



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР**

Урианхад  
Баатарын ОЮУНЖАРГАЛ  
Боржигон  
Даваагийн ХУЛАН  
Хангинаа Цэдэн  
Эрдэнэбатын ОЮУН-ЭРДЭНЭ  
Тольтон бургууд  
Чулуунтөмөрийн ОЮУНГЭРЭЛ

**ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН  
ОРОЛЦООТОЙ КОМПАНИУДЫН ЦАХИМ  
ХУУДАС ДАХЬ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД  
БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**



Мэргэжлийн индекс  
EO4130101

Бизнесийн удирдлагын  
**Мастерын зэрэг горилсон төсөлт судалгааны ажил**

Удирдсан  
Д.Гэрэлмаа /Ph.D./  
Г.Нарантунгалаг /MBA/  
Улаанбаатар. 2023



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР**



**Урианхад**  
**Баатарын ОЮУНЖАРГАЛ**  
**Боржигон**  
**Даваагийн ХУЛАН**  
**Хангинаа Цэдэн**  
**Эрдэнэбатын ОЮУН-ЭРДЭНЭ**  
**Тольтон бургууд**  
**Чулуунтөмөрийн ОЮУНГЭРЭЛ**

**ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН**  
**ОРОЛЦООТОЙ КОМПАНИУДЫН ЦАХИМ ХУУДАС**  
**ДАХЬ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**



Мэргэжлийн индекс

EO4130101

Бизнесийн удирдлагын

**Мастерын зэрэг горилсон төсөлт судалгааны ажил**

Удирдагч: ..... Д.Гэрэлмаа /Ph.D/

..... Г.Нарантунгалаг /MBA/

Улаанбаатар. 2023

## ГАРЧГИЙН ТОВЬЁОГ

МЭДЭГДЭХ ХУУДАС.....	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ .....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	v
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	v
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ .....	vii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	viii
УДИРТГАЛ .....	1
Судалгааны үндэслэл.....	1
Төсөлт судалгааны зорилго .....	3
Төсөлт судалгааны ажлын зорилт .....	3
Төсөлт судалгааны ажлаас хүлээгдэж буй үр дүн .....	4
Судлагдсан байдал .....	4
I БҮЛЭГ. ОНОЛЫН ТОЙМ.....	8
1.1 Засаглал, компанийн засаглалын онол, ойлголт .....	8
1.1.1 Засаглалын ойлголт .....	8
1.1.2 Компанийн засаглалын ойлголт .....	9
1.1.3 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглал.....	11
1.1.4 Компанийн сайн засаглал, түүний шинж .....	16
1.2 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тухай онолын ойлголт.....	19
1.3 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлал .	23
1.3.1 Компанийн засаглалын ил тод байдлын шалгуур ба үнэлгээний аргууд.	23
1.3.2 Цахим засаглал, цахим ил тод байдал ба үнэлгээний аргууд.....	26
1.3.3 Үнэлгээний аргачлалуудын харьцуулалт .....	34
1.3.4 Цахим хуудасны хэрэглэгчийн туршлагыг үнэлэх аргууд.....	36
II БҮЛЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	40
2.1 Монгол Улс дахь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын өнөөгийн байдал.....	40
2.2 Мэдээллийн нээлттэй, ил тод байдалтай холбогдох хууль болон журам .....	44
2.3 Нээлттэй ХК-д тавигдаж буй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт.....	47
III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....	50
3.1 Судалгааны хүрээ ба дизайн .....	50
3.2 Өгөгдөл цуглуулах ба шинжилгээ хийх арга .....	51

3.2.1	Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам .....	51
3.2.2	Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индекс .....	52
3.2.3	Хэрэглэгчийн туршлагыг үнэлэх нейро судалгаа .....	53
IV БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....		55
4.1	Журмын хүрээнд хийсэн үнэлгээний үр дүн.....	55
4.2	Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн үнэлгээний үр дүн .....	63
4.3	Хэрэглэгчийн туршлагыг үнэлэх нейро судалгааны үр дүн.....	66
4.4	Үнэлгээний үр дүнд хийсэн анализ.....	76
ДҮГНЭЛТ .....		78
САНАЛ ЗӨВЛӨМЖ .....		79
НОМЗҮЙ .....		i
ХАВСРАЛТ .....		i

## **МЭДЭГДЭХ ХУУДАС**

Энэхүү төсөлт судалгааны ажил нь бидний өөрсдийн бүтээл болохыг ийнхүү баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд тус сургуулийн номын сан судалгааны ажлыг нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Магистрантын нэр:

Баатарын ОЮУНЖАРГАЛ

Даваагийн ХУЛАН

Эрдэнэбатын ОЮУН-ЭРДЭНЭ

Чулуунтөмөрийн ОЮУНГЭРЭЛ

## **ТАЛАРХАЛ**

Энэхүү төсөлт судалгааны ажлыг гүйцэтгэхэд өөрийн мэдлэг, туршлагаа харамгүй хуваалцаж, мэргэжлийн үнэтэй заавар зөвлөгөө өгч, бүхий л хугацаанд удирдан чиглүүлж байсан СЭЗИС-ийн хүндэт багш, бидний ментор Д.Гэрэлмаа, Г.Нарантунгалаг болон Хүний зан төлөв, нейро судалгааны багтаа төсөлт судалгааны багийн зүгээс гүн талархал илэрхийлье.

Мөн төсөлт судалгааны ажлыг гүйцэтгэхэд тусалж дэмжсэн нийт багш, найз нөхөд, хамгийн үнэнч дэмжигч, туслагч болсон гэр бүлийнхэндээ гүнээ талархал илэрхийлье.

## ТОВЧ ХУРААНГУЙ

Сүүлийн 30 жил дэлхий дахинд өмч хувьчлал, төрийн өмчийг хувьд шилжүүлэх үйл явц хүчтэй өрнөж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани (цаашид “ТӨК” гэх)-ийн тоо буурах хандлагатай байгаа хэдий ч ТӨК нь эдийн засаг, санхүүгийн өсөлт болон хөгжлийн чухал тоглогч хэвээр байсаар байна. Ялангуяа даяарчлагдан буй дэлхий ертөнц дээр хязгаарлагдмал буй санхүү, ур чадвар, нөөцийн төлөөх өрсөлдөөн улам ихэссээр байгаа энэ цаг үед зарим орнуудын хувьд энэ өрсөлдөөнд байр сууриа эзлэх нэг арга хэрэгсэл нь ТӨК-аар дамжуулан энэхүү өрсөлдөөнд оролцох чиглэл ирээдүйд улам ихэснэ хэмээн үзэх хандлага гарч буй бөгөөд энэ нь ТӨК-ийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, тоо хэмжээ магадгүй цаашид ч өсөж болзошгүйг харуулж байна. Манай улсын хувьд ч ялгаагүй хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, байгалийн баялгийг хуваарилах, нийтийн эрх ашгийг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг ТӨК-ийг байгуулах гол үндэслэлээр стратегийн, нийтийн дэд бүтцийн хүрээнд болон бусад шаардлагатай салбарт нийт 105 ТӨК үйл ажиллагаа явуулж буй бөгөөд эдгээрийн нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөө өндөр байна. Гэвч эдгээр ТӨК-ууд байнга л эдийн засаг, ашгийн өгөөж багатай, өр төлбөр ихтэй, компанийн сайн засаглал бэхжээгүй, түүнд авлига, хууль бус байдал ихээр оршдог талаар мэдээ, мэдээлэл, тайлан дүгнэлтүүд олон улсын болон дотоодод хийгдсэн судалгааны үр дүнгүүдэд олонтоо дурдагдаж, улмаар компанийн үйл ажиллагааг ил тод байлгах, иргэдийн мэдэх эрхийг хангах, засаглалыг сайжруулах шаардлагыг иргэний нийгмийн зүгээс тавьсаар байгаа билээ.

Тэгвэл 2021 онд шинэчлэн батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар Мэдээлэл хариуцагчид хүлээлгэсэн үүргийн дагуу ТӨК нь хуульд заасан наад захын нээлттэй мэдээллийн шаардлагыг хангаж, мэдээллээ ил тод нийтлэх үүргийг хүлээсэн бөгөөд энэхүү хууль, журмын хэрэгжилт ямар түвшинд байгаа болон эдгээр компаниудын цахим хуудасны хэрэглээ нь хэрэглэгчийн туршлагын хүрээнд олон улсын аргачлалаар хэрхэн дүгнэгдэж болохыг дараах эх сурвалжуудыг ашиглан энэхүү төсөлт судалгааны ажлаар судаллаа. Үүнд:

- Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам;
- Олон улсын цахим засаглалын Rutgers аргачлал;
- Цахим хуудасны хэрэглэгчийн туршлагыг үнэлэх нейро судалгааны арга.

Судалгааны үр дүнд дараах гол дүгнэлтүүдийг өгөв.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нийтэд ил тод болгох мэдээллийн үнэлгээ нь дунджаар 31.37% буюу иргэний мэдэх эрхийг хангах хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
- Хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх тавцан буюу цахим хуудасны хэрэглэгдэхүйц байдал нь олон улсын цахим засаглалыг үнэлэх аргачлалын хүрээнд дунджаар 18.14% байгаа нь ТӨК-ийн цахим хуудас нь хэрэглэгчид таатай байх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

- Нейро судалгааны хүрээнд хэрэглэгч нь цахим хуудасны цэс, дэд цэс болон түүнд орсон мэдээллүүд нь уялдаатай байх, оруулж буй мэдээллийн чанар нь шууд харагдахуйц, тод байх, холбоотой цахим хуудасны мэдээллүүд мөн хайхад амар байх нөхцөлийг илүүд үзэж байна.
- ТОП-100 аж ахуйн нэгжид багтсан ТӨК нь мэдээллийн ил тод байдлын хүрээнд ч мөн тэргүүлэгч гэдгээ баталж чадахгүй байна.
- Нээлттэй болон хаалттай компаниудын мэдээллийн ил тод байдлын талаарх хууль, журмын хэрэгжилтэд томоохон ялгаа харагдахгүй байна.
- Компанийн бүтэц том, жижиг эсхүл үйл ажиллагаа нь ашигтай, ашиггүй эсэхээс үл хамааран хууль журмыг хэрэгжүүлэх боломжтой байна.
- Цахим хуудасны хэрэглэхэд тохиромжтой байдлын хувьд компанийн газар зүйн байршил, ашигт ажиллагаа зэрэг нь нөлөөлдөг байх магадлалтай.
- Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, төлөвшүүлэхэд мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангуулах явдал чухал болохыг нийгмийн бүхий л түвшинд хүлээн зөвшөөрч тэр хэрээр эрх зүйн орчныг сайжруулах, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг сүүлийн үед авч хэрэгжүүлсний үр дүнд компаниуд бүрэн бус ч мэдээллийг хуулийн шаардлагын хүрээнд оруулахыг хичээж, цахим хуудсанд холбогдох цэсийг үүсгэн, мэдээллүүдээ их, бага хэмжээгээр оруулж байна.

## **ТҮЛХҮҮР ҮГ**

Компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал, мэдээллийн нээлттэй байдал, засаглалын зарчим, компани, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үнэлгээний арга, аргачлал, цахим хуудасны үнэлгээ



## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Компанийн засаглалын онолууд.....	10
Хүснэгт 2. Компанийн засаглалын үндсэн зарчмууд .....	18
Хүснэгт 3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын онолын хандлагууд .....	22
Хүснэгт 4. Онлайн үйлчилгээний индекс (OSI).....	27
Хүснэгт 5. Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн үзүүлэлт, үнэлгээний оноо .....	28
Хүснэгт 6. Rutger-ийн цахим засгийн үнэлгээний оноо, тайлбар .....	29
Хүснэгт 7. Журмын дагуу цахим хуудсанд нээлттэй ил тод мэдээлэх мэдээллийн тоо.....	31
Хүснэгт 8. Журмын үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт .....	32
Хүснэгт 9. Стандартад заасан шалгуур үзүүлэлт.....	33
Хүснэгт 10. Хэрэглэгчийн туршлагыг хэмжих үзүүлэлт ба хэмжих аргууд.....	37
Хүснэгт 11. 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт .....	42
Хүснэгт 12. Нээлттэй мэдээллийн ангилал .....	46
Хүснэгт 13. Журмын дагуу нийтийн мэдээллийн ангилал, хэмжүүр .....	52
Хүснэгт 14. Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн онооны систем .....	52
Хүснэгт 15. Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн бүлэг, хэмжүүр .....	53
Хүснэгт 16. Журмын үнэлгээний ерөнхий үр дүн, мэдээллийн бүлэг болон компанийн төрлөөр.....	56
Хүснэгт 17. Үнэлгээний дүн, компаниар.....	56
Хүснэгт 18. Хамгийн өндөр ерөнхий оноотой компаниуд (Судалгааны багийн онооны систем) .....	57
Хүснэгт 19. Хамгийн өндөр ерөнхий оноотой компаниуд (Журмын онооны систем).....	58
Хүснэгт 20. Нээлттэй ХК болон хаалттай компаниуд.....	59
Хүснэгт 21. ТОП 100-д орсон болон нээлттэй болох компаниудын үнэлгээний харьцуулалт .....	59
Хүснэгт 22. Хамгийн өндөр оноотой болон хамгийн бага оноотой нийтийн мэдээлэл .....	60
Хүснэгт 23. Зургаан нээлттэй ХК-ийн мэдээлээгүй нийтийн мэдээллүүд.....	62
Хүснэгт 24. Олон улсын үнэлгээний ерөнхий үр дүн %, мэдээллийн бүлэг болон компанийн төрлөөр.....	64
Хүснэгт 25. Үнэлгээний дүн, компаниар.....	64
Хүснэгт 26. Хамгийн өндөр ерөнхий оноотой компаниуд (Судалгааны багийн онооны систем) .....	65
Хүснэгт 27. Нээлттэй ХК болон хаалттай компаниудын үнэлгээний харьцуулалт .....	66
Хүснэгт 28. ТОП 100-д орсон болон нээлттэй болох компаниудын үнэлгээний харьцуулалт .....	66
Хүснэгт 29. Нейро судалгаанд оролцогчийн гүйцэтгэх даалгавар .....	66
Хүснэгт 30. Өгөгдсөн даалгавар тус бүрийн мэдээллийн байршил, компани тус бүрээр... ..	67
Хүснэгт 31. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .....	67
Хүснэгт 32. Даалгавар гүйцэтгэсэн дундаж хугацаа, секунд .....	68
Хүснэгт 33. МИАТ ТӨХК-ийн цахим хуудсанд даалгавар гүйцэтгэсэн мэдээлэл .....	72
Хүснэгт 34. Монголын төмөр зам ТӨХК-ийн цахим хуудсанд даалгавар гүйцэтгэсэн мэдээлэл.....	72
Хүснэгт 35. Ганцаарчилсан ярилцлагын ерөнхий тойм.....	74
Хүснэгт 36. Нейро судалгааны үр дүнгийн нэгтгэл .....	75

## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хувийн өмчит болон төрийн өмчит компанийн ялгаатай байдал .....	12
Зураг 2. ТӨК-ийн үйл ажиллагаа явуулж буй салбараар .....	12
Зураг 3. ТӨК ба зах зээл .....	13
Зураг 4. Төрийн өмчит компани .....	14
Зураг 5. Сайн засаглалын 8 шинж .....	17
Зураг 6. Цахим ил тод байдлын индексийн бүлэг, дэд бүлэг, индикаторын хувийн жин ...	30
Зураг 7. Цахим ил тод байдлын индексийн үнэлгээний онооны тайлбар .....	30
Зураг 8. Үнэлгээний аргачлалуудын харьцуулалт .....	35
Зураг 9. Хэрэглэгчийн туршлагыг судлах зорилго ба хэмжих аргын хамаарал .....	38
Зураг 10. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоо .....	41
Зураг 11. ТӨК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч .....	41
Зураг 12. Судалгааны дизайны зураглал .....	51
Зураг 13. Нейро судалгааны дизайн .....	54
Зураг 14. Журмын үнэлгээний ерөнхий үр дүн, мэдээллийн бүлгээр .....	55
Зураг 15. Эхний таван компанийн үнэлгээний хувь болон мэдээллийн тоо .....	62
Зураг 16. Зургаан нээлттэй ХК-ийн үнэлгээний хувь болон мэдээллийн тоо .....	62
Зураг 17. Олон улсын үнэлгээний ерөнхий үр дүн, үзүүлэлтийн бүлгээр .....	63
Зураг 18. Нейро судалгаанд хамруулахаар сонгосон 2 компанийн цахим хуудас .....	67
Зураг 19. Даалгавар гүйцэтгэсэн дундаж хугацаа, секунд .....	68
Зураг 20. МИАТ ТӨХК-ийн цахим хуудаст компанийн бүтцийн зураглалын харагдах байдал .....	69
Зураг 21. Оролцогчдын даалгавар тус бүрийг гүйцэтгэсэн хугацаа, секундээр .....	69
Зураг 22. Оролцогчдын даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн хувь .....	70
Зураг 23. МТЗ ТӨХК-ийн цахим хуудасны Хүний нөөц цэс .....	71
Зураг 24. МИАТ ТӨХК-ийн цахим хуудасны Дүрэм, журам цэс .....	71
Зураг 25. Оролцогч шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл хайж буй байдал .....	72
Зураг 26. Сэтгэл хөдлөлийн хэмжилтийн дундаж хувь .....	73
Зураг 27. Оролцогчдын сэтгэл хөдлөлийн эерэг сөрөг байдлын дундаж үзүүлэлт .....	73
Зураг 28. МТЗ ТӨХК-ийн цахим хуудас дахь даалгавар 2-ын харагдах байдал .....	74

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Хуучин болон шинэ хуулийн мэдээллийн харьцуулалт .....	i
Хавсралт 2. Нээлттэй компанид тавигдаж буй мэдээллийн харьцуулалт .....	v
Хавсралт 3. Үнэлгээнд хамрагдсан компаниудын жагсаалт .....	xii
Хавсралт 4. Судалгаанд хамрагдсан компаниудын товч мэдээлэл.....	xiii
Хавсралт 5. Компанийн үнэлгээнд хамаарахгүй гэж үзээд хассан мэдээлэл.....	xix
Хавсралт 6. Журмын үнэлгээний авбал зохих онооны харьцуулсан хүснэгт.....	xx
Хавсралт 7. Нейро судалгаанд оролцогчдын мэдээлэл ба үр дүн.....	xxix
Хавсралт 8. Журам болон Rutger-ийн үнэлгээний харьцуулалт .....	xxxii
Хавсралт 9. Rutger-ийн цахим засаглалын индексийн шалгуур асуулт, үнэлгээний оноо .....	xxxii

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>ААТҮГ</b>	Аж Ахуйн Тооцоотой Үйлдвэрийн Газар
<b>АЗЗА</b>	Авто Зам Засвар Арчилгаа
<b>АНУ</b>	Америкийн Нэгдсэн Улс
<b>АСЕАН</b>	Зүүн Өмнөд Азийн Бүс Нутгийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
<b>ДНБ</b>	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
<b>ЗГ</b>	Засгийн Газар
<b>ЗГХЭГ</b>	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
<b>КтХ</b>	Компанийн тухай хууль
<b>МИТББМАЭтХ</b>	Мэдээллийн Ил Тод Байдал ба Мэдээлэл Авах Эрхийн тухай Хууль
<b>МХХТ</b>	Мэдээлэл Харилцаа Холбооны Технологи
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэсний Байгууллага
<b>ОУСК</b>	Олон Улсын Санхүүгийн Корпораци
<b>ОУХА</b>	Олон Улсын Хөгжлийн Агентлаг
<b>ОУЦХБ</b>	Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага
<b>СЭЗИС</b>	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
<b>SOE</b>	State-Owned Enterprises/ Төрийн өмчит компани
<b>ТӨК</b>	Төрийн Өмчит Компани
<b>ТӨОК</b>	Төрийн Өмчийн Оролцоотой Компани
<b>ТӨҮГ</b>	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
<b>ТӨХК</b>	Төрийн Өмчит Хувьцаат Компани
<b>ТӨХХК</b>	Төрийн Өмчит Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
<b>ТУЗ</b>	Төлөөлөн Удирдах Зөвлөл
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>УТҮГ</b>	Улсын Төсөвт Үйлдвэрийн Газар
<b>УУХҮЯ</b>	Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яам
<b>ХЭ</b>	Хувьцаа Эзэмшигч
<b>ЭЗХАХБ</b>	Эдийн Засаг Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага

## УДИРТГАЛ

### Судалгааны үндэслэл

Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал болон дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй өнөө үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшил нь хөгжлийн хурдасгуур, цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх гол хүчин зүйл болж байна (Цахим Үндэстэн 2022-2027, Дунд хугацааны зорилтот хөтөлбөрөөс).

Монгол Улс энэхүү дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага болж буй цахим шилжилтэд хөл нийлүүлэн алхах, хууль тогтоомж, төр засгийн бодлогын хүрээнд бүхий л түвшинд цахимжилтыг нэмэгдүүлэх чиглэлээр олон хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж буй бөгөөд тухайлбал Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор Цахим засаг 1 үндэстний хөтөлбөр, ЦХХХЯ-ны сайдын 2022 оны №А/24 тоот тушаалаар “Цахим Үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027) зэрэг олон бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг дурдаж болно.

ЦХХХЯ, ҮСХ-той хамтран “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний түүвэр судалгаа”-г Үндэстний хэмжээнд анх удаа хийсэн бөгөөд энэхүү судалгаагаар нийт өрхийн 80% нь интернэт хэрэглэж, 2021 оны байдлаар нийт иргэдийн 97.6% нь гар утас хэрэглэдэг, үүнээс ухаалаг гар утасны хэрэглээ 84.7% буюу ОУЦХБ-ын 2020 оны судалгаагаар интернэт ашигладаг хүн амын нэвтрэлтийн түвшин 90 хувь (Цахим үндэстэн баримтлах чиглэл, 2022)-д хүрчээ. Ийнхүү иргэдийн дунд цахим хэрэглээ, цахим дэд бүтэц хурдацтай нэмэгдэж, улмаар энэхүү хэрэглээгээр дамжуулан төрийн үйлчилгээ, мэдээллийг цахимаар хурдан шуурхай, нээлттэй, хүртээмжтэй авах боломж нэг талаас бүрдэж байгаа ч нөгөө талаас энэхүү үйлчилгээ, мэдээллийг цахим суваг, арга хэрэгслийг ашиглан иргэдэд хүргэх төрийн байгууллага, ТӨК-ийн цахим мэдээллийн түвшин, бэлэн байдал нь ямар хэмжээнд байгаа нь сонирхолтой.

УИХ, ЗГ-аас төрийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, нийтийн мэдээллийг ил тод байлгах олон баримт бичгийг батлан гаргаж, бодлогоор дэмжин ажиллаж байгаа бөгөөд тухайлбал:

- Төрийн байгууллагын цахим хуудас дахь мэдээллийн ил тод байдлыг хангах зорилготой “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг ЗГ-ын 2009 оны №143 дугаар тогтоолоор (цаашид “Тогтоол” гэх) батлан гаргасан ба тус тогтоол нь бүхлээрээ 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба, мэдээлэл авах эрхийн хууль (МИТББМАЭтХ, 2011)-ийн 2-р бүлэг болж тусгагдсан байна;
- Төрийн байгууллагын төсөв, санхүү, худалдан авалтын үйл ажиллагааг ил тод болгох, иргэд эдгээр мэдээллийг тусгай цахим хуудсаар дамжуулан нээлттэй авах боломжийг хангах зорилгоор 2014 онд Шилэн дансны тухай хуулийг баталсан;
- УИХ-аас 2020 оны №52 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” батлагдсан бөгөөд 5-р бүлэг ЗАСАГЛАЛ-ын асуудлыг тухайлан дурдсан ба түүнд зааснаар: “Зорилго 5. Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт

бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно” гэжээ;

- УИХ-аас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг шинэчилсэн найруулгыг баталж, 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн;
- ЗГ-ын 2021 оны №106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зургаан зорилтын нэг “Төрийн бүтээмжийн сэргэлт”-дээ ТӨК-дын засаглалыг сайжруулах зорилтыг багтаасан зэрэг болно.

Гэвч эрх зүйн баримт бичгийн хүрээнд ийнхүү зохицуулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг үүрэгдүүлж буй боловч ТӨК-ийн эрх зүйн хэлбэр тодорхойгүй маргаантай, гаргаж буй шийдвэр, гэрээ хэлцэл баримт бичгийг ил тод мэдээлдэггүй, ТӨК-д нээлттэй, ил тод байдал дутагдсанаас хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт ихсэж, удирдлагын хувьд ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн хяналтыг хэрэгжүүлэх нэрийн дор ТӨК-ийн бизнесийн үйл ажиллагаанд төр хэт оролцох, компанийн сайн засаглалын тогтолцоо бүрдэх нөхцөл бодит байдал дээр хангагдаагүй буюу хууль тогтоомж, бодлогын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байсаар байгааг Хөгжлийн банкны нээлттэй хэлэлцүүлэг, нүүрсний “off-take” гэрээ, “40 их наяд нүүрсний хулгайн хэрэг” зэрэг олон дуулиант хэргүүдээс харж болохоор байна. Түүнчлэн Монгол Улс “Авлигын төсөөллийн индекс 2022” үзүүлэлтээр 180 орноос 116 дугаарт жагссан буюу 33/100 оноогоор үнэлэгдсэн нь сүүлийн 5 жилийн хамгийн муу үзүүлэлт болсон (Corruption perceptions index, 2022), ЗГХЭГ-ын харьяанд байгаа 17 компаниас ашигтай 3, ашиггүй 13, ЭХЯ-ны харьяаны 26 компаниас ашигтай 8, ашиггүй 18, УУХУЯ-ны мэдэлд буй 3 компанийн 2 нь ашиггүй гэх мэтчилэн харвал нийт 106 компаниас 50 хүрэхгүй хувь нь ашигтай ажилладаг ба өгөөж нь ердөө 1% байгаа зэрэг нь төрийн өмчит компаниудын үр өгөөж туйлын хангалтгүй байгааг харуулж байна (ТӨБЗГ, 2023). Энэ бүгдээс төрийн байгууллагууд, ТӨК-ийн хувьд засаглалын хямрал нүүрлэсэн, сайн засаглалын зарчмуудын хэрэгжилт алдагдсан хэмээн дүгнэж болохоор байгаа бөгөөд сайн засаглалын тулгийн 3 чулуу нь хариуцан тайлагнах байдал (accountability), ил тод байдал (transparency), нээлттэй байдал (openness) хэмээн судлаачид тодорхойлж байна. Тэгвэл энэхүү сайн засаглалыг хангах хамгийн эхний буюу нийтэд харагдахуйц, мэдэгдэж болохуйц арга хэрэгсэл нь цахим хөгжлийн эринд амьдарч буй энэ цаг хугацаанд тухайн байгууллагын цахим хуудас болох бөгөөд цахим хуудас дахь мэдээллийн ил тод, нээлттэй байдал нь түүгээр дамжуулан ТӨК-ийн засаглалын ил тод, нээлттэй, ёс зүйтэй байдлыг дээшлүүлэх, төрд итгэх иргэдийн итгэлийг сайжруулах, мэдээллийг иргэдэд хүртээмжтэй болгох, мэдээлэл олж авах орон зай, цаг хугацааны хамаарлыг багасгах, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, зэрэг асуудлуудыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээнд цахим сүлжээнд суурилсан системийг өргөнөөр нэвтрүүлэх арга хэмжээг авах боломжийг сайжруулна гэж үзэж байна.

Иймд, энэхүү төсөлт судалгааны ажлын хүрээнд бид ЗГ-ын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн №244 дүгээр тогтоолын дагуу батлагдсан “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн

жагсаалт”-д багтсан 25 ТӨК болон “Үндэсний ТОП-100 аж ахуйн нэгж”-д багтсан ТӨК-ийн цахим хуудас дахь мэдээллийн ил тод, нээлттэй байдалд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон холбогдох журмын аргачлал, олон улсын цахим засаглалын Rutgers аргачлал болон цахим хуудасны хэрэглэгчийн туршлагыг үнэлэх нейро судалгааны аргаар үнэлгээ хийж, тус компаниуд нь нээлттэй байдлын хүрээнд хуульд заасан шалгуурыг хангаж буй эсэх, мөн цахим хуудас дахь мэдээллийн байдал нь түүнийг хэрэглэгч, иргэдийн зүгээс ашиглахад хэр ойлгомжтой, хүртээмжтэй, ашиглагдахуйц байгаа эсэхэд үнэлгээ өгөхийг зорив. Үнэлгээнд нийт нээлттэй хувьцаат компани болох жагсаалтад орсон 25 компани болон Топ-100 аж ахуйн нэгжид багтсан 15 ТӨХК багтсан болно.

### **Төсөлт судалгааны зорилго**

Энэхүү төсөлт судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын ТӨК-ийн цахим хуудас дахь мэдээллийн ил тод байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон түүнийг дагалдан гарсан Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмын үзүүлэлтүүдийн дагуу үнэлэх, мөн олон улсын цахим засаглалын үнэлгээний аргачлал болох Rutgers судалгааны аргачлалын хүрээнд болон цахим хуудасны хэрэглэгчийн туршлагыг үнэлэх нейро судалгааны аргаар сонгож авсан ТӨК-ийн цахим хуудсыг үнэлж, цахим хуудасны аюулгүй байдал, хэрэглэгдэхүйц байдал, агуулга, цахим хуудсаар үзүүлж буй үйлчилгээний төрлүүд, иргэдийн оролцох боломж зэрэг үзүүлэлтүүдийг шинжлэн дүгнэх бөгөөд судалгааны үр дүнд сонгосон ТӨК-ийн нээлттэй байдал хэрхэн хангагдаж буй болон хуулийн хэрэгжилтэд дүгнэлт өгч, мөн олон улсын аргачлалын хүрээнд цахим хуудсыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилго тавин энэхүү төсөлт судалгааны ажлаа хийлээ.

### **Төсөлт судалгааны ажлын зорилт**

Төсөлт судалгааны ажлын зорилгын хүрээнд бид дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. ТӨК-ийн эрх зүйн хэлбэр, тэдгээрийн тоо, төрийн хувьцаа эзэмшлийн байдлыг тоймлох;
2. Монгол Улсад хэрэгжиж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан журмын хүрээнд компаниудын цахим хуудсанд үнэлгээ хийх;
3. Мэдээллийн ил тод байдлыг үнэлэх олон улсын индексийг судалж үнэлгээ хийн харьцуулах;
4. Цахим хуудасны ойлгомжтой, хүртээмжтэй байдалд нейро судалгааны аргаар үнэлгээ хийх;
5. Үнэлгээний үр дүнд үндэслэн мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх тухай санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах.

### **Төсөлт судалгааны ажлын бүтэц**

Энэхүү төсөлт судалгааны ажил нь үндсэн 4 бүлэг, дүгнэлт, санал зөвлөмж, хавсралт, номзүй гэсэн бүтэцтэй байна.

## **Төсөлт судалгааны ажлаас хүлээгдэж буй үр дүн**

Энэхүү төсөлт судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨК-ийн цахим хуудас дахь мэдээллийн ил тод, нээлттэй байдал хуулийн шаардлагыг хэрхэн хангаж байгаа болон олон улсын цахим хуудасны үнэлгээний аргачлалыг ашиглан цахим хуудасны зохистой байдлын түвшинг үнэлж гаргана. Мөн хэрэглэгч талаас тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хэр нийцтэй, ашиглагдахуйц байдалд нейро судалгааны аргаар түүвэрлэн үнэлж, хийгдсэн судалгаатай харьцуулна. Эдгээр үнэлгээнд тулгуурлан санал зөвлөмж гаргаснаар ТӨК-ийн цахим хуудас дахь мэдээллийн ил тод нээлттэй байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулна.

### **Судлагдсан байдал**

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын ач холбогдлын тухай ойлголтууд нь засаглалын мэдлэгийн нэгэн томоохон хэсэг буюу нийтэд судлагдсан судлагдахууны хэсэг болсон бөгөөд энэ талаарх маш олон тооны судалгааны ажил, судлаачийн бүтээлүүд дэлхий даяар нийтлэгджээ.

Chow болон Wong-Boren нар Voluntary Financial Disclosure by Mexican Corporations, 1987 судалгааны ажлаараа нар сайн дурын ил тод байдлын талаарх тодорхойлогч хүчин зүйлүүдийг олж илрүүлэх эртний оролдлогуудын нэгийг Мексик улсын хуулийн этгээд болон тэдгээрийн хэмжээний загварыг ашиглан хийсэн бөгөөд энэхүү судалгаагаар хуулийн этгээдийн хэмжээ болон ил тод байдал нь эерэг харилцаа хамааралтай болохыг олж тогтоосон.

Durnev болон Kim нар Corporate Governance of SOEs and Performance in Transition Countries. Evidence from Lithuania, 2005 судалгааны ажлаараа өсөлтийн өргөн боломжтой болон гадаад санхүүжилтийн өндөр хэрэгцээ бүхий компаниудын хувьд засаглалын хамгийн сайн хэлбэр болон ил тод байдлын практикуудыг сонгодог хэмээн тогтоосон байна. Ялангуяа энэ нөхцөл нь эрх зүйн хамгаалалт султай улс орнуудад хамгийн үнэн бодитой байдаг. Ийм улсуудад оршин буй компаниудын хувьд эрх зүйн тодорхойгүй байдлын улмаас үүсэж болох компани болон боломжит хөрөнгө оруулагчдын хоорондын цоорхойг ил тод байдлыг сайжруулах практикийг сайжруулах замаар нөхөх гүүр болгож ашигладаг хэмээн бичжээ.

Hanifa болон Rashid нар The Influence of Corporate Governance and Firm Characteristics on the Timeliness of Corporate Internet Reporting By Top 95 Companies in Malaysia, 2005 судалгаандаа Малайзын 95 компанийн загварыг ашиглаж ил тод байдал нь компанийн хэмжээ, өсөлт, компанийн хэтийн төлөв болон өмчлөлийн төвлөрөл хооронд эерэг харилцаа байгаа болохыг тодорхойлсон. Мөн судлаачид нь гаднын хөрөнгө оруулагч бүхий компани нь хол зайнд буй хөрөнгө оруулагчдаа мэдээллээр хангах хэрэгцээнээс үүдсэн илүү нээлттэй, ил тод байх шаардлага үүсдэг болохыг баталсан.

Danila Djokic болон Mojca Duh нар Measuring Transparency of the Corporate Governance in Slovenia, 2015 судалгааны ажлаараа компанийн засаглалыг үнэлэх SEECGAN индексийн дагуу Словенийн хөрөнгийн биржид бүртгэлтэй 22 компанийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын түвшнийг үнэлсэн бөгөөд судалгааны үр дүнд тус улсын хөрөнгийн бирж дээр үйл ажиллагаа явуулж буй нээлттэй компаниудын мэдээллийн ил тод байдлыг түвшин харьцангуй сайн байгаа боловч нарийвчилсан үнэлгээгээр мэдээллийн чанар болон



тэдгээрийг ил болгож буй хэлбэр нь харилцан ялгаатай болохыг тодорхойлж, цаашид сайжруулах зөвлөмжийг гаргажээ.

Trabelsi, Labella болон Dumantier (2008) нар мөн Канадын компаниудын жишээ ашиглан ил тод байдлыг тодорхойлогч хүчин зүйлүүдийг илрүүлсэн бөгөөд судалгааг компаниудын цахим хуудсаар дамжуулан сайн дурын үндсэн дээр хийсэн байна. Судалгаагаар засаглалын ил тод байдал нь хувьцааны хөрвөх чадвар, хүлээгдэж буй гүйцэтгэл болон түүний R&D зарцуулалтын түвшинтэй эерэг хамааралтай болохыг илрүүлсэн ба зах зээлийн өрсөлдөөний хувьд сөрөг нөлөөтэй байгааг тодорхойлсон.

Mine Aksu and Arman Kosedag нар Transparency and disclosure scores and their determinants in the Istanbul stock exchange, 2006 судалгааны ажлын хүрээнд Истанбулын Хөрөнгийн бирж дээр гарсан компаниудын шинж чанарт заавал биелүүлэх болон сайн дурын шаардлагууд нь ил тод байдлын чанарыг сайжруулахад нөлөөлж байгаа эсэхийг тодорхойлох шинжилгээ хийсэн. Тэдгээрийн судалгаагаар олон улсын санхүүгийн тайлагналын стандартыг заавал хэрэгжүүлснээр Туркийн компаниудын хувьд ил тод, нээлттэй байдлыг сайжруулахад эерэг нөлөөг үзүүлсэн болохыг илрүүлсэн байна.

Patel, S., & Dallas, G нар Transparency and disclosure: Overview of methodology and study results United States, 2002 судалгааны ажлаараа Standard&Poors-н судалгааны арга зүйг ашиглан АНУ-ын нээлттэй 500 компанийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээг хийж, тэдгээрийн жилийн тайлангаа ил тод мэдээлж буй байдал болон түүнд агуулж буй мэдээллийн төрлүүдийг судалсан бөгөөд хуулиар шаардсан хэмжээнээс илүү мэдээллийг сайн дурын үндсэн дээр нээлттэй болгож буй байдал нь тухайн компанийн зах зээл дээрх үнэлгээг сайжруулах шилдэг туршлага болж байгааг тодруулсан байна.

Sasha Arsov болон Vesna Bucevska нар Determinants of transparency and disclosure-evidence from post-transition economies, 2017 судалгаагаар хуучин социалист орнуудын компаниудын компанийн сайн засаглалыг хэрэгжүүлж буй зан төлөвийн байдалд дүн шинжилгээ хийсэн бөгөөд Хрват, Македон, Слован, Серб зэрэг хуучин социалист орнуудын 145 компанийн мэдээллийг ашиглан Standard&Poors-н мэдээллийн ил тод байдлын үнэлгээний судалгааны арга зүйг ашиглан хийсэн байна.

Mendes-Da-Silva болон Onusic нар Corporate E-Disclosure Determinants: Evidence from the Brazilian Market, 2014 судалгааны ажлаараа компанийн шинж чанар болон вебд суурилсан ил тод байдал хоорондын холбоог шинжилсэн бөгөөд компанийн хэмжээ болон компанийн засаглалын хамгийн шилдэг практикийг хэрэгжүүлэх нь төсөөлж байсны дагуу ил тод байдалд эерэг нөлөө үзүүлж байгааг баталсан ч, хөрөнгийн зах зээлд гарах компанийн хугацааны хувьд сөрөг нөлөөтэй байгааг тодорхойлсон байна.

Манай улсын хувьд одоогоор мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг үнэлэх, тэр дундаа ТӨК-ийн засаглалын байдлыг үнэлэх хүрээнд хэд хэдэн судалгааны ажлууд хийгдсэн бөгөөд тэдгээрээс түүвэрлэн дор оруулав.

- АНУ-ын Хөгжлийн агентлагийн хийсэн “Монголын компанийн засаглалын судалгааны тойм” 2008;
- Дэлхийн банкнаас хийсэн “Стандарт, дүрэм журмын мөрдөлтийн байдалд өгсөн үнэлгээний тайлан” 2009;

- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Азийн хөгжлийн банкнаас хийсэн “Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах нь” 2009;
- СЭЗИС-ийн багш Т.Цэнд-Аюушийн “Монголын компанийн засаглалыг сайжруулах арга замууд” Бизнесийн удирдлагын ухааны докторын зэрэг горилсон бүтээл 2012;
- Удирдлагын академийн “Монголын компанийн засаглалын төрх, хандлага” 2012;
- ОУСК, Компанийн засаглалын хөгжлийн төвийн хийсэн “Компанийн засаглалын үнэлгээний тайлан” 2013;
- Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн “Монгол Улсын компанийн засаглалын үндэсний тайлан (жил бүр);
- Нээлттэй нийгэм хүрээлэн, Уул уурхайн яамны “Төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийн засаглалын өнөөгийн түвшин” 2014;
- Нээлттэй нийгэм хүрээлэн, Эрчим хүчний яамны “Төрийн өмчит эрчим хүчний компаниудын засаглалын үнэлгээ” 2015;
- Удирдлагын академийн “Төрийн өмчит хувьцаат компанийн засаглал төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлөх нь судалгааны тайлан” 2017;
- IRIM Судалгааны хүрээлэнгийн “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал: Мониторингийн тайлан” 2011 оноос хойш;
- ШУТИС-ийн БУХС-ийн Эрнэст Ученна Нүэкэгийн “Хувьцаат компанийн сайн дурын мэдээллийн тайлагналын нээлттэй байдал ба байгууллагын шинж төлөвийн хамаарлын судалгаа” докторын диссертаци;
- СЭЗИС-ийн багш Т.Цэнд-Аюушийн “Монголын компанийн засаглалын нээлттэй байдлын индексийн шинжилгээ” эрдэм шинжилгээний нийтлэл;
- СЭЗИС-ийн оюутан Н.Баясгалангийн “Төрийн өмчит компаниудын мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг үнэлэх нь” дипломын ажил 2018;
- СЭЗИС-ийн оюутан С.Насанжаргал нарын “Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдлыг үнэлэх нь” дипломын ажил 2019 зэрэг болно.

Харин бидний судалгаа чиглэж буй **цахим хуудас дахь** мэдээллийн ил тод байдлын чиглэлээр дагнан хийгдсэн судалгааны ажил, туурвигдсан бүтээл цөөн байгаа бөгөөд дээр дурдсан судалгааны ажлуудаас онол, судалгааны арга зүйн болон туршлагын хүрээнд энэхүү судалгааны ажилд түлхүү ашигласан эх сурвалжуудын хувьд:

Нээлттэй нийгэм хүрээлэн, Уул уурхайн яамнаас захиалан Д.Байлхүү нарын “Төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийн засаглалын өнөөгийн түвшин” 2014 судалгааны ажлаар Монгол Улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг төрийн өмчит 9 компанийг сонгон авч засаглалын өнөөгийн түвшнийг тодорхойлсон. Үнэлгээний аргачлал боловсруулахдаа ЭЗХАХБ-ийн “Компанийн засаглалын зарчим (1999, 2004) болон “Төрийн өмчийн компанийн засаглалын гарын авлага (2004), ОУСК-аас гаргасан Компанийн засаглалын гарын авлага (2004, 2008), АНУ-ын ОУХА-ын төрийн өмчийн компанийн засаглалын асуулга (2011), Компанийн засаглалын рейтинг тогтоох Standard & Poor’s-ийн аргачлал (2000), АСЕАН-ны Компанийн засаглалын шалгуур үзүүлэлт (2004) зэрэг материалыг ашигласан бөгөөд судалгааны ажлын үр дүнд ТӨК-ийн засаглалын ерөнхий үнэлгээ хэт доогуур түвшинд буюу дунджаар 28%, компанийн үйл ажиллагааны талаарх

мэдээллийг ил тод, нээлттэй болгох талаар гарсан хуулийн заалт хэрэгжихгүй байгаа талаар дүгнэжээ.

IRIM Судалгааны хүрээлэнгийн “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал: Мониторингийн тайлан” 2011 оноос хойш хийгдэж буй судалгаа бөгөөд тус судалгаа нь хамрах хүрээний хувьд төрийн байгууллагууд болох яам, агентлаг, 21 аймгийн цахим хуудсыг хамруулдаг. Судалгааны арга зүйн хувьд өөрсдийн боловсруулсан аргачлалын дагуу яам, агентлагийг 55, аймаг, дүүргийг 59 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байна.

Эдгээр олон улсад болон манай улсад хийгдсэн судалгааны ажлын үр дүн, дүгнэлтээс нэгтгэвэл мэдээллийн ил тод, нээлттэй байдал нь компанийн сайн засаглалыг бүрдүүлэх гол хүчин зүйл болохыг тодорхойлсон бөгөөд ийнхүү мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангахад тухайн улсын хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар, ил тод байдлын шилдэг туршлага, олон улсын стандартуудыг нэвтрүүлснээр амжилтад хүрэх боломжтой талаар нийтлэг байдлаар тодорхойлжээ.

## I БҮЛЭГ. ОНОЛЫН ТОЙМ

Энэ бүлэгт ТӨК-ийн мэдээллийн ил тод байдлын тухай ойлголт, олон улсад тодорхойлсон, судлагдсан байдал, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг үнэлэх арга аргачлалын талаар хамруулан оруулсан болно.

### 1.1 Засаглал, компанийн засаглалын онол, ойлголт

#### 1.1.1 Засаглалын ойлголт

“Засаглал”, “сайн засаглал” гэх нэр томъёо улам бүр түгээмэл болж, эдгээр ойлголтыг судлах, тодорхойлох хүрээнд олон судалгаа, нийтлэл, олон улсын байгууллагын баримт бичгүүд гарсаар байна. Олон улсын донор, банк, санхүүгийн байгууллагууд нь бодлого шийдвэр гаргах үнэлгээнд “сайн засаглал”-ыг хэрэгжүүлсэн байх гэсэн үзүүлэлтийг нэг гол үнэлгээний хэсэг болгох нь улам бүр ихэссэн. Засаглал хэмээх нэр томъёо нь тодорхой зорилгодоо хүрэх эсвэл тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх горимтой холбоотой ойлголт (Talat.A, Mian.S, 2014), Засаглал нь улс орны бүхий л түвшинд улс орны ажил хэргийг удирдан явуулах улс төр, эдийн захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлэх явдал бөгөөд энэ нь иргэд, тэдний бүлгүүд ашиг сонирхол, өөр хоорондын ялгаатай байдлаа илэрхийлэх, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх механизм, үйл явц, харилцаа, зохион байгуулалтын бүтцээс бүрдэнэ (UNDP, 2012), Улс орны эдийн засаг, улс төр, нийгмийн байгуулалтаар дамжуулан эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа арга зам (World Bank’s PRSP Handbook) хэмээн судлаачид болон олон улсын байгууллагуудын зүгээс янз бүрээр тодорхойлсон байна.

“Засаглал” хэмээх үг нь гарал үүслийн хувьд Латин хэлний “*gubernare*”, Грек хэлний “*kybernan*” хэмээх үгнээс гарал үүсэлтэй бөгөөд эдгээр нь чиглүүлэх, зааварлах, удирдах гэсэн утгатай байна (Talat.A, Mian.S, 2014).

“Засаглал” хэмээн үг нь нэр томъёоны хувьд: **Governance: Засаглал** *noun* (glvəˈnəns)

**Collins Dictionary:** The governance of a country is the way in which it is governed.

**Орчуулга:** Аливаа улс орны засаглал нь тухайн улс орныг удирдаж байгаа арга барил юм.

**Cambridge Dictionary:** The way that organizations or countries are managed at the highest level, and the systems for doing this.

**Орчуулга:** Байгууллага эсвэл улс орныг хамгийн дээд түвшинд удирдах арга зам болон түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо.

Монгол хэлэнд энэхүү нэр томъёог хэрхэн тайлбарлаж байгааг тодорхойлж үзвэл:

**засаг** *ᠵᠠᠰᠢᠭ* **Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь:** Улсын байгуулалтын захирч удирдах хэлбэр, дээд газар, ямар нэгэн юмыг засаж сайжруулах буюу мөрдөн журамлах тухайн арга явууллага

**Монгол хэлний журамласан толь:**

**Засаглал:** Засаглах үйлийн нэр; **Засаглах:** төр барих, засан тохинуулах; **Засагла:** яллан шийтгэх; **Засаг:** төр, захиргаа, цааз.

Монгол хэлний тайлбар толиудаас харвал засаглал гэдэг нэр томъёог төртэй холбон ойлгож ирсэн байдал ажиглагдаж байна. Хэдий тийм боловч сүүлийн үеийн дэлхийн хөгжлийн чиг хандлагаар засаглал хэмээх ойлголтыг дан төртэй холбохоо больж хувийн хэвшил, сайн дурын байгууллага, төрийн өмчит компани гэх мэт институтийн бүх түвшинд холбож үздэг болсон бөгөөд дээр тодорхойлолтуудаас нэгтгэн товч тодорхойлолт хийвэл *“Төр, улс орон, байгууллагын үйл ажиллагааг удирдан сайжруулах арга зам, арга барил юм”* хэмээж болохоор байна.

### 1.1.2 Компанийн засаглалын ойлголт

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 3.1-т зааснаар “Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ” (Компанийн тухай хууль, 2011) хэмээн тодорхойлсон. Компани нь аливаа улс орны хөгжил, эдийн засаг, хүн амын ажил хөдөлмөр эрхлэлтийн түвшинд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг аж ахуй эрхлэх хэлбэр бөгөөд 1992 оны Үндсэн хуулиар “төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” (Монгол Улсын Үндсэн хууль, 5 дугаар зүйл) хэмээн заасан.

Компани буюу корпораци хэмээх байгууллагын үүсэл хөгжлийг дундаж зууны үеэс эхлэлтэй хэмээн үздэг бөгөөд төрөөс тодорхой институтуудад тухайлбал хотууд, их сургууль, сүм гэх мэтэд тусгай эрх зүйн статус олгох болсноор хэрэглэгдэж эхэлсэн хэмээн бичсэн байна. 18-19-р зуунд Хойд Америк болон Европын орнуудад бизнесийн корпорациуд ихээр байгуулагдаж эхэлсэн бөгөөд үйл ажиллагаа нь ихэвчлэн далайн тээврийг санхүүжүүлэх, сувгууд барих, төмөр зам барих гэм мэт цөөн хүрээнд чиглэж байв. 20-р зуунаас олон улс орнуудад компани, корпорациудад “ашиг олохын тулд бизнес эрхлэх” гэх мэт ерөнхий зорилго бүхий компанийн дүрмийг олгох болжээ. Өөрөөр хэлбэл манай улсын хуулиар ч тэр, онолын анхны ойлголтоороо ч тэр компани бол ашиг олох, баялаг бүтээх зорилготой бүтэц юм хэмээн тодорхойлж байсан байна. Харин сүүлийн үеийн судалгааны онол, дэлхийн хөгжлийн чиг хандлагаар компани гэдэг бол зөвхөн ашиг олох зорилго бүхий бус нийгмийн хариуцлагатай байх, тогтвортой хөгжлийн зорилтыг хангах, Морал Хазардын асуудлыг анхаарч үзэх зэргээр үйл ажиллагаагаа компанийн үйл ажиллагаанд өртөж буй оролцогч талуудын ашиг сонирхолд нийцүүлэх, тэдгээрийн сонирхлыг зүй зохистой хангах буюу компанийн засаглалыг хэрэгжүүлэх гэдэг шалгуураар үнэлэх хандлага түгээмэл болж байна. (Stanford University press, n.d ).

Сүүлийн 30 жилд өрнөсөн хувьчлал, глобалчлал, томоохон корпорациудын засаглалын дуулиан, гадаад хөрөнгө оруулалтын өсөлт, 21-р зууны бизнесийн томоохон өрсөлдөөн зэрэг нь компанийн засаглалыг академик түвшинд улам бүр судлах, түүнийг тодруулах нөхцөлийг бий болгожээ. Хэдий тийм боловч компанийн засаглал нь хууль, бизнесийн ёс зүй, нягтлан бодох бүртгэл, санхүү, байгууллагын зан төлөв, бизнесийн удирдлага, эдийн засаг, улс тар гээд өргөн хүрээний олон салбарыг хамарсан сэдэв болж өргөжсөн учраас олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэг л тодорхойлолт байхгүй юм (Соломон, 2007).

Манай улсын хувьд ч тэр засаглалын ойлголтыг хэдийгээр Монгол хэлний тайлбар тольд төрийн удирдлага, арга барилтай холбож тайлбарласан байдаг хэдий ч сүүлийн үеийн дэлхийн хөгжлийн хандлага ойлголтоор уг нэр томъёог ойлгон, хэрэгжүүлж ирж буй бөгөөд тухайлбал Санхүүгийн зохицуулах хорооноос Компанийн засаглалын кодексийг 2022 онд шинэчлэн баталсан бөгөөд тус кодекс дурдсанаар “Компанийн засаглал нь компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах тогтолцоо бөгөөд байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо юм” хэмээн тодорхойлжээ.

Олон улсын хэмжээнд компанийн засаглал гэдгийг олон орны энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, судлаач, эрдэмтэд янз бүрээр тодорхойлон томъёолсон бөгөөд “Байгууллагын засаглал гэдэг нь байгууллагын менежмент, ТУЗ, ХЭ-д болон бусад оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагааны цогц юм. Байгууллагын засаглал нь зорилго, түүнд хүрэх арга замыг тодорхойлж, гүйцэтгэлийг хянах бүтцийг бий болгодог” (OECD, р. 11), “засаглал нь байгууллагыг үр дүнтэй удирдах, үйл ажиллагааг нь зөв зохион байгуулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хамарсан өргөн ойлголт бөгөөд байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын зохистой харьцааг тогтоодог тогтолцоо юм” (ERC, компанийн засаглалын тухай, 2018), “байгууллагын засаглал гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд хяналт болон зохистой удирдлагыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох, улмаар тасралтгүй боловсронгуй болгох үйл явц бөгөөд энэ асуудалд холбогдох бүх талын харилцаа холбоонуудаар тодорхойлогдоно” (Т.Цэнд-Аюуш, 2012) хэмээн олон янзын хэлбэрээр тодорхойлжээ.

Компанийн засаглалын талаар анх Адам Смит (1776) бүтээлдээ “компанийн удирдлагад ажиллаж буй бусдын мөнгөний менежерүүд өөрийнхөө мөнгийг харж хандахын адил бусдын мөнгийг анзааргатай харж хянана гэж санах хэрэггүй” гэж үзсэнээс эхтэй гэж үздэг (Удирдлагын академи, 2017). Адам Смитийн энэ санааг үргэлжлүүлэн Бэрлэ, Минс (1932) нар “компанийн өмчлөл болон хяналт салангид байх нь компани сайн ажиллана гэсэн үг биш юм” гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Энэ үеэс эхлэн компанийн засаглалын судалгаа хийгдэх болж онол, бүтээлүүд гарч эхэлсэн гэж үздэг (Удирдлагын академи, 2017). Компанийн засаглалын талаарх хэд хэдэн онолуудыг судлаачид тодорхойлсон бөгөөд зарим онолын гол төлөөлөгчид, үндсэн чиглэл, онолын санааг хураангуйлан Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Компанийн засаглалын онолууд

Онолын нэр	Онолын төлөөлөгч
КЗ-ийн тухай анхны онол	Адам Смит (1776), Бэрлэ, Минс нар (1932)
Агентын онол/Agency Theory	Женсин энд Меклин (1976), (1986), Алчиан, Демсэц (1983), Чарреакс, Алли (1987) нар, Химмелберг, Хаббард энд Палиа (1999), МсКолган (2001), Гомберс, Иший энд Метрик (2003), Кавалевски нар (2007), Фаринха (2003)
Хөрөнгийн хариуцлагын онол/ Stewardship Theory	Доналдсон болоод Дэвис (1991) нар, Далтон Кенсер (1987)

Оролцогч талуудын онол/ Stakeholder Theory	Фриймэний (1984), Жинсэн (2001), Хитт (2012)
Нөөцийн хамаарлын онол/ Resource Dependence Theory	Питтегрю (1992), Трикер (2012), Хитт (2012)
Хэлцлийн зардлын онол/ Transaction Cost Theory	Виллиамсон
Улс төрийн онол/ Political Theory	Абдуллах энд Валентин (2009), Рое (1994), Томсен (2008)
Мэдээллийн зөрүүний онол/ Information Asymmetry Theory	Акерлоф (1970)
Морал Хазардын онол/ Moral Theory	Дэмсэтц (1985), Бонази нар (2007), Абдуллах (2009), Лан (2010), Смит (2011), Хэндрик (2003) нар

*Эх сурвалж: Sorin, N., Monica-Violeta, A, 2013, Theories of Corporate Governance*

Эдгээр засаглалын онолууд нь компанийн оролцогч талуудын үүрэг, хариуцлага, ашиг сонирхлыг хэрхэн хангах, тэдгээрийн компани дахь харилцааг харилцан адилгүйгээр тайлбарласан байгаа хэдий ч бүхий л онолын хувьд компанийн засаглалын асуудал нь түүнд оролцогч талуудын ашиг сонирхлын нэгдэл, хамтын ажиллагаа, тэдгээрийн уялдаа холбоог зөв шийдвэрлэх замаар компанийг хэрхэн зөв зүйтэй удирдах тухайд анхаарсан байдгаараа адил байна гэж дүгнэж болно.

### **1.1.3 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглал**

Өмнөх хэсэгт Компани гэж юу болох, түүний засаглалын онцлог шинж, онолын ойлголтуудыг судалсан бөгөөд тодорхой тусгаарласан хөрөнгөтэй, ашиг олох зорилго бүхий бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй зохион байгуулалтын хэлбэрийг компани/корпораци хэмээн тодорхойлсон.

Компанийн тухай хуулиар компани нь эрх зүйн хэлбэрийн хувьд хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани хэмээн ангилагдах бөгөөд хувьцаат компани нь нээлттэй, хаалттай гэсэн 2 хэлбэртэй байхаар хуульчлан заажээ. Компанийг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч хэн байхаас хамааран хувийн болон төрийн өмчит, тэдгээрийн хосолсон хэлбэр бүхий төрийн өмчийн оролцоотой гэх мэт компанийн хэлбэр түгээмэл оршдог бөгөөд төр өөрийн нийтийн хэрэгцээг хангах чиг үүрэг, стратегийн салбаруудыг хяналтад байлгах зэрэг тодорхой зорилгуудыг хангах үндсэн дээр төрийн өмчит компанийг байгуулах боломжтой байдаг байна. Хувийн болон төрийн өмчит компанийн ялгаатай байдлыг Зураг 1-д харуулав.

Хэдийгээр сүүлийн 30 жил дэлхий дахинд өмч хувьчлал, төрийн өмчийг хувьд шилжүүлэх үйл явц хүчтэй өрнөж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот компанийн тоо буурах хандлагатай байгаа хэдий ч ТӨК нь эдийн засаг, санхүүгийн өсөлт болон хөгжлийн чухал тоглогч хэвээр байсаар байгаа юм (PwC, 2015).


Зураг 1. Хувийн өмчит болон төрийн өмчит компанийн ялгаатай байдал

	Хувийн хэвшлийн компани	Төрийн өмчит хуулийн этгээд
<b>ЗОРИЛГО</b>	Үнэ цэнийг хэрхэн хамгийн өндөр байлгах тодорхой зорилгод төвлөрнө.	Арилжааны болон арилжааны бус зорилгуудад төвлөрнө.
<b>ТӨЛӨӨЛЛИЙН АСУУДАЛ</b>	Дан төлөөлөл буюу хяналтын эрх бүхий ХЭ эсвэл гүйцэтгэх удирдлагын ашиг сонирхлын асуудалд анхаарал хандуулах	Давхар төлөөлөл буюу гүйцэтгэх удирдлага болон улс төрч/хүнд сурталтнуудын ашиг сонирхлын асуудалд анхаарал хандуулах
<b>УРАМШУУЛАЛ/ САХИЛГА БАТ</b>	Хүчтэй зах зээл дээр тулгуурласан урамшуулал, сахилга батын бодлого (жишээ нь: Булаан авах аюул занал, дампуурал, хангалтгүй гүйцэтгэлтэй ажилтнуудын гэрээг дуусгавар болгох, хязгаарлагдмал нөөцийн олдоц/ашиглалт болон бусад гүйцэтгэлд суурилсан цалин, урамшуулал)	Хязгаарлагдмал урамшуулал болон сахилга батын механизмууд (жишээ нь: дампуурал/булаан авахаас тусгаарлагдах, ажилтнуудын ажлын байрны өндөр хамгаалалт, гүйцэтгэлд тулгуурласан урамшуулал, цалин хөлсний хязгаарлагдмал бодлого буюу хэрэглээ)

Эх сурвалж: Дэлхийн банк

2018 онд ТӨК-ийн хөрөнгө 45 их наяд ам.доллар болж үнэлэгдсэн ба ДНБ-д эхлэх хувь нь 2000 онд 13 их наяд ам.доллар байснаас түүний хагас хүртэлхийг эзлэх хүртэл өссөн байна. Түүнчлэн 2015 онд 40 улсыг хамран хийсэн (БНХАУ ороогүй) судалгаагаар ТӨК нь 2.4 их наяд ам.доллараар үнэлэгдэж, 9.2 сая хүнийг ажиллуулж байна гэсэн тооцоог гаргажээ. 2018 онд хийгдсэн өөр нэгэн судалгаагаар дэлхий даяар ТӨК нь нийт хөрөнгө оруулалтын 20 орчим хувийг оруулдаг, нийт ажиллах хүчний 5 орчим хувийг ажиллуулдаг, зарим улс оронд тухайн орны дотоодын нийт бүтээгдэхүүний 40 орчим хувийг үйлдвэрлэдэг ч гэсэн тооцоог гаргасан байдаг (Дэлхийн банк, 2021). ТӨК-ийн хувьд голчлон харилцаа холбоо, эрчим хүч, санхүү, тээвэр болон ашигт малтмал олборлолтын чиглэлүүдэд байгуулсан бөгөөд Зураг 2-д графикийг харуулав.

Зураг 2. ТӨК-ийн үйл ажиллагаа явуулж буй салбараар



Эх сурвалж: ЭЗХАХБ, 2022



Дээрхээс дүгнэвэл ТӨК нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд голлон тоглогч хэвээр байсаар байгаа бөгөөд ялангуяа даяарчлагдан буй дэлхий ертөнц дээр хязгаарлагдмал буй санхүү, ур чадвар, нөөцийн төлөөх өрсөлдөөн улам ихэссээр байгаа энэ цаг үед зарим орнуудын хувьд энэ өрсөлдөөнд байр сууриа эзлэх нэг арга хэрэгсэл нь болж байгаа гэж үзжээ (PwC, 2015).

Хэдий тийм боловч төр гэдэг эзэн биегүй буюу бодитоор оршин байдаггүй нэрийн дор хэлбэр нь зохион байгуулагдаж, төр хэмээх ойлголтыг бүрдүүлж буй олон субъектүүдийн үйл ажиллагаа, шийдвэрээс хамаарч үйл ажиллагаа нь явагддаг онцлогтой, мөн хувийн бусад аж ахуйн нэгжтэй харьцуулахад эзэн болох төрөөсөө дэмжлэг, хууль тогтоомжийн тусгай зохицуулалт бүхий давуу талыг авах боломжтой байдаг зэрэг онцлогоосоо хамаараад ТӨК сайн засаглалтай байх, үр ашигтай байх явдал нь эргээд төсвийн орлого бүрдүүлэлт, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, томоохон хямралын үед ч өөрийн ханган нийлүүлэлтийн сувгаар дамжуулан нийгмийн хэрэгцээг хангах зэрэгт ихээхэн ач холбогдолтой болох нь харагдах бөгөөд PwC байгууллагаас хийсэн Гүйцэтгэх удирдлагын судалгаагаар (PwC's CEO Pulse survey) хэрвээ ТӨК-д засаглалын сайн практик болон удирдлагын зөв арга барил хэрэгжүүлэхгүй бол эдгээр үнэ цэнэ, давуу байдал нь сөрөг үр дагавар бий болох эрсдэлтэй хэмээн үзсэн байна.

ТӨК-ийн үр ашигтай байдал нь эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа болохыг судалсан судалгаагаар ТӨК-ийн үр ашгийг 5 хувиар дээшлүүлэхэд, ДНБ 1-5 хувиар өсөх боломжтой (Дэлхийн банк, 2021) хэмээсэн байна. Хэдий тийм боловч нөгөө талаас ТӨК-д нь өөрт байдаг хууль тогтоомжийн болон төрийн эрх мэдлийн давуу талаа ашиглан зах зээлийн өрсөлдөөнийг гажуудуулж, ижил салбарт ажиллаж буй хувийн хэвшлийг шахах шударга бус өрсөлдөөнийг бий болгох сөрөг үр дагаврыг ч бий болгох боломжтой бөгөөд ялангуяа хууль тогтоомжийн орчин сул, ил тод байдал, хяналтын тогтолцоо бүрдээгүй, шударга өрсөлдөөнийг хангах эрх зүйн тогтолцоо бий болоогүй нөхцөлд энэ үр дагавар илүүтэй бий болох боломжтой (Зураг 3-аас үзнэ үү).


Зураг 3. ТӨК ба зах зээл



Эх сурвалж: Дэлхийн банк

ЭЗХАХБ-аас гишүүн орнуудын хүрээнд ТӨК-ийн засаглалын судалгааг 2005 онд явуулж, судалгааны үр дүнд тулгамдаж буй хэд хэдэн асуудлыг тодорхойлсон бөгөөд үүнд компанийн засаглал хангалтгүй байгаа учраас алдаа дутагдлууд гарч, төрийн өмчийг зохисгүй ашиглах байдал бий болж, тухайн цаг хугацаан дахь эрх баригчдын шийдвэр зэргээс хамаардаг буюу ашиг сонирхлын нөлөөнд ордог тул хувийн хэвшлийн компаниас харьцангуй үр ашиггүй ажилладаг, зорилт, үйл ажиллагаанд нь үнэлгээ өгөхөд хүндрэлтэй, ХЭ, ТУЗ, болон гүйцэтгэх удирдлага зэрэг оролцогч талууд нь харьцангуй бие даасан байдлаар ажилладаг учраас сайн удирдлага, засаглалтай байх сонирхол бага байсаар ирсэн хэмээн дүгнэжээ (Удирдлагын академи, 2017). Улмаар тус байгууллагаас 2015 онд “Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын удирдамж”-ийг гаргасан бөгөөд энэхүү удирдамж нь ТӨК-ийн үйл ажиллагаанд хариуцлагатай, нээлттэй ил тод байдлыг хэрхэн бүрдүүлэх, тэдгээрийн эдийн засгийн үр ашгийг хэрхэн сайжруулах талаар улс орнуудын ЗГ-т чиглэсэн зөвлөмжийн шинжтэй баримт бичиг юм. (OECD, 2015). ТӨК-ийн засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх явдал нь улс орны хөгжилд эерэг үр дагаврыг авчирч чадах болохыг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, үүнийг бодлогоор дэмжиж байгаа явдал нь ТӨК-ийн үр дүнг зөвхөн санхүүгийн үр дүнгээр үнэлэх бус үүн дээр нэмээд нийгэм, соёл, хүн, инноваци, байгаль орчны зэрэг нөхцөлүүдийг харгалзан үздэг байх буюу ТӨК-ийн дүр төрхийг Зураг 4-д дараах байдлаар тодорхойлж байна.

Зураг 4. Төрийн өмчит компани



Төрийн өмчит компани гэдэг ойлголт нь улс орнуудын эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжийн онцлогоос хамааран төрийн корпораци, ЗГ-ийн газрын хамаарал бүхий компани, нийтийн өмчит компани гэх мэтээр янз бүрээр нэрлэгддэг. Өөрөөр хэлбэл ТӨК хэмээх нэгдсэн нэг нэр томъёог олж тодорхойлох боломжгүй буюу улс орон бүр өөрөөр нэрлэдэг гэсэн үг юм.

Эх сурвалж: PwC, 2015

Судлаачдын дэвшүүлсэнээр ТӨК-ийн эрх зүйн хэлбэрүүд дараах хүчин зүйлүүдээс хамааран тогтож байна гэж үзсэн байна:

- Компанийг өмчилж буй өмчлөгчийн түвшин (төрийн, орон нутгийн, бүс нутгийн г.м);
- Компанийг үүсгэн байгуулсан арга зам;
- Төрийн захиргааны байгууллагын шатлан захирах ёсонд эзлэх байр суурь;
- ТӨК-ийн зорилго;

- ТӨК-ийн статус;
- Төрөөс бүтэн болон хэсэгчлэн өмчлөх эрхийг хэрэгжүүлж буй байдал;
- Нээлттэй, хаалттай хувьцаат г.м.

Энэхүү ялгаатай байдлын хүчин зүйлүүд нь ТӨК-ийн өмчлөлийн бодлогыг хэтэрхий ойлгомжгүй, төвөгтэй болгох, ил тод байдлыг бууруулах, бусад компаниудад үйлчилж буй эрх зүйн орчны үйлчлэлээс ангид буюу түүнд хамаарахгүй мэт байдалд хүргэх зэрэг нөхцөл хүргэж болзошгүй (PwC, 2015) болох бөгөөд дараагийн дэд хэсэгт бичигдэх манай орны ТӨК-ийн өнөөгийн нөхцөл байдал үүний нэг жишээ болж байна гэж дүгнэж байна.

ЭЗХАХБ-аас баталсан дээр дурдсан удирдамж нь бүтцийн хувьд 8 бүлэгтэй, тэдгээр нь дараах агуулгыг хамарсан байна. Үүнд:

Удиртгал.

Нэгдүгээр бүлэг. Төрийн өмчийн үндэслэл

Хоёрдугаар бүлэг. Өмчлөгч болох төрийн зүгээс хэрэгжүүлэх чиг үүрэг

Гуравдугаар бүлэг. ТӨК-ийн зах зээл дэх оролцоо

Дөрөвдүгээр бүлэг. Хувьцаа эзэмшигчийн тэгш эрхийн зарчим

Тавдугаар бүлэг. Оролцогч талуудтай харилцах, хариуцлагатай үйл ажиллагаа

Зургаадугаар бүлэг. Нээлттэй, ил тод байдал

Долоодугаар бүлэг. Төрийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ-ийн хариуцлагын асуудлуудыг багтаана.

Улмаар удирдамжийн хэрэгжилтийг хангах, улс орнуудын ТӨК-ийн засаглалыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагыг таниулан сурталчлах чиглэлээр судалгааг OECD, САҮ зэрэг олон улсын байгууллагуудаас тогтмол хийж дээр дурдсан бүлгүүдийн хүрээнд ТӨК-ийн засаглалын асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг зөвлөсөн бөгөөд үүнээс заримыг дурдвал:

А. Үр дүнтэй эрх зүйн тогтолцоо, зохицуулалтын орчныг бий болгох хүрээнд:

- ТӨК-ийн эрх зүйн байдал нь төр өмчлөгч болохын хувиар болон мөн зохицуулагч болохын хувиар эрх үүрэг нь тодорхой ялгаатай байх шаардлагатай;
- ТӨК-ийн засаглалын ерөнхий бүтэц нь зөвхөн хууль тогтоомжийн шаардлагаас гадна бусад хувийн сектортой өрсөлдөх боломжийг хангахуйц өөрийн зохицуулалтын туршлага, сайн дурын амлалт, бизнесийн практик дээр үндэслэх боломжтой байх;
- ТӨК-д эрх зүйн ялгаатай байдлыг хууль тогтоомжоор олгох үндэслэл нь аливаа байдлаар бүтцийн болон арилжааны, ажиллах хүчний гэх мэт ялгаатай нөхцөлүүдийг тусгах бус зөвхөн хувийн өмчит компаниудад хэрэгжүүлдгээс илүү сайн засаглалын хэлбэрийг хэрэгжүүлэх болон компани татан буугдах үйл явцтай холбоотойгоор эрх зүйн үйлдлийг тодорхойлох 2 зорилгын хүрээнд орших ёстой;
- ТӨК-ийн капиталын бүтэц нь компанийн зорилго, зорилгод хүрэх шаардлагатай тохиолдолд тодорхой хэмжээнд өөрчлөлт оруулах боломжтой буюу уян хатан байдлыг хангах эрх зүйн орчныг хангах;

- ТӨК нь санхүүжилтийн асуудлаар аливаа харилцаанд оролцохдоо тухайн зах зээлийн нөхцөлийн дагуу ажиллах. Өөрөөр хэлбэл банкнаас зээл авах, санхүүгийн хэрэгслийн бусад шалгуур нь адил тэгш байх.

Б. Төрийн өмчлөлийн үүргийн хүрээнд:

- ЗГ нь ТӨК-ийн хувьцаа эзэмшигч, эсвэл өмчлөгчийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг, компанийн засаглалыг бэхжүүлэхэд гүйцэтгэх үүргийг эрх зүйн хүрээнд тодорхойлох;
- ЗГ нь ТӨК-ийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд компанийн удирдлагад компанийн бизнес зорилтыг биелүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны бүрэн эрхийг олгосон байх;
- ЗГ нь өмчлөгчийн хувиар ТӨК-ийн удирдлагад түүнийг эрх үүргээ хэрэгжүүлэх боломжийг олгохоос гадна түүний бие даасан, хараат бус байдлыг хүндэтгэх;
- Тусгайлсан өмчлөлийн агентлаг бий болгож тодорхойлсон байх нь сайн туршлага болж байна.

В. Мэдээллийн ил тод байдал, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл хүрээнд:

- ТӨК нь өөрийн ТУЗ-аас баталсан Мэдээллийн ил тод байдлыг бодлоготой байх ёстой бөгөөд энэ нь ялгаатай оролцогч талуудын хяналтыг бий болгох, тэдгээр нь тухай бүрт мэдээллээр хангагдах боломжийг хангах боломжтой болгоно;
- ТӨК нь өөрийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг өндөр чанарын болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу нийтлэх ёстой;
- ТӨК нь оролцогч талуудад шаардлагатай санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь хангах ёстой;
- ТӨК нь жил бүр өөрийн засаглалын талаарх тайланг бэлтгэн гаргах ёстой;
- ТӨК нь өөрийн нэгтгэсэн үйл ажиллагааны тайланг жил бүр бэлтгэн гаргадаг байх ёстой зэргээр ТӨК-ийн засаглалын хүрээнд хэрэгжүүлэх практик зөвлөмжийг олон улсын хэмжээнд гаргаж, улс орнуудад сайн туршлагаар хэрэгжүүлэхийг зөвлөж байна.


#### **1.1.4 Компанийн сайн засаглал, түүний шинж**

Бүлгийн эхний хэсэгт компанийн засаглал болон төрийн өмчит компанийн засаглалын ойлголтуудын талаар товч дурдсан бөгөөд компанийн засаглал нь компанийн үйл ажиллагааг хэрхэн удирдан явуулж буй арга замыг ойлгоно хэмээн товч тодорхойлсон. Тэгвэл дэлхий даяар энэхүү үйл ажиллагааг хэрхэн зөв зүйтэйгээр хэрэгжүүлэх хүрээнд сайн туршлага, зарчмуудыг тодорхойлохыг оролдож хөгжүүлсээр ирсэн бөгөөд НҮБ-ийн Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн зөвлөлөөс Сайн засаглалын дараах гол 8 шинжүүдийг тодорхойлжээ (Зураг 5-аас үзнэ үү).

Энэхүү сайн засаглалын гол шинжүүдийн ойлголтыг товчхон дурдвал:

**Оролцоо:** Эмэгтэй, эрэгтэй аль ч хүйсийн оролцоотой байдал нь сайн засаглалын гол тулгын чулууны нэг болно. Оролцоо нь өөрөө болон өөрийн сонгосон төлөөллийн хэлбэрээр дамжуулан шууд болон шууд бусаар хэрэгжиж болно.

## Зураг 5. Сайн засаглалын 8 шинж



**Эрх зүйт байдал:** Сайн засаглал нь хүчин төгөлдөр байдал бүхий шударга эрх зүйн тогтолцоог бий болгоно. Түүнчлэн хүний эрхийг бүхэлд нь хамгаалах ялангуяа цөөнхийг эрхийг хангах явдлыг шаарддаг. Хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх байдлыг хангахад хараат бус хяналтын бүтцийг бий болгох нь чухал гэж үздэг байна.

Эх сурвалж: НУБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн зөвлөл

**Ил тод байдал:** Ил тод байдал нь шийдвэр гаргах болон түүнийг хэрэгжүүлэх үйл явц нь холбогдох хууль, дүрэм журмыг дагасан байх, улмаар тухайн шийдвэрийн хэрэгжилт болон шийдвэрийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдүүдэд мэдээлэлтэй чөлөөтэй танилцах, чөлөөтэй олж авах боломжтой байх утгыг агуулдаг. Мөн энэ нь хангалттай хэмжээний мэдээллийг өгсөн байх болон түүнийг ойлгоход хялбар байх нөхцөлийг хангасан байх гэсэн утгыг ч мөн агуулна.

**Цаг хугацаандаа байх:** Сайн засаглал нь бүхий л оролцогч талуудад үндэслэл бүхий цаг хугацаанд багтаан үйлчилдэг байх, хариу өгдөг байх тогтолцоо, процессыг мөн шаардана.

**Зөвшилцөл:** Тухайн бүтцэд олон янзын ашиг сонирхлуудыг тохируулах, хамгийн сайн ашиг сонирхол нь юу байхыг тогтоох болон түүнд хэрхэн хүрэх зэрэг зөвшилцөлд хүрсэн байхыг шаардана.

**Нийтийг хамарсан байх, тэгш шударга байх:** Өөрөөр хэлбэл оролцогч бүхий л талуудад тухайн үйл явцаас хасагдаагүй байх, түүнд хамаарч байгаа гэсэн мэдрэмжийг бий болгох бөгөөд хамгийн эмзэг хэсгийг ч багтаагаад бүхий л бүлгүүдэд тэдгээрийн энэхүү мэдрэмж, хэрэгцээг хангах, сайжруулах боломжийг олгосон байхыг сайн засаглал шаардана.

**Үр дүнтэй, үр ашигтай байх:** Нөөцийг зөв зохистой ашиглах замаар оролцогч талуудын хэрэгцээг хангах процесс, бүтцийг бий болгох, мөн байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах агуулгыг багтаана.

**Хариуцлагатай байх.** Нийгмийн бүхий л түвшний байгууллагууд нь нийгэмд болон оролцогч талууддаа хариуцлагатай хандах, шийдвэр гаргахдаа тухайн шийдвэрийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй гадаад, дотоод талууддаа хариуцлагатай хандахыг шаардах бөгөөд хариуцлагатай байдал нь ил тод байдлыг хангахгүйгээр хэрэгжих боломжгүй байдаг байна.

Онолын болон практик олон судалгаагаар компанийн сайн засаглалын механизм нь компани нь хувийн болон төрийн эсэх хэлбэрээс үл хамааран компанийн гүйцэтгэлийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг тодорхойлсон бөгөөд жишээлбэл: ЭЗХАХБ-ын төрийн өмчит компаниудын засаглалын гарын авлагын хэрэгжилтэд хийсэн судалгааны үр дүнгээр засаглалыг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангаснаар дараах зэрэг үр дүнгүүд гарч байгааг дүгнэсэн байна (World Bank, 2014):

- Компаниудын хувьд гадаад санхүүгийн орчинд нэвтрэх боломжийг нэмэгдүүлсэн ба энэ нь эргээд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг татах, компанид өндөр өсөлтийг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг зэрэг үр дагаврууд руу хөтөлнө;
- Капиталын зардлыг бууруулж, компанийн үнэлгээг өсгөх бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдын компанид хөрөнгө оруулах сонирхлыг илүүтэйгээр татаж улмаар өсөлт болон ажил эрхлэлтийг нэмэгдүүлж байна;
- Нөөцийг зөв хуваарилах болон илүү үр дүн бүхий удирдлагыг хэрэгжүүлэх замаар стратегийн шийдвэр гаргалт болон үйл ажиллагааны гүйцэтгэл сайжирсан;
- Корпорацийн хямрал, скандалын эрсдэлийг бууруулж ялангуяа үндэстэн дамнасан корпорациудын хямралаас үүсэж болох томоохон хэмжээний эдийн засаг болон нийгмийн эрсдэлээс сэргийлнэ;
- Оролцогч талуудтай сайн харилцаа холбоотой байх нөхцөлийг хангаж энэ нь цаашлаад нийгмийн болон хөдөлмөрийн харилцааг сайжруулах, түүнээс үүсэх тухайлбал байгаль хамгаалах асуудлууд гэх мэт асуудлуудыг шийдвэрлэхэд туслах ба улмаар ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг багасгах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд тусалж байна.

Мөн ЭЗХАХБ-аас тэмдэглэсэнээр компанийн сайн засаглал нь “компанийн дүр төрхийг сайжруулж, эрсдэлийг бууруулж, хувьцаа эзэмшигчдийн итгэлийг машид өсгөдөг” (OECD, 2004) бөгөөд компанийн үр бүтээмжийг дээшлүүлэх тогтвортой механизм, дотоод хяналтын тогтолцоо зэрэг олон боломжуудыг бий болгож байдаг байна. ЭЗХАХБ нь Компанийн засаглалын зарчмуудыг анх 1999 онд гаргасан бөгөөд эдгээр зарчмууд нь оролцогч талуудын хувьд олон улсын жишиг баримт бичиг, эх сурвалж болж байна (Хүснэгт 2-оос үзнэ үү). Компанийн засаглалын зорилго нь урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн бүрэн бүтэн байдлыг хөхиүлэн дэмжихэд шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчныг бүрдүүлэх, ингэснээр эдийн засгийн өсөлт, нийгмийн хариуцлага, шударга, ил тод зах зээлийг дэмжих явдал юм (OECD, 2015) хэмээн тодорхойлжээ.

Хүснэгт 2. Компанийн засаглалын үндсэн зарчмууд

Хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах	<ul style="list-style-type: none"> <li>✓ Үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхийг шилжүүлэх</li> <li>✓ Ногдол ашиг авах</li> <li>✓ Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхийг хамгаалах</li> </ul>
Шударга байх	<ul style="list-style-type: none"> <li>✓ ХЭ-д тэгш хандах</li> <li>✓ ХЭ-ийн эрх зөрчигдөхөд адил тэгш хандах</li> </ul>
Оролцогчдын эрх ашгийг зөвшөөрөх	<ul style="list-style-type: none"> <li>✓ ХЭ бус оролцогч талын өмнө нийгмийн болон гэрээний хариуцлага хүлээх</li> </ul>

ТУЗ-ийн үүрэг хариуцлага зохистой байх	✓ ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны үр дүнг нягтлан шинжлэх чадвартай байх ёстой
Ил тод, нээлттэй байх	✓ ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, хариуцлагыг олон нийтэд ил тод байлгах, санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар хянуулах

Эх сурвалж: OECD, 2015

Дээрхээс дүгнэвэл аливаа хэлбэрийн компанийн засаглалын асуудал нь компанийн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулахад шаардлагатай оролцогч талуудын хяналт, зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зөв механизмыг бүрдүүлэх арга хэлбэр бөгөөд үүний тулд компанийн засаглалын зарчмууд болох оролцогч талуудын тэгш эрх, оролцоог хангах, үүрэг хариуцлагыг тодорхой байлгах, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах замаар сайн засаглалыг бий болгодог байна. Оролцогч буюу хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага болон бусад дотоод, гадаад оролцогч талуудын оролцоо, тэгш эрхийг хангах асуудал нь оролцох, эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй асуудлын талаар эхлээд мэдсэн, мэдээлэгдсэн байх буюу мэдээллийн ил тод байдал нь хангагдсан тохиолдолд хэрэгжих боломжтой бөгөөд тэр ч утгаараа ил тод байдал нь сайн засаглалыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй (IRIM, 2021), түүний нэгж шинж байдал болдог болохыг дээр дурдсан болно. Түүнчлэн компанийн засаглалын онолуудын гол тодорхойлдог эзэн буюу хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагын харилцаанд гарч байгаа зөрчлийг багасгах арилгах нэг арга зам нь тэдгээрийн хооронд үүсч байдаг мэдээллийн зөрүүг арилгах явдал (Sorin, 2013) бөгөөд мэдээллийн зөрүүг арилгах арга нь мөн л адил тухайн мэдээлэлтэй танилцах боломжтой эсэх, мэдээлэгдсэн эсэх, ил тод байгаа эсэх зэрэг мэдээллийн ил тод, нээлттэй байдлын асуудалтай холбогдож байна. Ил тод, нээлттэй байна гэдэг нь оролцогчдын өмнө хариуцлагатай байгаагаа харуулахын тулд ТУЗ болон ГУ нь чиг үүрэг дүрэмд заасны дагуу биелүүлж байгаа эсэх, хариуцлагатай ажиллаж, санхүүгийн болон санхүүгийн бус тайланг хөндлөнгийн аудитораар хянуулж хэвлэн нийтлэх, бүх хөрөнгө оруулагчдад үнэн зөв, бодит мэдээллийг цаг хугацаанд нь тэнцвэртэй хүргэхийг хэлнэ (OECD, 2015).

## 1.2 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тухай онолын ойлголт

Англи хэлэнд Transparency and Disclosure гэдэг үг нь мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг илэрхийлсэн үг бөгөөд үүнийг толь бичгээс утгачилж үзвэл дараах утгатай байна. Үүнд:

**Transparency: Ил тод, нээлттэй байдал**

*noun* /træn'spær.ən.si/ **Collins Dictionary:** The transparency of a process, situation, or statement is its quality of being easily understood or recognized, for example because there are no secrets connected with it, or because it is expressed in a clear way.

**Орчуулга:** Аливаа үйл явц, нөхцөл байдал, мэдэгдлийн ил тод байдал гэдэг нь амархан ойлгогдох, эсвэл танигдах чанарыг хэлнэ. Жишээлбэл, үүнтэй холбоотой ямар ч нууц байхгүй, эсвэл тодорхой илэрхийлэгдсэн байхыг ойлгоно.

**Cambridge Dictionary:** The quality of being done in an open way without secrets.

**Орчуулга:** Нууцлалгүй, нээлттэй байдлаар хийгдэх.

**Disclosure: Мэдээллийг ил тод болгох/задруулах үйлдэл**

*noun* /dɪ'skləʊ.ʒər/ • formal The act of making something known or the fact that is made known.

**Орчуулга:** Аливаа зүйлийг мэдэгдүүлэх үйлдэл эсхүл мэдэгдсэн үйл баримт.

Монгол хэлэнд ил тод, нээлттэй байдал болон нийтийн мэдээлэл гэдэг үгийг толь бичиг болон хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулийн зохицуулалтаас утгачилж үзвэл дараах утгатай байна. Үүнд:

**Ил:** (а) юмны халхлагдаагүй, далд биш, олноо мэдүүлэх зорилгоор сонин, сэтгүүлд нийтэлсэн зүйл; (б) (Монгол хэлний их тайлбар толь);

**Ил тод:** ив илэрхий (Монгол хэлний их тайлбар толь);

**Олонд нээлттэй байх:** Үйл ажиллагаа олон түмэнд ил тод байлгах (Монгол хэлний их тайлбар толь);

**Мэдээлэл:** Ямар нэгэн үйл хэргийн тухай ам болон бичгээр дэлгэрэнгүй мэдээлэх явц, мэдээ дамжуулах, түгээх (Монгол хэлний их тайлбар толь);

**Нийтийн мэдээлэл:** Нийтийн мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цуглуулсан, боловсруулсан, ашиглаж байгаа өгөгдлийн бүрдлийг ойлгоно (Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2021).

Иймд нийтийн мэдээлэл гэдэг нь нийтийн мэдээлэл хариуцагч буюу төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой этгээд, төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд, олон нийтийн радио, телевиз, улс төрийн нам хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цуглуулсан, боловсруулсан, ашиглаж байгаа өгөгдлийн бүрдлийг ойлгоно гэж үзэж болохоор байна.

СЗХ-оос 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн №145 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодексоос үзвэл Компанийн засаглалын үндсэн 9 зарчмын нэг зарчим нь тайлагнал, мэдээллийн ил тод байдал орсон. Компанийн засаглалын кодексийг нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компанид тус тус үүрэг болгосон. Иймд эдгээр дурдсан байгууллагын эрх барих байгууллага ТУЗ нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллахаар тусгасан.

Компанийн засаглалын кодексийн зорилго нь компанийн дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг Компанийн засаглалын кодексийн зарчимд нийцүүлэн баталгаажуулах, дагаж мөрдөх хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх, тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг сайжруулах. хяналтын тогтолцоог сайжруулснаар компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвшил болгоход оршдог.



Ил тод байдал өндөр хэмжээнд байх болон нээлттэй байдлыг сайжруулах явдал нь компанийн сонирхогч талууд тухайн компанийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг мэдэх хамгийн сайн арга зам болдог байна (Sandeep & George, 2002 Transparency and Disclosure: Overview of Methodology and Study results-United States). Мэдээллийн ил тод байдал өндөр хэмжээнд байх нь компани болон хувьцаа эзэмшигчдэд бий болгох зардал болон үр ашгийн шинжилгээ болон засаглалын ил тод байдлын асуудлын талаар олон судалгааг хийсэн байдаг.

Тухайлбал Hermalin&Weisbach, 2007 нар мэдээллийн ил тод байдлыг сайжруулснаар зах зээлээр илүү ойрхон ажил нь хянагдаж байдаг менежерүүдийн хувьд хүссэн ч эс хүссэн ч мэдээллийг нээлттэй байлгах дарамтыг бий болгодог, хяналтын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьд тэдгээрийн мэдээллийн давуу талаа алдаж, тэдгээрийн байр суурийг татах сонирхол сулардаг (Berglof& Pajuste, 2005) ба мөн энэ нь бизнесийг ирээдүйд борлуулах тохиолдолд анхны эзэмшигчдэд гарах зардлыг нэмэгдүүлдэг (Verrecchia, 2001). Farhi, Lerner болон Tirole (2013) нар бүтээгдэхүүний сертификатаас бий болсон ил тод байдал нь өрсөлдөгчдөд ашиг тус бий болгож байдаг талаар анхааруулсан байна. Leuz болон Verrecchia (2000) нар мөн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх нь ач холбогдлын хувьд эерэг болон сөрөг холилдсон үр дагавартай болохыг тэмдэглэсэн байна.

Төв болон Зүүн Европын орнуудад ихэнх хувьцаат компаниуд нь хуучны социалист нэгдлээс саяхан хувьчлагдсан байдалтай бөгөөд ил тод байдлыг өндөр хэмжээнд хэрэгжүүлэх хүсэл сонирхол болон түүний хэрэгцээний талаарх ойлголтын аль алиных нь дутагдал байна гэж харж байгаа. Өнгөрсөн хугацаанд, дотоодын хөрөнгийн зах зээлийн зохицуулагчид болон эрх мэдэлтнүүдийн гаргасан хичээл зүтгэлийн үр дүнд нөхцөл байдал тодорхой хэмжээгээр сайжирсан. Эдгээр асуудлууд нь эрдэмтэн, судлаачдын анхаарлыг улам татаж, олон зохиолчид энэ нөхцөл байдалд компанийн засаглал болон ил тод байдлын онцлогуудыг тодорхойлох чиглэлд хувь нэмрээ оруулах болсон байна (Berglof & Pajuste, 2005). Djankov болон Murrel (2002) нарын олж тодорхойлсноор компанийг гадныханд хувьчлах явдал нь компанийг дахин зохион байгуулахад илүү эерэг үр нөлөөг үзүүлж байна. Korent, Dundek болон Calora (2014) нарын олсноор CROBEX-н хөрөнгийн зах зээлийн индексэд багтсан компаниудын хувьд компанийн засаглалын чанарын хувьд эерэг нөлөөллийг бий болгож байна хэмээн дүгнэсэн байна.

Өнөө үед, эдгээр улс орнуудын компаниудын хувьд ил тод байдлын түвшин нь харилцан адилгүй буюу нэлээн том ялгаатай байдлыг харуулж байгаа болох нь харагдаж байна. Бидний судалгааны ажлын зорилгын хувьд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон нийтийн мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмын арга зүйг ашиглан шалгуур асуудлыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийж, тэдгээрийн нийтийн мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдлыг тодорхойлж үнэлэх зорилготой болно.

### ***Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын онол, хандлагууд***

Компаниуд ямар учир шалтгааны улмаас мэдээллээ ил тод, нээлттэй байлгадаг болохыг ганц онолоор тайлбарлах боломжгүй бөгөөд хэд хэдэн онолын хүрээнд авч үзэх

шаардлагатай (Эрнэст Учэнна Нүжэ, 2017) талаар олон судлаачид дурдсан байдаг. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаар компанийн засаглалын онолуудын хүрээнд тайлбарласныг дор Хүснэгт 3-т товчлон харуулав.

Хүснэгт 3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын онолын хандлагууд

Онолын чиглэл	Үндэслэл
Төлөөллийн онолын хандлага	Агентын онолын үзэл баримтлал болох эзэн болон түүнийг төлөөлж буй төлөөлөгчийн хүсэл зориг нэг байна гэж үзэх боломжгүй буй эзэн нь өөрийн ашиг сонирхлыг хамгийн сайнаар хангагдах, төлөөлөгчийн хувьд компанийн ашиг сонирхол хамгийн сайнаар хангагдах эрмэлзлийн улмаас тэдгээрийн хооронд зөрчил үүсдэг гэж үздэг онол дээр тулгуурладаг. Энэхүү эзэн болон агентын хооронд үүсэж буй зөрчлийг шийдвэрлэхэд мэдээллийн ил тод, нээлттэй байдал нь чухал нөлөө үзүүлнэ хэмээх онолын хандлага юм.
Дохиоллын онолын хандлага	Дохиоллын онолын хандлага нь оролцогч талуудын хооронд мэдээллийн тэгш хэмт байдлыг хадгалах үүднээс мэдээлэл дутмаг тал руу дохио өгч мэдээллээ хуваалцах хэрэгтэйг чухалчилдаг онолын хандлага болно (Эрнэст Учэнна Нүжэ, 2017).
Оролцогч талуудын онолын хандлага	Орчин үеийн засаглалын онолын нэг гол хандлага нь компани нь зөвхөн өөрийн эдийн засгийн ашиг сонирхлыг хангахыг тэргүүнд тавихаас гадна түүний үйл ажиллагаанд өртөж буй, нөлөөлж буй гадаад болон дотоод оролцогч талуудын ашиг сонирхлыг мөн харгалзан үзэх ёстой хэмээх үзэл баримтлал бөгөөд энэхүү нөхцөлийг хангах арга зам нь оролцогч талуудад компанийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах явдал гэж үздэг байна. (Gray et al, 1996).
Хууль ёсны зүй тогтлын онолын хандлага	Энэ онолын хандлага нь компани нь үйл ажиллагаа явуулахдаа олон тооны хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг даган мөрдөх, хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд энэхүү үүргээ биелүүлэх, түүнийг хэрэгжүүлж буйг илтгэх арга зам нь хууль тогтоомжоор шаардсан заавал биелүүлэх шаардлагыг хангах болон сайн дурын нээлттэй байдал байх болно хэмээн үздэг байна.

*Эх сурвалж: Энхбаяр, Н, 2018, Монголын арилжааны банкнуудын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг үнэлэх нь. СЭЗИС-Бүтээлийн сан, Мастерын зэрэг горилсон дипломын ажил*

Дээрх онолын хандлагуудын хүрээнд мэдээллийн ил тод, нээлттэй байдлын компанийн засаглалд нөлөөлөх үүрэг, ач холбогдлыг ялгаатай байдлаар тайлбарласан ч бүх онолын хүрээнд нийтлэгээр тодорхойлж буй ойлголт нь мэдээллийн ил тод, нээлттэй байдал нь компани болон түүний оролцогч талуудын эрх ашигт чухал эерэг ач холбогдолтой, компанийн үйл ажиллагаа, үр дүнд ямар нэгэн байдлаар нөлөөлж байдаг бөгөөд засаглалын гол суурь зарчмын нэг мөн юм гэдэг санааг илэрхийлсэн байдгаараа нийтлэг байна.

### **1.3 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлал**

#### **1.3.1 Компанийн засаглалын ил тод байдлын шалгуур ба үнэлгээний аргууд**

Академик судлаачид, зохицуулагчид, компанийн дотоод оролцогч талууд (гүйцэтгэх удирдлага болон давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид) болон гадаад оролцогч талууд (жижиг хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгчид зэрэг) хоорондын мэдээллийн зөрүүг багасгахад мэдээллийн ил тод байдал нь чухал үүрэг гүйцэтгэнэ (Sandeep & George, 2002). Компанийн сайн засаглалын ойлголт нь сонор сэрэмжтэй ТУЗ, санхүүгийн мэдээллийг цаг хугацаанд нь, хангалттай нээлттэй байлгах, ТУЗ-ын болон удирдлагын үйл ажиллагааны талаарх бүрэн гүйцэт, нээлттэй мэдээлэл, гүйцэтгэх удирдлага, захирлууд, ХЭ-чид болон бусад оролцогч талуудын хоорондын ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох, эзэмшлийн бүтцийн ил тод байдал гэсэн ойлголтуудыг агуулдаг (Sandeep & George, 2002). Өөрөөр хэлбэл компанийн засаглал нь агуулга, бүтцийн хувьд өргөн хүрээг хамрах ойлголт бөгөөд түүнийг зөвхөн ганц шалгуураар үнэлэх боломжгүй. Энэ ч утгаараа компанийн засаглалын ил тод, нээлттэй байдлыг үнэлэх олон улсын арга аргачлалууд өргөн хүрээнд боловсруулагдан дэлхий даяар хэрэглэгдэж буй бөгөөд эдгээр арга аргачлалуудаас түгээмэл хэрэглэгдэж буй дараах үнэлгээний аргачлалууд байна.

#### **Standard & Poor's мэдээллийн ил тод байдлын стандартууд**

Standard & Poor's Financial Services LLC (S&P) нь Америкийн санхүүгийн үйлчилгээний компани бөгөөд хувьцаа, бонд, бараа бүтээгдэхүүний талаар санхүүгийн судалгаа, шинжилгээ хийж гаргадаг олон улсад нэр хүндтэй компани юм. S&P нь мэдээллийн ил тод байдлын үнэлгээ гаргах 3 бүлэг 98 асуулттай, өөрийн гэсэн үнэлэмжийг боловсруулж гаргасан бөгөөд энэ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аналистуудын эх сурвалжаа болгодог үнэ цэнтэй шалгуур болж хөгжсөн.

S&P-ийн тодорхойлсноор ил тод байдал нь компанийн үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэл, компанийн засаглалын үйл ажиллагааны талаар зохих мэдээллийг цаг тухайд нь нээлттэй байлгахад оршино. S&P-ийн “Компанийн засаглалын үнэлгээ ба шалгуур” гэх бичиг баримтад ил тод байдлын талаар дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- Зөв засаглалтай компанийн хувьд цаг тухайд нь мэдээлэх, ил тод байлгах стандарт нь бусад компанитай харьцуулахад илүү өндөр байдаг. Энэ нь хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгч, захирлуудад компанийн менежмент, үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлд үр дүнтэй хяналт тавих боломжийг олгодог.
- Ил тод буюу тунгалаг байдлын хүрээнд компанийн санхүүгийн тайлан нь компанийн бодит нөхцөл байдлын талаар тодорхой ойлголттой болоход тусална. Нягтлан бодох бүртгэлийн стандарт хязгаарлагдмал буюу сул хөгжилтэй байгаа зарим улсад ил тод байдлыг хангах үүрэг хүлээнэ гэдэг нь тухайн компани нь нягтлан бодох бүртгэлийн орон нутгийн стандартуудаас гадна олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг баримтлах ёстой талаар чухалчилсан.
- Ил тод байдал нь санхүүгийн ил тод байдлаас гадна санхүүгийн бус үйл ажиллагаа, ялангуяа компанийн бизнесийн үйл ажиллагаа, өрсөлдөөний байр суурьтай холбоотой нээлттэй байдлыг шаардана.

S&P-ийн ил тод байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг дурдвал:

**Шалгуур 1:** Санхүүгийн тайлан ба санхүүгийн бус тайлан аль аль нь чухал ач холбогдолтой бөгөөд тайлан, тодруулгыг өндөр нарийвчлалтайгаар тодорхой зааж өгөх ёстой. Шинжилгээний үндсэн асуудлууд:

- Нягтлан бодох бүртгэлийн стандартууд;
- Санхүүгийн тайлан (үндсэн түншүүдийн талаарх мэдээллийг багтаасан) хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг нийгэмд ил болгосон;
- Цөөнхийн, хоорондын болон холбогдох талуудын хэлцэл;
- Үйл ажиллагааны тодруулга;
- Засаглалын холбогдох тодруулга;
- Нийгэм, байгаль орчны тайлан;
- Олон нийтэд нээлттэй мэдээлэх хугацаа, нээлттэй байдал.

**Шалгуур 2:** Олон нийтэд нээлттэй дамжуулах бүхий л мэдээлэл хувьцаа эзэмшигч нарт болон бусад ирээдүйн хөрөнгө оруулагч нарт бүрэн нээлттэй, үнэ төлбөргүй байх ёстой. Компани нь мэдээллийг тогтмол түгээж байх зарчмыг баримтлах ёстой. Компани нь өөрсдийн мэдээлэл болон тайланг хүргэх өөрсдийн цахим хуудастай байх ёстой бөгөөд дээрх мэдээллүүд тухайн орны хэлнээс гадна англи хэл дээр байх хэрэгтэй. Шинжилгээний үндсэн асуудлууд:

- Олон нийтийн мэдээллийг хүргэх хүртээмж;
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, зах зээлийн нууц мэдээллийг ил тод болгох журам;
- Цахим хуудас ба цахим хуудсанд суурилсан тайлан;
- Давтамж;
- Тогтмол байгаа эсэх;
- Аудитын үйл ажиллагаа.

**Шалгуур 3:** Аудит нь ТУЗ болон бусад удирдлагын төвшний албан тушаалтнуудаас хараат бус, түүнчлэн нэр хүндтэй байх хэрэгтэй. Шинжилгээний үндсэн асуудлууд:

- Аудитын байгууллагыг сонгох процесс;
- Аудитын байгууллагыг солих, шинэчлэх дүрэм журам;
- Хараат бус байдал;
- Эрсдэлийн шинжилгээ;
- Аудитын байгууллагын дүрэм;
- Дотоод үйл ажиллагааны хяналт.

**Төрийн өмчит компанийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт /ЭЗХАХБ/**

ТӨК-ийн засаглалын OECD зарчим нь (The OECD Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises) ТӨК-ийн үйл ажиллагааг нээлттэй, үр дүнтэй байдлыг хангах, хувийн компаниудтай ижил түвшинд байлгахыг зорьсон стандарт болно. Энэхүү удирдамжийн үндсэн зарчмуудын нэг нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй компаниудын хувьцаа эзэмшигчдэд хандах хандлага шиг олон нийтийн өмнө хариуцлага хүлээх ёстой гэсэн ойлголт юм. Мөн олон

нийтийн эрх ашгийн төлөө төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өмчлөлийн эрхийг хэрэгжүүлж буй улс орнууд нь тэдгээрийн зорилго, зорилт, үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн талаар өөрийн орны иргэдэд нээлттэй байх ёстой гэсэн шаардлагыг тавьдаг. Энэхүү удирдамж 10 гаруй жилийн өмнө батлагдсанаас хойш дэлхий даяар олон улс орнууд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоо бүхий компаниудын аль ч түвшинд ил тод байдлыг сайжруулах чиглэлээр шинэчлэлтийг хийсээр байна. Хэдий тийм боловч улс орнуудын хувьд энэхүү зарчмыг хэрэгжүүлэлтийн хүрээнд хүрсэн түвшин нь янз бүр байгаа бөгөөд ерөнхийдөө нээлттэй ХК-ийг бодвол ТӨК-ийн нээлттэй байдлын дэглэм нь сул байсаар байгаа юм (OECD, 2020 Transparency and Disclosure Practices of State-Owned Enterprises and their Owners).

2004 онд ЭЗХАХБ-аас компанийн засаглалын зарчмуудыг, 2005 онд ТӨК-ийн засаглалын зарчмуудыг тус тус тодорхойлж гишүүн орнууддаа уг зарчмыг мөрдүүлж эхэлсэн байдаг. ЭЗХАХБ-ын компанийн засаглалын зарчмуудыг эдүгээ улс орнууд мөрдөж ажиллах гол удирдамж болгож, хууль эрх зүйн зохицуулалтын хүрээгээ тодорхойлж байна (Төрийн өмчит хувьцаат компанийн засаглал төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлөх нь, 2017).

ЭЗХАХБ-ын “Төрийн өмчит үйлдвэрийн газрын компанийн засаглалын зарчим” 2015 онд шинэчлэгдсэн бөгөөд үндсэн 7 бүлгийн хамарна.

6-р бүлэг Ил тод, нээлттэй байдал хэсэгт “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд ил тод байдлын өндөр стандартыг мөрдөж, хөрөнгийн биржид бүртгэлтэй (listed) компаниудтай адил өндөр чанарын нягтлан бодох бүртгэл, ил тод байдал, нийцэл, аудитын стандартыг дагаж мөрдөх ёстой” гэж дурдсан ба дараах 3 үндсэн шалгуурыг тавьсан. Үүнд:

- A. **Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг** (зорилт ба түүний хэрэгжилт, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, засаглалын бүтэц, дүрэм, бодлого ба түүний хэрэгжилт, удирдах зөвлөлийн гишүүд, үндсэн удирдах ажилтнуудын цалин хөлс, ТУЗ-ын гишүүдэд тавих шалгуур, сонгон шалгаруулах үйл явц, ТУЗ-ын гүйцэтгэх үүрэг, эрсдэлийн удирдлага, төрөөс авсан татаас, санхүүжилт гм) олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өндөр чанарын стандартад нийцүүлэн **тайлагнах**;
- B. Жилийн санхүүгийн тайланг өндөр чанартай хөндлөнгийн **аудитад хамруулах**. (Төрийн хяналтын тусгай журам нь хөндлөнгийн хөндлөнгийн аудитыг орлохгүй);
- C. Өмчлөгч аж ахуйн нэгж нь **төрийн өмчит аж ахуйн нэгжийн талаарх тайланг** боловсруулж, **жил бүр цахим хуудсаар нийтлэх**.

ТӨК-ийн засаглалын OECD зарчим нь бие даасан үнэлгээний арга биш, зарчмын шаардлагуудыг тодорхойлсон баримт бичиг бөгөөд харин эдгээр зарчмуудыг засаглал, ил тод байдлын үнэлгээнд суурь болгон ашиглах нь түгээмэл байна.

***Төрийн өмчит компанийн засаглалын ил тод байдлын индекс (State-Owned Enterprises Corporate Governance Transparency Index)***

Public Policy and Competitiveness Direction of CAF (Corporación Andina de Fomento) байгууллагаас Латин Америкийн улсуудын төрийн өмчийн компаниудын засаглалын ил тод байдлыг үнэлэх зорилгоор Төрийн өмчит компанийн засаглалын ил тод байдлын индексийг

боловсруулсан. Тус аргачлалын дагуу Латин Америкийн бүс нутгийн 13 орны 105 компанийн цахим хуудаст байгаа мэдээлэлд тулгуурлан компанийн засаглалын ил тод байдлыг үнэлсэн.

Энэхүү индекс нь ЭЗХАХБ (2006), Дэлхийн Банк (2006), САФ (2010)-ын төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдамжид суурилсан таван тулгуур баганаас бүрдэнэ:

- (i) Төрийн өмчит аж ахуйн нэгжийн харьяалагдах хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин;
- (ii) Өмчлөлийн томилогдсон төлөөлөгч үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа байдал;
- (iii) Цөөнхийн хувьцаа эзэмшигчид (хэрэв байгаа бол) оршин тогтнох, эрх тэгш байх нөхцөл хангагдаж байгаа байдал;
- (iv) Мэдээллийн ил тод байдал;
- (v) Төлөөлөн удирдах зөвлөлийн томилгоо.

Эдгээр дэд индекс тус бүр нь нэг оноотой өөр өөр асуултуудаас бүрдэнэ. Дараа нь энэ анхны үр дүн нь арван цэгийн суурь болж хувирдаг. Эцэст нь 50 оноонд суурилсан компанийн засаглалын ерөнхий үзүүлэлтийг гаргахын тулд дэд индекс бүрийн стандартчилсан үр дүнг нэгтгэн гаргадаг.

Энэхүү индексийн үнэлгээ нь зөвхөн компанийн засаглалын ил тод байдалд төвлөрсөн бөгөөд онлайн үйлчилгээ, хэрэглээ болон олон нийтийн оролцоог хангах талаар асуулга, үнэлгээг хамруулаагүй байна.

### **1.3.2 Цахим засаглал, цахим ил тод байдал ба үнэлгээний аргууд**

Цахим засаглал (e-governance) нь төрөөс иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд мэдээллийн технологийг ашиглах явдал юм. Энэ нь төрийн албан хаагчид болон олон нийтийн хоорондын холбоог бэхжүүлж, улмаар илүү хүчтэй, илүү хариуцлагатай, хүртээмжтэй ардчилалд хүргэнэ гэж найдаж байна. (Council of Europe) Үүнтэй адилаар компанийн засаглалд мэдээллийн технологийг ашиглах нь ил тод, үр ашигтай байдлыг илүү сайжруулах нь дамжиггүй.

Цахим шилжилтийн өнөө үед “цахим ил тод байдал” гэх ойлголт бий болсон бөгөөд цахим ил тод байдлыг тогтвортой хэрэгжүүлснээр авлигатай тэмцэх, засаглалыг сайжруулах, төр-иргэд болон бусад оролцогч талуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх боломжтой юм (IRIM, 2022).

“Цахим засаглал” зөвхөн статик үйлчилгээ, контенттой байсан бол өнгөрсөн 10 жилд сошиал медиа технологитой нэгдэж, хэрэглэгч өөрөө контент үүсгэх боломжтой болон хөгжиж байна. Энэ нь иргэдийг бодлого, хөтөлбөрт санал, шүүмж өгөх, оролцоог хангах боломжийг олгож, цахим-ардчилал болон олон нийтийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд дэм болж байна гэж үзэж байна (Aroon P.Manoharan, 2022).

Цахим засаглал, цахим ил тод байдалд үнэлгээ хийж буй олон улсын болон үндэсний түвшний дараах хэд хэдэн арга байгааг харьцуулан судалж үзлээ. Үүнд:

- (i) Цахим засгийн хөгжлийн индекс (E-Government Development Index - EGDI), Нэгдсэн үндэстний байгууллага;

- (ii) Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индекс (Rutgers E-Governance Performance Index. Holzer and Manoharan, 2016);
- (iii) Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс, IRIM судалгааны байгууллага (2019, 2021);
- (iv) Төрийн байгууллагын вэб хуудсанд хийсэн үнэлгээ, Авлигатай тэмцэх газар;
- (v) Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021), Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам (2022).

### Цахим засаглалын хөгжлийн индекс (E-Government Development Index - EGDI)

Цахим засаглалын хөгжлийн индекс нь Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын нийт 193 гишүүн улсуудын үндэсний цахим хуудас болон цахим засгийн бодлого, стратеги нь ерөнхий болон тодорхой салбарт хэрхэн хүрч байгааг онлайнар үнэлдэг судалгаанд суурилдаг.

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтсээс хоёр жил тутамд цахим засаглалын судалгааг гаргадаг. Энэ нь НҮБ-ын гишүүн улсуудын цахим засаглалын төлөв байдлыг үнэлдэг дэлхийн цорын ганц тайлан бөгөөд шийдвэр гаргагчдад цахим засаглалын хүчин чадал, бэрхшээлийг тодорхойлох, засгийн газрын бодлого, стратегид чиглүүлэх хэрэгсэл болдог. Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI) нь цахим засгийн хөгжлийг үндэсний түвшинд үнэлдэг бөгөөд онлайн үйлчилгээний индекс, харилцаа холбооны дэд бүтцийн индекс, хүний капиталын индекс гэсэн гурван бүрэлдэхүүн хэсэгт суурилдаг.

Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI) нь ижил хувийн жин бүхий суурь 3 индексээс бүрддэг.

- Онлайн үйлчилгээний индекс - Online Service Index (OSI);
- Харилцаа холбооны дэд бүтцийн индекс - Telecommunications Infrastructure Index (ТИ);
- Хүний капиталын индекс - Human Capital Index (HCI).

Харилцаа холбооны дэд бүтцийн индексийг Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан мэдээлэлд суурилдаг бол хүний капиталын индексийг гаргахдаа Нэгдсэн үндэстний боловсрол, шинжлэх ухаан, соёлын (UNESCO) байгууллагаас гаргасан мэдээллийг ашигладаг. Харин онлайн үйлчилгээний индексийг 5 бүлэг бүхий онлайн судалгааны асуулгын дагуу улс орнуудын үндэсний цахим хуудсанд үнэлгээ хийх замаар тодорхойлсон. Тухайлбал 2022 онд 130 улсын хувьд энэ үнэлгээг хийхэд 66 улсын хэл дээр нийт 227 сайн дурын ажилтнууд гүйцэтгэсэн байна.

Онлайн үйлчилгээний индекс (OSI) нь дараах 5 бүлгээс бүрддэг. Үүнд:

#### Хүснэгт 4. *Онлайн үйлчилгээний индекс (OSI)*

№	Бүлэг	Үнэлгээнд эзлэх хувь
1.	Үйлчилгээний үзүүлэлт	45%
2.	Технологи	5%
3.	Цахим засаглалын хөгжил	10%
4.	Контентын үзүүлэлт	5%

5.	Цахим оролцоо	35%
----	---------------	-----

Эх сурвалж: UN E-Government survey, 2022

Цахим засаглалын хөгжлийн индекс нь улс орнуудын түвшинд үнэлгээ хийдэг тул асуулгын цар хүрээ илүү өргөн байж, технологийн хөгжил, үйлчилгээний хүртээмж, иргэдийн оролцоонд түлхүү анхаардаг ба компанийн засаглал, удирдлага, санхүүгийн чиглэлийг хамардаггүй онцлогтой.

### Rutger -ийн цахим засгийн гүйцэтгэлийн индекс

АНУ-ын Rutger-ийн их сургуулийн дэргэдэх “Олон нийтийн үйл ажиллагааны үндэсний төв”-өөс энэхүү үнэлгээний аргачлалыг боловсруулсан бөгөөд 2003 оноос хойш, 2 жилд 1 удаа, дэлхийн 100 том хотуудын хотын захиргааны албан ёсны цахим хуудсыг эх хэл дээр нь үнэлж, харьцуулсан судалгааг гаргадаг. Хотуудыг сонгохдоо Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (ITU) дата ашиглаж, харилцаа холбооны сүлжээ хамгийн сайн хөгжсөн улсын хамгийн их хүн ам бүхий хотыг сонгож авдаг байна.

Тус үнэлгээг Хүснэгт 5-д дурдсан 5 бүлэг, нийт 106 үзүүлэлтийн дагуу хийж, үзүүлэлт тус бүрийг 0-3 оноогоор үнэлдэг ба дараа нь оноог бүлэг тус бүрийн жигнэсэн дундаж оноонд шилжүүлдэг (Хүснэгт 6-г үзнэ үү).

Хүснэгт 5. Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн үзүүлэлт, үнэлгээний оноо

Ангилал	Шал-гуурын тоо	Raw оноо	Жиг-нэсэн оноо	Ангилалд хамрах агуулгууд
Нууцлал/ Аюулгүй байдал	21	27	20	Хувийн мэдээллийн нууцлалын бодлоготой эсэх, нууцлалын бодлогын хамрах хүрээ, танилт нэвтрэлт, кодлол, дата менежмент, cookies, цахим гарын үсгийн хэрэглээ, социал медиа бодлоготой эсэх
Ашиглах боломж	20	32	20	User-friendly design, нүүр хуудасны урт, формат, зорилтот хэрэглэгчийн линк ба суваг, хайлт хийх боломжууд, цахим хуудасны шинэчлэл
Контент/ агуулга	26	63	20	Хууль журам, бодлогын баримт бичгүүд, тайлангууд, мэдээ, нийтлэлүүд, төсөв, хаяг, линкүүд, холбоо барих, хүний нөөц, ажлын байр, яаралтай тусламж, хөгжлийн бэрхшээлтэй хүн хандах боломж, гар утаснаас хандах боломж, хэлний сонголт, хуанли
Үйлчилгээ	21	61	20	Татвар, торгууль төлөх, зөвшөөрлийг онлайнгаар авах, статусыг хянах, онлайн худалдаа, гүйлгээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ ба татвар, мэдээллийн сангийн хайлт, гомдол гаргах, асуулт асуух, мэдээлэл авах, авилгын талаар мэдээлэх боломж, FAQ, арга хэмжээнд бүртгүүлэх



Иргэд ба нийгмийн оролцоо	18	48	20	Иргэний онлайн оролцоо, хэлэлцүүлэг, чат, цахим хурлын боломж, иргэдээс судалгаа авах, иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх боломж, албан тушаалтанд үнэлгээ өгөх боломж, иргэнийг урамшуулах гм
<b>Нийт</b>	<b>106</b>	<b>231</b>	<b>100</b>	

Эх сурвалж: *The E-Governance Institute, Rutgers, 2016*

Хүснэгт 6. *Rutger-ийн цахим засгийн үнэлгээний оноо, тайлбар*

<b>Оноо</b>	<b>Тайлбар</b>
0	Өгөгдсөн агуулгаар цахим хуудсанд мэдээлэл байхгүй.
1	Өгөгдсөн агуулгаар цахим хуудсанд мэдээлэл байгаа. (тухайн мэдээллийг үзэх линк болон и-мэйл хаягийг оролцуулна)
2	Цахим хуудаснаас мэдээллийг татаж авах боломжтой (маягт загвар, аудио, видео болон бусад нэг талт гүйлгээ, роруп box)
3	Үйлчилгээ, гүйлгээ, харилцааг онлайнгаар бүрэн хийх боломжтой (кредит картын гүйлгээ, зөвшөөрлийн апп, хайх боломжтой дата баазууд, күүкий хэрэглээ, тоон гарын үсэг, хандалтыг хязгаарлах)

Эх сурвалж: *The E-Governance Institute, Rutgers, 2016*

Хотуудын цахим хуудсанд үнэлгээ хийдэг энэхүү индексийн асуулга нь хэдийгээр компанийн засаглал, хувьцаа эзэмшигч, удирдлага, санхүүгийн чиглэлийг бүрэн хамардаггүй боловч, тухайн цахим хуудас дахь мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үзүүлж буй үйлчилгээ, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байдал, олон нийтийн оролцооны байдлыг үнэлдэг, асуулгуудын хувьд сайн боловсруулагдсан, оновчтой асуулгуудтай байна.

### **Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс**

IRIM (Independent Research Institute of Mongolia) судалгааны хүрээлэн нь 2010 оноос хойш жил бүр төрийн байгууллагуудын цахим хуудсанд ил тод байдлын үнэлгээг өөрийн санаачилгаар хийж ирсэн. 2019 оноос үнэлгээг шинэчилж, олон улсын түвшний индекс болгон хэмжих боломжтой (Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс тайлан, 2021, х5) “Цахим ил тод байдлын индекс” тооцох арга зүйг боловсруулан 2019, 2021 оны тайлангуудыг уг аргачлалын дагуу гаргажээ. 2020 онд цар тахлын улмаас хуучин аргачлалаар гаргасан. 2019 оныг хүртэл төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг хувиар үнэлдэг байсан бол шинэчилсэн арга зүйгээр зөвхөн цахим хуудасны ил тод байдлыг үнэлэхээс гадна бодлогын орчин, тухайн төрийн байгууллагын чадавхийг харгалзан үздэг болсон байна.

Зураг 6. Цахим ил тод байдлын индексийн бүлэг, дэд бүлэг, индикаторын хувийн жин

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ (1/3)			БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖ (1/3)			ЦАХИМ ИЛ ТОД БАЙДАЛ (1/3)		
<b>МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ</b> (1/3)	<b>ЗАСАГЛАЛ</b> (1/3)	<b>ИРГЭНИЙ НИЙГЭМ</b> (1/3)	<b>БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДАЛ</b> (1/3)	<b>ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА</b> (1/3)	<b>МХТ-ийн АШИГЛАЛТ</b> (1/3)	<b>ТЕХНОЛОГИ</b> (0.13)	<b>НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА</b> (0.80)	<b>ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА ХАРИЛЦАА</b> (0.07)
Мэдээлэл авах эрх (1/12)	Хуулийн хэрэгжилт (1/12)	Иргэдийн ороцоо (1/9)	Ил тод байдлыг хангах процедур ба процесс (1/6)	Манлайлал (1/6)	МХТ-ийн ашиглалт (1/9)	Технологийн нийцтэй байдал (0.07)	Үйл ажиллагаа (0.16)	Харилцаа ба эргэх холбоо (0.07)
Мэдээллийн хүрээ (1/12)	Дуу хоолой ба хариуцлага (1/12)	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө (1/9)	Нөөцийн хүрэлцээ (1/6)	Тасралтгүй хөгжил ба сургалт (1/6)	МХТ-ийн хүрэлцээ (1/9)	Технологийн үр нөлөөтэй байдал (0.07)	Төсөв санхүү (0.24)	
Мэдээлэл хүсэх процедур (1/12)	Зохицуулалтын чанар (1/12)	Иргэний нийгмийн төлөв байдал (1/9)			Мэдээллийн санг үүсгэх, засварлах чадвар (1/9)		Худалдан авах ажиллагаа (0.18)	
Мэдээллийн санцр ба хамгаалалт (1/12)	Засгийн газрын үр нөлөөтэй байдал (1/12)						Нээлттэй өгөгдөл (0.07)	

Эх сурвалж: IRIM, 2021

Цахим ил тод байдлын индекс нь эрх зүйн орчин, байгууллагын чадамж, цахим ил тод байдал гэсэн үндсэн 3 бүлэг, бүлэг тус бүр нь мөн 3 дэд бүлэгт, дэд бүлэг тус бүр нь 2-5 үзүүлэлтэд задарч, нийт 26 индикатор үзүүлэлтээр үнэлгээг хийдэг. Зураг 6-д Цахим ил тод байдлын индексийн бүлэг, дэд бүлэг, индикатор тус бүрийн хувийн жинг харуулав.

Индексийн бүлэг ба дэд бүлэг нь адил хувийн жинд хуваагдах ба индикаторууд нь оруулж буй хувь нэмрээс хамаарч өөр өөр жинтэй байна.

Индекс нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд Зураг 7-д индексийн үр дүнгийн утгын ангилал, тайлбарыг харуулав.

2021 оны Төрийн байгууллагын цахим ил тод байдлын тайлангийн үнэлгээнд Төрийн болон орон нутгийн захиргааны 6 төрлийн 88 төрийн байгууллагыг хамруулсан. 2021 оны цахим ил тод байдлын ерөнхий индекс улсын хэмжээнд 0.602 буюу “Сул” дүнтэй үнэлэгдсэн байна. Харин ТӨК-ийг үнэлгээнд хамруулж байгаагүй байна.

Зураг 7. Цахим ил тод байдлын индексийн үнэлгээний онооны тайлбар

<b>Сайн</b>	<b>≥0.80</b>	Цахим ил тод байдлыг бий болгох, мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бүрэн бэхжүүлсэн.
<b>Хангалттай</b>	<b>0.65-0.79</b>	Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бэхжүүлж байгаа.
<b>Сул</b>	<b>0.50-0.64</b>	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой зарим үзүүлэлт байгаа. Цаашид байгаа мэдээллүүдийг шинэчлэх, тогтвортой хангах чадварыг бэхжүүлэх шаардлагатай.
<b>Хангалтгүй</b>	<b>0.35-0.49</b>	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх талаар суурь түвшний процедур, нөөц, хариуцлагатай, ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадвар хомс байна.
<b>Муу</b>	<b>&lt;0.35</b>	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага бараг байхгүй, энэ нь эргээд цахим хуудсаар мэдээллийг түгээхгүй байхад гол нөлөө үзүүлж байгаа.

Эх сурвалж: IRIM, 2021

## **Авлигатай тэмцэх газрын төрийн байгууллагын албан ёсны цахим хуудсанд үнэлгээ хийх аргачлал**

Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газар 2021 онд “Төрийн байгууллагын албан ёсны цахим хуудсанд үнэлгээ хийх аргачлал”-ыг боловсруулан 14 яам, 21 аймгийн албан ёсны цахим хуудсанд үнэлгээ хийсэн.

Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтад заасныг аргачлалд тусгаж, яам, агентлагийг 55, аймаг, дүүргийг 59 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн.

Үнэлгээ нь дараах 5 хэсгээс бүрдэх ба шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулсан эсэхийг харгалзан тус бүрт 0-3 оноо, нийт 0-100 оноо өгөх замаар үнэлгээ хийдэг байна. Үүнд:

- (i) Авлигын эсрэг манлайлал;
- (ii) Үйл ажиллагааны ил тод байдал;
- (iii) Төсөв санхүүгийн ил тод байдал;
- (iv) Хүний нөөцийн ил тод байдал;
- (v) Цахим хуудасны үнэлгээ.

Авлигатай тэмцэх газрын энэхүү үнэлгээний аргачлал нь хамаарах хуулийн хэрэгжилтийн байдлыг үнэлэхэд чиглэсэн бөгөөд 2021 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдан гарснаар чиг үүрэг нь Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд шилжсэн.

### **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021), Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам (2022)**

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд нийтийн мэдээлэл хариуцагчийн (мөн хуулийн 6-р зүйлд тодорхойлсон) ил тод нээлттэй байлгах шаардлагатай 5 бүлэг, нийт 71 мэдээллийг тодорхойлсон. Үүнээс ТӨК-д хамаарах 44 үзүүлэлт байна (Хүснэгт 7-оос үзнэ үү).

Хүснэгт 7. Журмын дагуу цахим хуудсанд нээлттэй ил тод мэдээлэх мэдээллийн тоо

№	Бүлгийн агуулга	Журмын шалгуурын тоо	ТӨК -д хамаарах шалгуурын тоо
1.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	10	10
2.	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	6
3.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	28	14
4.	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	2	2

5.	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	25	12
<b>НИЙТ</b>		<b>71</b>	<b>44</b>

Эх сурвалж: Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам, 2022

ЗГ-ын 2022 оны №352 дугаар тогтоолын хавсралтаар “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг баталсан. Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг дараах Хүснэгт 8-д заасан 4 шалгуур үзүүлэлтээр үнэлнэ гэж журамд заасан.

Хүснэгт 8. Журмын үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

№	Бүлэг	Хангалттай	Дутуу	Хангалтгүй
1	<b>Мэдээллийн хүртээмжтэй байдал</b>	Цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгслээр нийтэлсэн бол <b>30 оноо</b>	зөвхөн цахим хуудаст – 15 оноо мэдээллийн самбарт – 10 оноо бусад хэлбэрээр – 5 оноо	Нийтлээгүй бол 0 оноо
2	<b>Хугацаандаа нийтлэгдсэн байдал</b>	Хуулиар тогтоосон хугацаанд нийтэлсэн, шинэчилсэн бол <b>30 оноо</b>	Хуулиар тогтоосон хугацаанаас хойш нийтэлсэн, шинэчилсэн бол <b>10 оноо</b>	Нийтлээгүй, шинэчлээгүй бол 0 оноо
3	<b>Мэдээллийн бүрэн бүтэн байдал: 8.6 үүрэг хүлээгээгүй</b>	8.2-8.5 Бүрэн нийтэлсэн бол 30	Дутуу бол 15 оноо	Нийтлээгүй бол 0 оноо
	<b>Мэдээллийн бүрэн бүтэн байдал: 8.6 үүрэг хүлээсэн</b>	8.2-8.5 Бүрэн нийтэлсэн бол 15	Дутуу бол 10 оноо	Нийтлээгүй бол 0 оноо
		8.6 Бүрэн нийтэлсэн бол 15	Дутуу бол 5 оноо	Нийтлээгүй бол 0 оноо
4	<b>Эх сурвалжийн тодорхой байдал (хуулийн нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эх сурвалж, холбоо барих мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэх)</b>	мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн бол 30 оноо	Аль нэгийг нийтлээгүй бол 10 оноо	Нийтлээгүй бол 0 оноо

Эх сурвалж: Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам, 2022

Хууль болон журамд заасан нээлттэй ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүд нь засаглал, үйл ажиллагаа, хүний нөөц, санхүү, үйлчилгээний чиглэлийг хамруулсан бөгөөд

технологи, иргэдийн оролцоог хангах, хэрэглэхэд хялбар ойлгомжтой байх талаас үзүүлэлт тусгагдаагүй байна.

### "Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага" Монгол Улсын MNS 6285:2017 стандарт

ЗГ-ын 2022 оны №201 дүгээр тогтоолын хавсралт, Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмын 2.1-д мэдээлэл хариуцагч нь буюу ТӨК нь "Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага" Монгол Улсын MNS 6285:2017 стандартыг **хангасан**, Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG 2.1 зөвлөмж)-д **нийцсэн** өөрийн цахим хуудас (цаашид "цахим хуудас" гэх) -тай байхыг заасан.

MNS 6285:2017 стандарт нь MNS 6285:2011-ийн шинэчилсэн хувилбар ба ISO, ISO/IEC стандартуудад суурилсан. Тус стандартаар дараах Хүснэгт 9-д заасан 6 бүлэг, нийт 71 шаардлагыг тодорхойлсон байна.

#### Хүснэгт 9. Стандартад заасан шалгуур үзүүлэлт

№	Бүлгийн нэр	Тоо	Ерөнхий агуулга
1.	Нийтлэг шаардлага	27	Монгол хэлээр, крилл үсгээр, нийтлэлийн огноотой, лого нь зүүн дээд буланд, жижиг дэлгэц болон мобайл хувилбартай байх, бэлтгэгч нийтлэгч администратортой байх г.м.
2.	Агуулгын шаардлага	6	Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны танилцуулгатай, баримт бичгүүдийг хавсаргасан, иргэдтэй харилцах, зөвлөгөө өгөх булантай, хамтын ажиллагааны хэсэгтэй байх.
3.	Зохиомжийн шаардлага	17	Цахим хуудасны дэлгэцийн урт, өргөн, өнгө, текстийн зохимжит хэмжээг заасан. Хайлт, хэрэглэгч нэвтрэх, бүртгэх хэсэгтэй байх.
4.	Гүйцэтгэлийн шаардлага	13	Хэрэглэгчийн шаардлага, үйлдлийг бүрэн дүүрэн гүйцэтгэдэг, хамгаалагдсан байх. Хуваалцах боломжтой, шинэчлэн сайжруулах боломжтой байх г.м.
5.	Хэрэглээний шаардлага	3	Хэрэглэгчийн үйлдлийг хадгалдаг, буцах, зогсоох, дахин эхлүүлэх боломжтой, ойлгомжтой байх.
6.	Тусгай шаардлага	5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглах боломжийг хангасан, хүртээмжтэй байх.
<b>Нийт</b>		<b>71</b>	

Эх сурвалж: MNS 6285:2017

Стандартын шаардлагуудын зорилгыг шинжилж үзэхэд цахим хуудсыг тодорхой, ойлгомжтой, хүртээмжтэй, хялбар байдлыг хангахад ихэнх (70-80%) шаардлага чиглэж байна.

Нийт 71 шаардлагаас 51 шаардлагыг цахим сайтаас шууд шалгах боломжтой, 10 шаардлагыг асуулгаар шалгах, харин 18 шаардлага нь техникийн шинжтэй тул мэргэжлийн ажилтны туслалцаа шаардлагатай.

### **1.3.3 Үнэлгээний аргачлалуудын харьцуулалт**

Компанийн болон цахим засаглалын ил тод байдлыг үнэлж буй аргачлал, үнэлгээний үзүүлэлтүүдийг харьцуулж үзэх зорилгоор үндсэн 10 ангиллын хүрээг тодорхойлж гаргасан бөгөөд судалсан аргачлалуудын шалгуурууд нь тухайн ангилалд хэрхэн хамаарч байгааг Зураг 8-д харьцуулан шинжилж үзэв.

Компанийн засаглалын ил тод байдлын үнэлгээний аргачлалууд нь хувьцаа эзэмшигчийн бүтэц, эрх, томилгоо, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, аудит, хяналтын тайланг ил тод мэдээлж буй байдлыг авч үздэг бол цахим засаглалын ил тод байдлын үнэлгээний аргачлалууд нь компанийн засаглалын үнэлгээний шалгуурыг ерөнхийд нь хамруулахаас гадна илүү өргөн хүрээний буюу хүний нөөц, үзүүлж буй үйлчилгээ, хэрэглэхэд тохиромжтой байдал, иргэний оролцоог хангах чиглэл шалгууруудтай байна. Байгууллагын бүтэц, засаглал, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан бүх үнэлгээнд чухал байр суурьтай байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон журмын шаардлагууд нь компанийн засаглалын ил тод байдлын шалгууртай түлхүү давхцаж, харин мэдээллийн аюулгүй байдал, иргэдийн оролцоо, хэрэглээг хангах талаарх шаардлага тусгагдаагүй, тэдгээр нь MNS 6285:2017 стандартад тодорхой хэмжээнд тусгагдсан байна.

Зураг 8. Үнэлгээний аргачлалуудын харьцуулалт

Ерөнхий ангилал	Компанийн засаглалын ил тод байдлын шалгуур ба үнэлгээ			Цахим засаглал, цахим хуудсын үнэлгээний аргууд					
	S&P	OECD	Латин Америк	UN EGDI, OSI	Rutgers	IRIM	АТГ	ХУУЛЬ, ЖУРАМ	MNS 6285:2017
Хууль, эрх зүйн зохицуулалт ба тогтолцоо			Төрийн өмчит аж ахуйн нэгжийн харьяалагдах хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин;	Засаглалын тогтолцоо/ Хувь хүний өгөгдөл хамгаалах, Кибер аюулгүй байдал, Нээлттэй засгийн хууль ба бодлого		Эрх зүйн орчин/Мэдээлэл авах эрх, Иргэний нийгэм			
Дагаж мөрдөж буй хууль, журам ба хэрэгжилт					Контент/ Холбогдох дүрэм журам	Эрх зүйн орчин - Засаглал/ хуулийн хэрэгжилт, Зохицуулалтын чанар, ЗГ-ын үр нөлөөтэй байдал	Авлигын эсрэг манлайлал	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт/ Мөрдөж байгаа хууль, тогтоомж, хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан Авлигын эсрэг хууль, тогтоомж	Агуулгын шаардлага: хууль эрх зүй, дүрэм журам
Байгууллага, хувьцаа эзэмшигчийн бүтэц, засаглал	Эзэмшлийн бүтэц болон хувьцаа эзэмшигчдийн эрх	Засаглалын бүтэц, дүрэм, бодлого, хэрэгжилт	Өмчлөлийн томилогдсон төлөөлөгч үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа байдал;	Засаглалын тогтолцоо/ Засгийн газрын бүтэц, линкүүд	Контент/ Эрхэм зорилго, байгууллагын хаяг	Цахим ил тод байдал/ Нээлттэй мэдээллийн агуулга/ Үйл ажиллагаа/ Бүтэц, холбоо барих		Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт/ бүтэц зохион байгуулалт, хаяг	Агуулгын шаардлага: Байгууллагын бүтцийн танилцуулга, тушаал шийдвэр
	ТУЗ болон удирдлагын бүтэц, үйл ажиллагаа	Удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, шалгуур	Цөөнхийн хувьцаа эзэмшигчид (хэрэв байгаа бол) оршин тогтнох, эрх тэгш байх;	Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох.				Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал (ТӨХЭ-ийн УЗ, ХЗ, ГҮ-ын мэдээлэл)	
Хүний нөөц					Контент/ Ажилтнуудын мэдээлэл	Цахим ил тод байдал/ Нээлттэй мэдээллийн агуулга/ Үйл ажиллагаа/ Хүний нөөц	Хүний нөөцийн ил тод байдал,	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	Агуулгын шаардлага: Одоогийн бүрэлдэхүүн, Албан тушаалтан
Санхүүгийн тайлан, мэдээлэл	Санхүүгийн болон санхүүгийн бус тайлан	Санхүүгийн болон мэдээллийг тайлагнах Санхүүгийн тайланг аудитад хамруулах	Мэдээллийн ил тод байдал; (санхүү ба үйл ажиллагааны тайлан, аудит, стратеги, кодекс)	Цахим оролцоо/ Төсвийн мэдээлэл	Контент/ Төсвийн мэдээлэл	Цахим ил тод байдал/ Нээлттэй мэдээллийн агуулга/ Үйл ажиллагаа/ Төсөв санхүү, худалдан авах ажиллагаа	Төсөв санхүүгийн ил тод байдал,	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	Агуулгын шаардлага: Шилэн данс
Үйл ажиллагааны тайлан, мэдээлэл	Аудитын үйл ажиллагаа	Төрийн өмчит аж ахуйн нэгжийн жилийн тайланг эвб хуудсаар нийтлэх		Контент/ Үндэсний порталууд, Худалдан авах ажиллагаа	Төрийн өмчит аж ахуйн нэгжийн жилийн тайланг эвб хуудсаар нийтлэх	Цахим ил тод байдал/ Нээлттэй мэдээллийн агуулга/ Үйл ажиллагаа/ байгууллагаас гаргасан шийдвэр	Үйл ажиллагааны ил тод байдал,	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт/үйл ажиллагааны тайлан, хяналт шинжилгээ	Агуулгын шаардлага: үйл ажиллагааны танилцуулга, төлөвлөгөө, хөтөлбөр, тайлан
Үйлчилгээний мэдээлэл				Үйлчилгээ/ Онлайн үйлчилгээний боломжууд	Контент/ худалдан авах ажиллагаа, гэтгэлэг гм	Үйлчилгээ/ онлайнаар зөвшөөрөл авах, татвар төлөх	Цахим ил тод байдал/ Нээлттэй мэдээллийн агуулга/ Үйл ажиллагаа/ үзүүлж байгаа үйлчилгээ, нээлттэй өгөгдөл	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	Агуулгын шаардлага: үйлчилгээ, э-үйлчилгээ, үйлчилгээ авахад бүрдүүлэх материал
Мэдээллийн аюулгүй байдал					Нууцлал, аюулгүй байдал/ бодлого ба мэдэгдэл, хувийн мэдээлэл, тоон гарын үсэг, вирус шалгах боломж				Гүйцэтгэлийн шаардлага/ зөвшөөрөлгүй хандалтаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын зөвлөгөө
Технологи ба хэрэглээ	Тухайн орны хэл ба Англи хэл дээр байх			Технологи/ Хайлтын систем, Сайтын бүтэц, Түгээмэл асуулт, тусламж, чат, дата хандалт, эвб стандарт гм	Ашиглах үйц байдал, нүүр хуудасны урт, формат, хайлт хийх боломжууд	Контент/ GIS, яаралтай тусламж, мобайл хувилбар	Цахим ил тод байдал/ Технологи/ Технологийн нийцтэй байдал/ Мобайл хувилбар, хайлт, хурд, хэний сонголт	Цахим хуудасны үнэлгээ хялбар, ойлгомжтой эсэх, хайлтын систем	Нийтлэг шаардлага Зохиомжийн шаардлага
Олон нийтийн оролцоог хангах				Цахим оролцоо/ Чат, Feedback, Сошиал медиа харилцаа, авилгалыг мэдээлэх, олон нийтийн хэлэлцүүлэг	Иргэд ба нийгмийн оролцоо/ Иргэний онлайн оролцоо, хэлэлцүүлэг, чат, цахим хурал, иргэдээ судалгаа авах, иргэдийн сэтгэл ханамж, албан тушаалтанд үнэлгээ өгөх	Цахим ил тод байдал/ иргэдийн оролцоо ба харилцаа/ шууд харилцах боломж, нийгмийн сүлжээ, хандалтын тоо		Мэдээлэл харилцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр Олон нийтээс санал авч буй хууль, тогтоомж, иргэний санал	Агуулгын шаардлага: хэрэглэгчтэй харилцах, иргэдэд зориулсан тусламжийн хэсэгтэй байх
Бусад						Байгууллагын чадамж/ бэлэн байдал, манлайлал, тасралтгүй хөгжил ба сургалт		Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал/ Оюуны өмч, Газар, Мэдээлэл харилцагчийн зардлаар суралцагчийн мэдээлэл, Түншлэл, ХАСУМ хянасан тухай гм	

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

### 1.3.4 Цахим хуудасны хэрэглэгчийн туршлагыг үнэлэх аргууд

Мэдээллийг ил тод болгох, цахим хуудсанд байршуулах нь эцэстээ түүнийг хэрэглэгчид хүргэх зорилготой билээ. Хэрэглэгчийн чадавх, туршлагаас хамаарч, мэдээллийн ашиглагдах байдал харилцан ялгаатай байх бөгөөд цахим хуудасны хийц, загвар, зохион байгуулалт мөн чухал үүрэгтэй байх нь тодорхой юм.

Usability буюу хэрэглэхэд тохиромжтой байдал (эсхүл ашиглах чадвар) гэдэг нь хэрэглэгч тухайн бүтээгдэхүүнийг ашиглан өгөгдсөн даалгаврыг амжилттай биелүүлэх чадвар гэж үздэг бол user experience (UX) буюу хэрэглэгчийн туршлага нь илүү өргөн хүрээг хамардаг ба тухайн хүний бүтээгдэхүүнтэй харьцаж буй ерөнхий байдал, тэр харилцан үйлчлэлээс үүдэн бий болсон бодол, мэдрэмж, ойлголтыг авч үздэг (Bill & Tom, 2022).

ISO 9241 (*Ergonomics of human-system interaction*) стандартад “Usability”-ыг “Тодорхой хэрэглэгчид тодорхой орчинд тодорхой зорилгодоо хүрэх үр дүн (*effectiveness*), үр ашиг (*efficiency*), сэтгэл ханамж (*satisfaction*)” гэж тодорхойлсон.

Нейлсоны (1993 он) тодорхойлноор хэрэглэхэд тохиромжтой байдал (*usability*) нь олон талтай ба дараах 5 шинжийг агуулдаг гэсэн. Үүнд:

1. Сурахад хялбар (Easy to learn);
2. Хэрэглэхэд үр ашигтай (Efficient to use);
3. Санахад хялбар (Easy to remember);
4. Алдах магадлал бага (Low Error rate);
5. Хэрэглэгчийн сэтгэлд нийцсэн (Meets user satisfaction).

Эдгээр тодорхойлолтуудаас дүгнэхэд “Цахим хуудасны хэрэглэгчийн туршлага” гэдгийг хэрэглэгч тухайн цахим хуудаснаас хүссэн зүйлээ олж авч байгаа үр дүн, тэр нь тухайн хүний хэрэгцээг хангаж байгаа болон сэтгэл ханамжийн байдал гэж тодорхойлж болохоор байна.

Хэрэглэгчийн туршлагыг үнэлэхэд зан байдлыг шууд ажиглаж, хэмжих, асууж дүгнэлт хийх, эсвэл тусгай төхөөрөмж ашиглах гэх зэрэг олон аргууд байна.

UX metric буюу хэрэглэгчийн туршлагыг үнэлэх хэмжүүр (цаашид UX хэмжүүр гэх) нь туршилтын найдвартай системд суурилсан, ажиглалт хийх боломжтой (*observable*), тоогоор үр дүнг илэрхийлдэг (*quantifiable*) байх шаардлагатай. UX хэмжүүр нь хэрэглэгч ба бүтээгдэхүүн хооронд үүсч буй харилцааг буюу даалгаврыг бүрэн гүйцэтгэж чадсан эсэх үр дүн (*effectiveness*), зарцуулсан идэвх зүтгэл (*efficiency*), сэтгэгдэл, сэтгэл ханамжийн (*satisfaction*) байдлыг илрүүлдэг.

UX хэмжүүр нь судалгаа, мэдээлэлд суурилж шийдвэр гаргахад буюу дараах төрлийн асуултуудад хариу өгөхөд тусалдаг. Тухайлбал:

- Хэрэглэгч системийг хэрэглэснийхээ дараа өөр хэрэглэгчид санал болгох уу?
- Шинэ систем нь өмнөхөөсөө илүү сайн, үр ашигтай байж чадаж байна уу?
- Хэрэглэгчийн туршлагын байдал нь бусад өрсөлдөгчийнхтэй харьцуулахад хэр байна вэ?



- Хэрэглэгч тухайн системд хандсаны дараах сэтгэгдэл хэр байна вэ?
- Энэ системийг ашиглахад хамгийн чухал асуудал юу вэ?
- Загварыг шинэчилснээр сайжруулалт хийгдэж байна уу?

Билл, Том нар хэрэглэгчийн туршлагыг хэмжиж буй үзүүлэлтүүдийг дараах үндсэн 3 бүлэгт хувааж авч үзсэн:

1. Гүйцэтгэл (User Performance)
2. Сонголт, сэтгэл ханамж (User Preferences)
3. Сэтгэл хөдлөл, мэдрэмж (User Emotions)

### ***Гүйцэтгэлийг хэмжих нь***

Хэрэглэгч өгөгдсөн даалгаврыг амжилттай гүйцэтгэж чадах түвшин буюу даалгавар болон үйлдэл бүрийг гүйцэтгэх хугацаа, хийсэн оролдлогууд, гаргасан алдааны тоо, суралцах чадварыг хэмждэг.

### ***Хэрэглэгчийн сонголт, сэтгэл ханамжийг хэмжих нь***

Хэрэглэгчийн сонголтын хувьд сайн, муу, зөв буруу гэж байдаггүй. Жишээлбэл, нэг хэрэглэгч мэдээллээр баялаг системийг илүүд үздэг бол өөр хэрэглэгч илүү оновчтой дизайныг илүүд үздэг байж болох ба аль нь ч зөв эсвэл буруу биш юм. Харин аль төрлийн систем нь тэдэнд хамгийн ашигтай байх вэ гэдэг нь чухал. Хэрэглэгчийн сонголтыг хэмжих нь хэрэглэгчийн хамгийн сайн туршлагыг бий болгох чухал элемент юм.

### ***Сэтгэл хөдлөл, мэдрэмжийг хэмжих нь***

Одоо үед хэрэглэхэд хялбар, үр ашигтай бүтээгдэхүүн зохион бүтээх нь хангалтгүй бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өрсөлдөөний давуу талыг хадгалахын тулд илүү сайн сэтгэл хөдлөлийн үр дүнд хүргэх шаардлагатай болсон. Хэрэглэгчийн сэтгэл хөдлөл нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, ашиглалтын нөхцөл байдлаас хамааран ихээхэн ялгаатай байж болно. Зарим бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгчдэд илүү их итгэлийг бий болгоход чиглэдэг бол бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ нь оролцоог нэмэгдүүлэхэд чиглэдэг. Зарим бүтээгдэхүүн, үйлчилгээ нь өөрсдийн брэндийн стратегид нийцүүлэхийн тулд илүү эерэг мэдрэмжийг бий болгохыг хүсдэг.

Дараах Хүснэгт 10-д хэрэглэгчийн туршлагыг хэмжих үзүүлэлт болон түүнд хамаарах аргуудыг харуулав.

Хүснэгт 10. *Хэрэглэгчийн туршлагыг хэмжих үзүүлэлт ба хэмжих аргууд*

<b>Хэрэглэгчийн туршлагыг хэмжих үзүүлэлтүүд</b>		
<b>1. Гүйцэтгэл</b> <i>Performance</i>	<b>2. Сонголт, сэтгэл ханамж</b> <i>Preference</i> (Satisfaction, expectation, ease of use, confidence, usefulness, awareness)	<b>3. Сэтгэл хөдлөл</b> <i>Emotions</i> (Joy, engagement, stress)
Хэмжих аргууд:		

<ul style="list-style-type: none"> <li>○ Даалгаврын биелэлт (Task success)</li> <li>○ Даалгаврын хугацаа (Task time)</li> <li>○ Алдаа (Errors)</li> <li>○ Үр дүн (Efficiency)</li> <li>○ Суралцах чадвар (Learnability)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>○ <b>Өөрөө мэдээлэх хэмжүүр (Self-reported metrics)</b></li> <li>5, 11 оноогоор үнэлдэг асуулгын олон аргууд бий. ASQ, SUS, CSUQ, Cards, UEQ, AttracDiff, NPS, <b>WAMMI</b></li> <li><b>Нүдний хөдөлгөөн дагах (Eye tracking 7.)</b></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>○ Аман илэрхийлэл (Verbal expression)</li> <li>○ Өөрөө мэдээлэх (Self-report)</li> <li>○ Нүүрний хувирал (Facial expression)</li> <li>○ Галваник арьсны хариу үйлдэл (Galvanic skin response)</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>○ Асуудалд суурилсан арга Usability – Issue based metric</li> <li><i>Frequency, severity, type of issue</i></li> </ul>	

Эх сурвалж: William Albert, Thomas S. Tullis, 2023, *Measuring the user experience 3<sup>rd</sup> edition*

Ямар аргыг сонгох нь судалгааны зорилгоос хамаарна. Дараах Зураг 9-д хэрэглэгчийн туршлагыг үнэлэх хамгийн түгээмэл байдаг 10 зорилго болон тэдгээрийг хэмжих боломжит аргуудыг харуулав.

Зураг 9. Хэрэглэгчийн туршлагыг судлах зорилго ба хэмжих аргын хамаарал

Хэрэглэгчийн туршлагыг судлах зорилго		Хэмжих аргууд										
		Даалгаврын биелэлт	Гүйцэтгэх хугацаа	Алдаа	Үр ашиг	Суралцах чадвар	Асуудалд суурилсан метрик	Өөрөө мэдээлэх	Нүдний хөдөлгөөн дагах ба биометрик	Нэгдмэл ба харьцуулах метрик	Live Website метрик	Карт ангилах/ модны тест
1	Гүйлгээг бүрэн гүйцэтгэх	X			X		X	X			X	
2	Бүтээгдэхүүнийг харьцуулах	X			X			X		X		
3	Адил бүтээгдэхүүний байнгын хэрэглээг үнэлэх	X	X		X	X		X				
4	Навигац ба мэдээллийн архитектурыг үнэлэх	X		X	X							X
5	Мэдлэгийг нэмэгдүүлэх							X	X		X	
6	Асуудлыг илрүүлэх						X	X				
7	Гол бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх	X		X	X							
8	Хэрэглэгчийн эерэг ерөнхий туршлагыг бүтээх							X	X			
9	Дизайны өөрчлөлтийн нөлөөллийг үнэлэх										X	
10	Өөр загваруудыг харьцуулах	X	X				X	X		X		

Эх сурвалж: William Albert, Thomas S. Tullis, 2023, *Measuring the user experience 3<sup>rd</sup> edition*

Зураг 9-өөс үзэхэд Мэдлэгийг нэмэгдүүлэх (Increasing awareness) болон Нийтлэг эерэг хэрэглэгчийн туршлагыг бүтээх (creating an overall positive user experience)

зорилгоор “Нүдний хөдөлгөөн дагах биометрик” хэмжүүрийг ашиглах нь тохиромжтой гэсэн байна.

### ***Хэрэглэгчийн туршлагыг хэмжих аргууд***

Хэрэглэгчийн туршлагыг хэмжих аргуудаас хамгийн түгээмэл, өргөн хэрэглэгддэг мөн судалгаанд ашиглах боломжит дараах аргуудыг сонгон авч үзлээ.

***Даалгаврын биелэлт*** (task success) хэмжих нь хамгийн өргөн хэрэглэгддэг хэмжигдэхүүн ба хэрэглэгч өгөгдсөн даалгаврыг хэр зэрэг үр дүнтэй биелүүлснийг хэмжинэ. Даалгаврын биелэлтийг хэмжих хоёртын системийн (binary) болон түвшний (level) гэсэн 2 арга байна. Хоёртын системийн арга нь 0, 1 буюу тийм, үгүй гэсэн сонголтоор үнэлгээ өгч, даалгавар тус бүрээр болон оролцогч тус бүрээр нийт даалгаврын хэдэн хувийг гүйцэтгэсэн гэдгийг тооцно. Харин түвшний арга нь “туслалцаатай бүрэн”, “туслалцаагүй бүрэн”, “туслалцаатай бүрэн бус”, “туслалцаагүй бүрэн бус” “биелүүлж чадаагүй” гэх мэтээр түвшинд хувааж үнэлдэг.

***Даалгавар гүйцэтгэсэн хугацаа*** (task time) нь мөн хамгийн түгээмэл хэмжүүр юм. Ерөнхийдөө оролцогч даалгаврыг хурдан гүйцэтгэх тусам хэрэглэгчийн туршлага сайн гэж үзэх боловч, зарим тохиолдолд үнэн байдаггүй. Даалгавар гүйцэтгэсэн хугацааг автомат систем ашиглан тооцох нь тохиромжтой.

***Системийн хэрэглээний оноог*** (System Usability Score-SUS) 1986 онд Жонн Брүүк анх хөгжүүлсэн. Энэ арга нь хэрэглэгчийн сэтгэгдлийг үнэлэх эерэг 5, сөрөг 5 асуулга бүхий нийт 10 асуулгаас бүрддэг ба 5 шатлалаар үнэлгээ өгдөг. Үнэлгээ тооцохдоо асуулга бүрд 0-4 оноо өгнө. 1, 3, 5, 7, 9-р асуултын хариултын шатлалаас нэгийг хасаж оноог тооцно. Харин 2, 4, 6, 8, 10-р асуултын хариултын шатлалаас тавыг хасаж оноог тооцно. Онооны нийлбэрийг 2.5-аар үржүүлж SUS оноог гаргана.

***Website Analysis and Measurement Inventory (WAMMI)*** буюу Цахим хуудасны анализ ба хэмжилтийн үнэлгээний онлайн аргыг 1998 онд Ирландын Корк их сургуулийн Хүний хүчин зүйлийн судалгааны багаас хөгжүүлсэн. Тус үнэлгээг [www.wammi.com](http://www.wammi.com) цахим хуудсаар дамжуулан хийх боломжтой. Тус багаас гаргасан, үүнтэй төстэй аппликэйшн үнэлэх аргыг нь SUMI гэж нэрлэдэг байна. WAMMI нь Likart-ийн 5 шатлал бүхий 20 асуулгатай. Үр дүнгээр нь сонирхолтой байдал (Attractiveness), хяналттай байдал (Controllability), үр ашигтай байдал (Efficiency), ашиг тустай байдал (Helpfulness), суралцах чадвар (Learnability) гэсэн 5 чиглэлээр шинжилгээ хийх боломжтой.

***Eye tracking*** буюу Нүдний хөдөлгөөн дагах арга нь цахим хуудас болон мобайл аппликэйшн зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээ дэх дизайны үр нөлөөг харьцуулах, харааны анхаарлыг хэмжих хамгийн тохиромжтой арга гэж үздэг.

Нүдний хөдөлгөөн хэмжихэд ихэвчлэн хэт ягаан туяаны технологи ашигладаг бөгөөд нүдний эвэрлэгийн тусгалын байрлалыг хүүхэн хараатай харьцуулснаар харааны чиглэлийг тооцоолдог байна. Нүдний хөдөлгөөний замын дүрслэл нь тухайн хүний хэзээ, юуг харж байсан тухай түүхийг өгүүлдэг. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг дүрслэл бол нүдний бэхэлгээний хөдөлгөөн, түүний үргэлжлэх хугацааг харуулсан замууд, мөн харааны анхаарлын хуваарилалтыг дүрсэлсэн дулааны зураг юм. Нүдний хөдөлгөөний

хэмжилтийн үр дүнд анализ хийх хамгийн түгээмэл арга бол Areas of Interest (AoI) буюу Сонирхлын талбаруудыг тодорхойлох арга гэж үздэг. Сонирхлын талбарууд гэдэг нь дэлгэц дээрх текст, функцууд, эсвэл дүрс гм объектуудыг хэлнэ. Нүдний хөдөлгөөн хэмжихэд тэдгээр талбаруудыг харахад зарцуулсан хугацаа, харсан дараалал, анх хараа тогтсон байршил зэргийг авч үздэг.

## **II БҮЛЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Энэхүү бүлэгт сэдвийн судалгааны объект болж буй Монгол Улс дахь ТӨК-ийн өнөөгийн нөхцөл байдал, тэдгээрийн мэдээллийн ил тод байдлын харилцааг зохицуулж буй холбогдох хууль эрх зүйн орчны талаар тодорхойлсон болно.

### **2.1 Монгол Улс дахь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын өнөөгийн байдал**

Монгол Улсад 1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Тус хуулийн 21 дүгээр зүйлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлогийг зохицуулж өгсөн байна.


Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг **төрийн өмчит хуулийн этгээд**, төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг **төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд** гэж тодорхойлж өгсөн.

Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь (i) төрийн байгууллага; (ii) төрийн өмчит үйлдвэрийн газар; болон (iii) төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг гэж ангилна. Төрийн өмчит үйлдвэрийн газарт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (ААТҮГ) улсын төсөвт үйлдвэрийн газар (УТҮГ) гэх бөгөөд өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг ААТҮГ, өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг УТҮГ гэж тодорхойлсон байна.

Засгийн газрын 2016 оны №80 тоот Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журамд зааснаар нийт гаргасан энгийн хувьцааг нь 100 хувь төр эзэмшдэг компани болон нийт гаргасан энгийн хувьцааны тодорхой хувийг нь төр эзэмшдэг компанийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд тооцохоор зохицуулсан байна.

ЗГХЭА, ТӨБЗГ-аас гаргасан мэдээллээс үзвэл ТӨҮГ 21, ТӨХК 51, ТӨХХК 21, ТӨОК 12 буюу нийт 105 хуулийн этгээд байна. (Зураг 10-ыг үзнэ үү)


Зураг 10. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоо



ТӨК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгчийн хувьд авч үзвэл ЗГХЭГ 17, Эрчим хүчний яам 26, Сангийн яам 7, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам 2, Зам тээврийн хөгжлийн яам 2, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 1, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 49 буюу нийт 105 хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг гаргасан байна (Зураг 11-ийг үзнэ үү).

Эх сурвалж: ТӨБЗГ, 2022

Зураг 11. ТӨК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч



Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа дээр дурдсан хуулийн зохицуулалтыг дүгнэж үзээд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын гаргасан мэдээлэлд дурдсан төрийн өмчит хуулийн этгээд болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх зүйн хэлбэр тодорхойгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Эх сурвалж: ТӨБЗГ, 2022

Төрийн өмчит хуулийн этгээдийн шинэчлэлийн бодлогын хүрээнд ТӨК-ийн засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор нэмж хувьцаа гарган, хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд санал болгох шийдвэрийг төрийн эрх барих дээд байгууллага, гүйцэтгэх байгууллагаас гаргаад байна.

Улсын Их Хурлын 2022 оны №16 тоот тогтоолоор Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл баталсан. Улсын Их Хурлын тус тогтоолоор 25 төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын Хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгохоор шийдвэрлэсэн.

Улмаар ЗГ-ын 2022 оны №244 тоот тогтоолоор төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн

жагсаалтыг баталж, төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг биржээр худалдахтай холбогдсон арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу авч хэрэгжүүлэх, шаардагдах эх үүсвэрийг тооцож, зохих ёсоор шийдвэрлэж ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгаж шийдвэрлэсэн байна.

ТӨБЗГ-ын 2022 оны №336 тоот Нэмэлт хувьцаа гаргах тухай тогтоолоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 25 хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт хувьцааг гаргаж, Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгохоор шийдвэрлэсэн.

Төрийн эрх барих дээд байгууллага, гүйцэтгэх байгууллагаас нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулж, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн тэдгээр 25 ТӨК-ийн мэдээллийг ЗГХА, Улсын бүртгэлийн ерөнхий газрын нээлттэй мэдээлэл цахим хуудаснаас нягталж үзэхэд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн мэдээлэл болон эцсийн өмчлөгчийн мэдээлэл тодорхойгүй, эсхүл иргэнээр бүртгэгдсэн, эсхүл Төрийн өмчийн хороо гэж хуучин нэрээр бүртгэгдсэн зөрүүтэй мэдээлэл байна (Хүснэгт 11-ийг үзнэ үү). Иймд нийтэд нээлттэй хэлбэрээр үйл ажиллагаа явуулах ТӨК-ийн улсын бүртгэлийн мэдээлэл зөрчилтэй байна.

*Хүснэгт 11. 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт*

№	ТӨК	Хуулийн этгээдийн хэлбэр	ХЭХ-ын эрхийг хэрэгжүүлэгч	Эцсийн өмчлөгч	Төрийн хувь эзэмшлийн хэмжээ
1.	Монголын Хөрөнгийн бирж ТӨХК	ТӨХК	Төрийн өмчийн хороо	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй
2.	Монголын цахилгаан холбоо ТӨХК	ТӨХК	Мэдээлэл тодорхойгүй	Тохирох мэдээлэл олдсонгүй	Мэдээлэл тодорхойгүй
3.	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	ТӨХХК	ТӨБЗГ	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй
4.	Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ	ААТҮГ	Харилцаа Холбоо, Мэдээллийн Технологийн Газар	Тохирох мэдээлэл олдсонгүй	100%
5.	Үндэсний давхар даатгал ХК	ХК	Сангийн яам	Б.Жавхлант	100%

6.	Баянчандмань АЗЗА ТӨХК	ТӨХК	Иргэн Ц.Цогтбаатар	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй
7.	Налайх АЗЗА ТӨХК	ТӨХК	Иргэн М.Лут-Очир	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй
8.	Архангай АЗЗА ТӨХК	ТӨХК	Иргэн Д.Батцолмон	Иргэн С.Нэргүй	Тодорхойгүй
9.	Багануур АЗЗА ТӨХК	ТӨХК	Му-Ын Газар	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй
10.	Булган АЗЗА ТӨХК	ТӨХК	ТӨБЗГ	Тохирох мэдээлэл олдсонгүй.	100%
11.	Говь Алтай- АЗЗА ТӨХК	ТӨХК	Иргэн Говь-Алтай Азза	Иргэн Ш.Тогтмол	Тодорхойгүй
12.	Дархан АЗЗА ТӨХК	ТӨХК	Иргэн Н.Пүрэвбат	Тохирох мэдээлэл олдсонгүй.	Тодорхойгүй
13.	Дорноговь АЗЗАТӨХК	ТӨХК	Иргэн А.Баттогтох	Иргэн У.Баярбилэг	Тодорхойгүй
14.	Завхан АЗЗА ТӨХК	ТӨХК	Иргэн М.Болд	Тохирох мэдээлэл олдсонгүй.	Тодорхойгүй
15.	Орхон АЗЗА ТӨХК	ТӨХК	Төрийн өмчийн хороо	Иргэн Ц.Батзориг	100%
16.	Өвөрхангай- АЗЗА ТӨХК	ТӨХК	Төрийн өмчийн хороо	Тохирох мэдээлэл олдсонгүй.	100%
17.	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	ХК	Л.Ганболд	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй
18.	Талын зам ТӨХК	ТӨХК	Л.Батбаяр	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй
19.	Төв АЗЗА ТӨХК	ТӨХК	Төрийн Өмчийн Бодлого, Зохицуулалтын Газар	Тохирох мэдээлэл олдсонгүй	100%
20.	Увс АЗЗА ТӨХК	ТӨХК	Төрийн Өмчийн Хороо	Р.Төмөрчөдөр	100%
21.	Харгуй ТӨХК	ТӨХК	Төрийн Өмчийн Хороо	Л.Батоктябрь	100%

22.	Хархорин АЗЗА ТӨХК	ТӨХК	Д.Дашцэрэн	Ж.Бадрах	Тодорхойгүй
23.	Ховд АЗЗА ТӨХК	ТӨХК	Ховд Азза	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй
24.	Хөвсгөл АЗЗА ТӨХК	ХК	Төрийн Өмчийн Бодлого, Зохицуулалтын Газар	Б. Галбадрах	100%
25.	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨХК	Эрдэнэсант Азза	Тохирох мэдээлэл олдсонгүй	Тодорхойгүй

Эх сурвалж: <http://opendata.burtgel.gov.mn/>

Өнөөдрийн байдлаар дээр дурдсан хуулийн этгээдээс Монголын Хөрөнгийн бирж ТӨХК болон Үндэсний давхар даатгал ХК нь нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлж, компанийн хэлбэрийг нээлттэй болгох зөвшөөрлөө холбогдох төрийн зохицуулагч байгууллагаас авсан байна.

## 2.2 Мэдээллийн нээлттэй, ил тод байдалтай холбогдох хууль болон журам

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэгт “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний энэхүү үндсэн эрхэд хамаарах төр, түүний байгууллагаас мэдээлэл хүлээн авах эрхийн хэрэгжилтийн баталгааг хангах зорилгоор Улсын Их Хурлаас анх 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталсан. Тус хууль нь 6 бүлэг, 25 зүйлтэй.

Улмаар Монгол Улсын хувьд Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Олон Улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенци соёрхон батлах тухай хуулийг баталж, нэгдэн орсон. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Цахим засгийн талаарх судалгааг гишүүн улс бүрээр 2 жил тутамд авч танилцуулдаг.

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан нь өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод явуулах зорилгоор олон нийтэд нээлттэй байдлаар хүргэж



байсан мэдээллээс шаардлагагүй мэдээллийг байршуулахыг хасаж, шаардлагатай олон төрлийн мэдээллийг цахим хуудаст байршуулахаар хуульчилсан байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн харьцуулалтыг Хавсралт 1 -ээс үзнэ үү.

Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй Мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний мэдээлэл хайх, мэдээлэл авах эрхийг бодитой хэрэгжүүлэх мэдээлэл авах журмыг нарийвчлан тодорхойлсны зэрэгцээ иргэнийг мэдээллээр хангах мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан байна. Тодруулбал мэдээлэл хариуцагч үйл ажиллагааныхаа олон нийтэд хүргэх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгслийг ашиглах, мэдээллийн бусад хэрэгслийг ашиглаж байгаагаас үл хамааран цахим хуудаст хууль болон журамд тодорхойлсон мэдээллийг цахим хуудсаар мэдээлэх харилцааг зохицуулсан байна гэж үзэж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу ЗГ-аас 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн №352 тоот тогтоолоор Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмыг баталсан.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд 8 бүлэг, 38 зүйлтэй. Тус хуулийн зорилго нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино. Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг тус хуулиар зохицуулахгүй байхаар хуульд тусгасан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд нийтийн мэдээлэл хариуцагч нь дараах хуулийн этгээд байхаар хуульчилсан. Үүнд:

1. Төрийн байгууллага;
2. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд;
3. Хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд;
4. Олон нийтийн радио, телевиз;
5. Улс төрийн нам.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд нийтийн мэдээллийг дараах 3 төрөлд ангилсан. Үүнд:

1. **Нээлттэй мэдээлэл:** Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ.
2. **Хязгаарлалттай мэдээлэл:** Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ (Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй);

3. **Хаалттай мэдээлэл:** Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл гэж үзнэ.

Хуулийн зохицуулалтад үндэслэж үзвэл мэдээлэл хариуцагч нь 5 ангиллын 67 төрлийн мэдээллийг нээлттэй байлгах ёстой. Иймд төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дараах Хүснэгт 12-д заасан мэдээллийг ил тод, нээлттэй байлгах үүрэг хүлээсэн.

Хүснэгт 12. *Нээлттэй мэдээллийн ангилал*

№	Нээлттэй мэдээллийн ангилал	Нээлттэй мэдээллийн тоо
1.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	10
2.	Хүний нөөц	6
3.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	27
4.	Хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээ	2
5.	Өөрийн эрхлэх үйл ажиллагааны хүрээ дэх мэдээлэл	22
<b>Нийт</b>		<b>67</b>

*Эх сурвалж: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 2021*

Төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зорилгын хүрээнд олон нийтэд заавал нээлттэй, ил тод байх мэдээллийн жагсаалтыг хуулиар тогтоож, хязгаарласан мэдээллийг зөвшөөрөлтэйгөөр олгодог эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Түүнчлэн иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах зохицуулалтын хүрээнд мэдээлэл хариуцагчийн 67 мэдээллийг цахим хуудаснаас авах эрхийг хангах, баталгаажуулах, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгахад чиглэсэн хууль болсон байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдсанаар төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай, хариуцлагатай болгох, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах эрх зүйн орчин бүрдэж, иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэнэ.

Түүнчлэн төрийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод болсноор хүнд суртал, авлига, ашиг сонирхлын аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэх, төрийн мэдээлэл, үйлчилгээг биечлэн хандаж авахаас гадна цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахим хэлбэрээр авах боломж бүрдэж байна. Иргэд төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох боломж нэмэгдэж, төрийн мэдээлэл, үйлчилгээ авахтай холбоотой үүсдэг байсан зардал болон цаг хугацаа хэмнэгдэнэ. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлчилгээний чанар, хүртээмж, хариуцлага, ил тод байдал дээшилнэ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэгт заасан “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр,

байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална”, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл заасан “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж тус тус заасантай нийцэж байна.

Түүнчлэн Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний мэдээлэл авах эрхийг бодитой хэрэгжүүлэхийн тулд хуульд иргэн мэдээлэл авах журмыг нарийвчлан зааснаас гадна иргэнийг мэдээллээр хангах төрийн үүргийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байхаар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран цахим хуудсыг заавал ажиллуулж байх зохицуулалтыг тусгасан байна. Үүнээс гадна төрийн байгууллага хооронд болон төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдтэй мэдээлэл солилцоход ашиглах зорилгоор нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан нь төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, цахим хэлбэрээр явуулахаар хуулиар зохицуулсан байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийг ил тод байлгах асуудлыг, Шилэн дансны тухай хуулиар төрийн байгууллагуудын төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, тэдгээртэй холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байх харилцааг зохицуулсан байна.

### **2.3 Нээлттэй ХК-д тавигдаж буй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт**

ЭЗХАХБ-аас 2015 онд гаргасан “Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын удирдамж”-ийн Өмнөх үг хэсэгт “Энэхүү удирдамж нь ТӨК-ийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага нь хамгийн багадаа хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргасан нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээх хариуцлагын хэмжээнд байж чадах тэр нөхцөлийг хангах зөвлөгөөгөөр төр, засгийг хангана” хэмээсэн бөгөөд улмаар удирдамжийн 6-р хэсэг буюу Ил тод, нээлттэй байдлын зарчмын үндэслэлийг дараах байдлаар тодорхойлсон.

*“ТӨК нь ил тод байдлын талаар тавигдаж буй өндөр стандартыг анхаарах ёстой бөгөөд нээлттэй компанийн адилаар санхүүгийн, ил тод байдлын, нийцлийн болон аудитын стандартын өндөр шаардлагыг биелүүлэх ёстой. (State-owned enterprises should observe high standards of transparency and be subject to the same high quality accounting, disclosure, compliance and auditing standards as listed companies)”* (OECD, 2015).

Иймд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд нээлттэй, ил тод болгохоор шаардсан мэдээллүүд нь манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нээлттэй компани болоход тавигдаж буй мэдээллийн шаардлага болон нээлттэй болсны дараа нээлттэй, ил тод байлгах мэдээллийн хууль, зохицуулалтын шаардлагатай хэрхэн уялдаж байгаа харьцуулсан судалгааг хийсэн бөгөөд харьцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-д оруулав.

Монгол Улсад одоогоор нээлттэй хувьцаат компани болох болон нээлттэй хувьцаат компани болсны дараа дагаж мөрдөх шаардлагатай Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, зохицуулагч байгууллагуудаас батлан гаргасан дараах хууль тогтоомжийн эрх зүйн орчин үйлчилж байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013.05.24);
- СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №225 тоот тогтоолоор батлагдсан **Үнэт цаасны бүртгэлийн журам**;
- МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 тоот тогтоолоор батлагдсан **Үнэт цаасны бүртгэлийн журам**;
- СЗХ-ны 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн №268 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаанд зайны хяналт тавих журам;
- СЗХ-ны 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн №72 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам;
- МХБ-ийн 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн №08 тоот тогтоолоор батлагдсан МХБ-ийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд мэдээлэл хүргэх журам.

Уг харьцуулалтаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх журмын хүрээнд нээлттэй болгохоор заасан мэдээллүүдийн хувьд ТӨК-ийн ерөнхий үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээлэл болон төсөв, санхүү, худалдан авах үйл ажиллагааны талаарх мэдээллүүдийн хүрээнд илүү өргөн хүрээний мэдээллийг ил тод болгохыг шаардсан байгаа нь харагдаж байна. Хэдий тийм боловч нээлттэй хувьцаат компани болоход тавигдаж буй хууль тогтоомжийн шаардлагын хүрээнд мэдээлэх ёстой дараах мэдээлэл байна. Үүнд:

- *Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;*
- *“Компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршилагын байдал болон эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, түүний шаардлага;*
- *Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;*
- *Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;*
- *Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;*
- *Аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх, татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх.*

Иргэдийн мэдэх эрхийг хэрэгжүүлэх, нээлттэй хувьцаат компани болох ТӨК-ийн үйл ажиллагаанд хяналт тавихад ач холбогдолтой мэдээллийг бүрэн хамарч чадаагүй болохыг Хавсралт 2 дахь харьцуулалтаас харж болохоор байна. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх үндсэн зорилго болсон ТӨК-ийн засаглал, ил тод, нээлттэй байдлыг сайжруулахад шаардлагатай мэдээллийн шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо “Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын удирдамж”-д зөвлөсний дагуу нээлттэй хувьцаат компанид хууль тогтоомжоор тавигдаж буй нээлттэй мэдээллийн шалгуур үзүүлэлтийг мөн харгалзан үзэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

### III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Зураг 8-д дурдсан компанийн засаглалын ил тод байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд болон цахим ил тод байдлыг үнэлэх үнэлгээний аргуудыг нийт 9 үзүүлэлтээр харьцуулж үзэхэд Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам нь нийт 6 үзүүлэлтийг хамарч байгаа нь харьцангуй өргөн хүрээтэй болохыг илэрхийлж байна. Харин цахим ил тод байдал талаасаа буюу технологи, мэдээллийн аюулгүй байдал, иргэдийн оролцоог хангах, хэрэглэхэд хялбар ойлгомжтой байх чиглэлийн үзүүлэлт тусгагдаагүй байна. Иймд эдгээр үзүүлэлтийг шалгах боломжтой бусад аргуудыг харьцуулж, асуулгын хувьд харьцангуй оновчтой, байгууллагын цахим хуудсыг үнэлэхэд тохиромжтой, техникийн нарийн ур чадвар шаардахгүй, олон улсад хэрэглэж туршигдсан зэргийг харгалзан “Rutger -ийн цахим засгийн гүйцэтгэлийн индекс” аргыг 2 дахь аргаар сонгож авав. Цахим хуудаст үнэлгээ хийхээр сонгосон аргууд:

1. ЗГ-аас баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”;
2. Rutger -ийн цахим засгийн гүйцэтгэлийн индекс.

#### 3.1 Судалгааны хүрээ ба дизайн

Судалгаанд ТӨК-аас дараах 2 шалгуур үзүүлэлтийн дагуу нийт 39 компанийг сонгож авсан. Үүнд:


1. ТӨК-ийг олон нийтийн шууд хяналтад оруулах бодлогын хүрээнд ЗГ-ын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн №244 дүгээр тогтоолоор Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг баталсан. Тус жагсаалтад **нийт 25 ТӨК** багтсан бөгөөд эдгээр хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, хувьцаа гаргах бэлтгэл хангах, биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгож, өөрчлөн байгуулах ажлыг ЗГ-аас зохион байгуулж эхлээд байна. Иймд эдгээр компаниуд нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, журмын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгааг үнэлж, харьцуулж үзэхийг зорив.

2. ЗГ, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим хамтран ТОП-100 аж ахуйн нэгжийг эрэмбэлэх, өргөмжлөх үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг бөгөөд ТОП-100 аж ахуйн нэгжийг эрэмбэлэхдээ аж ахуйн нэгжийн тухайн жилийн орлого, улсын төсөвт оруулсан татвар, нийгмийн даатгал төлсөн ажиллагсдын тоо, ашиг, хөрөнгийн хэмжээ гэсэн үндсэн 5 үзүүлэлтэд тулгуурладаг байна. 2021 оны ТОП-100 компанид **15 ТӨК** багтсан байна. Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж байгаа эдгээр ТӨК-ийн хувьд мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг үнэлж, харьцуулж үзэхээр сонгов.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь дээр дурдсан хоёр ангилалд хамаарч байгаа болно. Судалгаанд хамрагдсан ТӨК-ийн мэдээллийг Хавсралт 3 болон тэдгээр ТӨК-ийн товч танилцуулгыг Хавсралт 4-өөс үзнэ үү.

ТӨК нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, компанийн засаглалыг сайжруулах, үйлчилгээгээ олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор цахим хуудсаараа холбогдох мэдээллийг ил тод болгож байгаа хэдий ч мэдээлэл нь иргэдэд хэр зэрэг хүрч, иргэдийн мэдэх эрхийг хангаж байгаа талаар хийгдсэн тодорхой үнэлгээ, судалгаа байхгүй байна. Иймд Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам болон олон улсын Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн үзүүлэлтээр сонгосон компаниудын цахим хуудаст үнэлгээг гүйцэтгэж, үнэлгээний нэгдсэн дүнгээр хамгийн өндөр оноо авсан 2 компанийн цахим хуудасны хэрэглэхэд тохиромжтой байдал, хэрэглэгчийн туршлагыг нейро болон чанарын судалгааны аргачлалаар шинжилгээ хийхээр төлөвлөв. Судалгааны ерөнхий дизайныг Зураг 12-т харуулав.

Зураг 12. Судалгааны дизайны зураглал



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

### 3.2 Өгөгдөл цуглуулах ба шинжилгээ хийх арга

#### 3.2.1 Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам

Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журамд үнэлгээ хийх нийт 5 бүлгийн 71 мэдээлэл тодорхойлноос төрийн өмчит компанид хамаарах 44 мэдээлэл байна гэж үзсэн. Үнэлгээнд хамаарахгүй гэж үзсэн мэдээллийн жагсаалтыг Хавсралт 5-аас үзнэ үү. Судалгааны багийн зүгээс үнэлгээг илүү нарийвчлан хийх зорилгоор тэдгээр 44 мэдээллийг дахин ангилж, нийт 100 мэдээлэл болгон өргөжүүлсэн. Эдгээр мэдээллийн жагсаалтын Хавсралт 6-аас үзнэ үү.

Мэдээлэл тус бүрийг цахим хуудсанд байрлуулсан эсэхээс хамаарч, журамд заасан аргачлалын дагуу “хангалттай”, “дутуу”, “хангалтгүй” гэж үнэлэн хангалттай бол 30, дутуу бол 15 эсвэл 10 (тухайн үзүүлэлтээс хамаарч), “хангалтгүй” бол 0 оноогоор харгалзуулан оноогоор үнэлнэ. Тухайн мэдээллийн цахим хуудаст байрлуулсан байдлыг

журамд заасны дагуу мэдээллийн хүртээмж, хугацаандаа нийтлэгдсэн байдал, бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал гэсэн 4 шалгуураар үнэлнэ.

Бүлэг тус бүрийн мэдээллийн тооноос хамаарч авбал зохих оноо ялгаатай байна. Судалгааны баг ангиллыг өргөжүүлсэн ч бүлэг тус бүрд авбал зохих оноонд өөрчлөлт орохгүй. Хүснэгт 13-д журмын дагуух нийтийн мэдээллийн ангилал болон хэмжин үзүүлэлтийн тоо, оноог харуулав.

Хүснэгт 13. Журмын дагуу нийтийн мэдээллийн ангилал, хэмжүүр

Мэдээллийн ангилал	Үндсэн мэдээллийн	Хамаарах мэдээллийн	Судалгааны багийн ангилсан мэдээллийн	Авбал зохих оноо	Үнэлгээний ерөнхий онооны хувь тооцох аргачлал
Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	10	10	25	1,200	Мэдээллийн ангилал тус бүрийн онооны хувийн арифметик дундаж
Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	6	7	720	
Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	28	14	31	3,360	
Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	2	2	10	240	
Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	25	12	27	3,000	
Нийт	71	44	100	8,520	

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

### 3.2.2 Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индекс

Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индекс нийт 5 бүлэг, 106 асуулгатай бөгөөд бүлэг тус бүр цахим хуудасны өөр өөр шалгуур үзүүлэлтүүдийг хэмждэг. Бүлэг бүр 18-26 асуулгатай, асуулгын бүтэц болон зорилгоос хамааран ялгаатай онооны системтэй (Хүснэгт 14-өөс үзнэ үү).

Хүснэгт 14. Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн онооны систем

Онооны систем	Тайлбар
0;1	0=Үгүй; 1=Тийм.
0;1;2	0=Үгүй; 1=асуулгын анхан шатны мэдээллийг агуулсан, мэдээллийг асуулга тус бүрд тайлбарлан бичсэн байсан; 2=Асуулгын зорилтод мэдээллийг агуулсан.
0;1;3	0=Үгүй; 1=Асуулгын анхан шатны мэдээллийг агуулсан, мэдээллийг



	асуулга тус бүрд тайлбарлан бичсэн байсан; 3=Асуулгын зорилтод мэдээллийг агуулсан.
0;1;2;3	0=Үгүй; 1, 2, 3 оноо асуулга тус бүрийн зорилгоос хамааран өөр өөр шалгуур үзүүлэлттэй.
0;3	0=Үгүй; 3=Тийм.

Эх сурвалж: *The E-Governance Institute, Rutgers, 2016*

Энэхүү цахим засаглалын гүйцэтгэлийн индексийн бүлэг тус бүрийн авбал зохих оноо харилцан ялгаатай ч хүндийн жин ижил байна. (Хүснэгт 15-ыг үзнэ үү)

Хүснэгт 15. *Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн бүлэг, хэмжүүр*

№	Бүлэг	Нийт оноо	Хүндийн жин
1.	<b>Аюулгүй байдал/нууцлал (security/privacy)</b> Асуулга 1~21, нийт 21 асуулга	33	20%
2.	<b>Ашиглахуйц байдал (usability)</b> Асуулга 22~41, нийт 20 асуулга	32	20%
3.	<b>Агуулга (content)</b> Асуулга 42~67, нийт 26 асуулга	63	20%
4.	<b>Үйлчилгээ (service)</b> Асуулга 68~88, нийт 21 асуулга	60	20%
5.	<b>Иргэн болон нийгмийн оролцоо (citizen &amp; social engagement)</b> Асуулга 89~106, нийт 18 асуулга	47	20%
<b>Нийт</b>		<b>235</b>	<b>100%</b>

Эх сурвалж: *The E-Governance Institute, Rutgers, 2016*

### 3.2.3 Хэрэглэгчийн туршлагыг үнэлэх нейро судалгаа

Хэрэглэгчийн туршлагыг үнэлэх нейро судалгаа нь сонгосон түүврээс СЭЗИС-ийн дэргэдэх нейро судалгааны лабораторт нүдний хөдөлгөөн дагах (eye tracking) төхөөрөмжөөр дата цуглуулж, дараа нь ганцаарчилсан ярилцлага хийх чанарын судалгаа байна.


Түүвэрт бүрэн дундаас дээш боловсролтой, 20-45 насны **нийт 20 оролцогчийг** хамруулах ба хүйсийн хувьд аль нэг хүйсийн оролцогч 8-аас доошгүй байхаар төлөвлөв.

Оролцогч нь нейро судалгааны лабораторт нүдний хөдөлгөөн дагах төхөөрөмж дээр өгөгдсөн цахим хуудас тус бүрд заасан 4 даалгаврыг гүйцэтгэнэ.

Даалгаврыг гүйцэтгэхдээ Google зэрэг өөр хайлтын систем, өөр цахим хуудас ашиглахгүй. Харин тухайн цахим хуудсанд холбосон линкээр өөр хуудас руу дамжиж орж болно. Нейро судалгааны дизайныг зураг 13-д харуулав.

Даалгаврыг зохиохдоо судалгаанд сонгогдсон 2 компанийн цахим хуудаст хоёуланд нь байгаа мэдээллийг хамруулна. Нейро судалгааны үр дүнг дараах үзүүлэлтүүдээр хэмжинэ. Үүнд:

Зураг 13. Нейро судалгааны дизайн



- Даалгавар гүйцэтгэсэн хугацаа - Даалгавар тус бүрийг гүйцэтгэсэн хугацааг хэмжинэ.
- Даалгаврын биелэлт – Даалгавар тус бүрийг гүйцэтгэж чадсан эсэх, өөрөөр хэлбэл даалгаварт өгөгдсөн мэдээллийг олж чадсан эсэхийг хэмжинэ. Судалгааг хэт сунжруулахаас сэргийлж, даалгавар тус бүрийн гүйцэтгэх хугацааг 3 минут байхаар тохируулна.
- Сэтгэл хөдлөлийн үр дүн – Оролцогчийн сэтгэл хөдлөлийн үзүүлэлтүүд болон эерэг, сөрөг сэтгэл хөдлөлийн дундаж үзүүлэлтийг даалгавар тус бүрээр гаргана.

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Нейро лабораторт даалгавар гүйцэтгэсний дараа оролцогчоос цахим хуудас тус бүрийн талаарх сэтгэгдлийг асууж, дараах асуулгын хүрээнд ганцаарчилсан ярилцлага хийнэ. Үүнд:

- Цахим хуудасны ерөнхий бүтэц ашиглахад хэр зэрэг хялбар, ойлгомжтой байсан бэ?
- Даалгаварт өгөгдсөн мэдээллийг хайж олоход хэр зэрэг хүндрэлтэй байсан бэ?
- Та бүх даалгаврыг бүрэн гүйцэтгэж чадсан уу? Ямар мэдээллийг олж чадаагүй вэ? Ямар мэдээллийг хурдан олсон бэ?

### Судалгааны хязгаарлалт

Судалгааны баг нь судалгааг зөвхөн сонгосон 39 компанийн хүрээнд, тэдгээрийн цахим хуудсанд нээлттэй нийтлэгдсэн мэдээлэл дээр үндэслэн хийнэ. Тухайн байгууллагын цахим хуудсанд нээлттэй мэдээлээгүй болон мэдээллийг нийтлэх үүрэг хүлээсэн бусад байгууллагын эх сурвалжийг линкээр холбож заагаагүй тохиолдолд тухайн мэдээллийг нээлттэй мэдээлсэн гэж тооцохгүй. Судалгааны баг нь тухайн мэдээллийг олох зорилгоор бусад төрийн байгууллага, албан газрын цахим хуудас, интернэт орчинд дэлгэрүүлсэн хайлт хийхгүй бөгөөд ингэж судалгааг өргөжүүлэх нь судалгааны үндсэн зорилго болох тухайн байгууллагын цахим хуудас дахь мэдээллийн ил тод байдлын үнэлгээтэй нийцэхгүй гэж үзсэн тул зөвхөн цахим хуудсан дахь мэдээллээр судалгааг хязгаарлахаар шийдсэн.

## IV БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


### 4.1 Журмын хүрээнд хийсэн үнэлгээний үр дүн

Судалгааг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс 4 дүгээр сарын 02-ны өдрийн хугацаанд гүйцэтгэж, нийт 39 компанийн цахим хуудсыг хамруулснаас, 38 компанийн цахим хуудаст Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журамд заасан хамаарах 44 мэдээлэл болон судалгааны багийн гаргасан 100 мэдээлэлд тус тус үнэлгээг хийсэн.

Үнэлгээнд хамрагдсан 38 компанийн дундаж үнэлгээ Журмын үнэлгээний системээр 31.37%, Судалгааны багийн гаргасан онооны системээр 32.60% гарсан байна.

Үнэлгээг бүлэг тус бүрээр авч үзвэл, “үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл” хамгийн өндөр хувьтай, харин “бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал” гэсэн бүлэг хамгийн бага хувьтай байна. (Зураг 14-ийг үзнэ үү)

Зураг 14. Журмын үнэлгээний ерөнхий үр дүн, мэдээллийн бүлгээр



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Орон нутгийн Авто зам засвар арчилгааны (АЗЗА) үйлчилгээ үзүүлж буй 20 компанийг үнэлгээнд хамрагдсан бусад компанитай харьцуулахад журмын үнэлгээний системийн хувьд 16 хувиар бага, судалгааны багийн онооны системийн хувьд 19 хувиар бага оноогоор үнэлэгдсэн байна (Хүснэгт 16-аас үзнэ үү).

Журмын болон судалгааны багийн онооны системээр хоёроор **Монголын төмөр зам ТӨХК** хамгийн өндөр оноог авч, нэгдүгээрт эрэмбэлэгдэж байгаа бол хамгийн бага оноог Завхан АЗЗА ХК авсан байна. Нийт компаниудын үнэлгээний ерөнхий дүнг журам болон судалгааны багийн онооны системээр харьцуулж Хүснэгт 17-д харуулав.

Хүснэгт 16. Журмын үнэлгээний ерөнхий үр дүн, мэдээллийн бүлэг болон компанийн төрлөөр

№	Шалгуур үзүүлэлт	Бусад компанийн дундаж хувь (нийт 18 компани*)		АЗЗА дундаж хувь (нийт 20 компани)		Нийт (нийт 38 компани)	
		СБ	Журам	СБ	Журам	СБ	Журам
А.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	45.23%	42.08%	18.99%	17.82%	31.42%	29.31%
В.	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	56.79%	56.29%	21.35%	21.15%	38.14%	37.79%
С.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	40.70%	38.21%	38.33%	36.27%	39.45%	37.19%
Д.	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	72.02%	52.60%			72.02%	52.60%
Е.	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	26.04%	25.47%	18.03%	19.83%	21.83%	22.50%
<b>Нэгдсэн дүн</b>		<b>40.47%</b>	<b>38.40%</b>	<b>25.53%</b>	<b>25.05%</b>	<b>32.60%</b>	<b>31.37%</b>

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Журмын онооны системээр хамгийн өндөр оноо 71.85% гарсан бол судалгааны багийн онооны системээр 75.51% гарсан байна. Судалгааны багийн онооны систем 6 компаниас бусад компанид илүү хувьтай гарсан бөгөөд компаниуд зарим мэдээллийг бүрэн бус оруулсан ч тодорхой үнэлгээ авсныг харуулж байна.

Хүснэгт 17. Үнэлгээний дүн, компаниар

Компанийн нэр	Журмын онооны систем		СБ онооны систем	
	Эрэмбэ	Үнэлгээний ерөнхий оноо, хувь	Эрэмбэ	Үнэлгээний ерөнхий оноо, хувь
Монголын төмөр зам ТӨХК	1	71.85%	1	75.51%
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	2	56.04%	2	57.03%
Монголросцветмет ТӨҮГ	3	52.92%	3	56.88%
Монголын Хөрөнгийн бирж ТӨХК	4	50.39%	4	54.84%
Үндэсний давхар даатгал ХК	5	49.90%	5	51.09%
Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨҮГ	6	44.51%	6	49.29%
Эрдэнэс Тавантолгой ХК	7	43.90%	7	45.78%
Төв АЗЗА ТӨХК	8	42.84%	8	43.59%
МИАТ ТӨХК	9	39.48%	9	40.94%
Дорноговь АЗЗА ТӨХК	10	36.54%	12	36.97%
Дархан АЗЗА ТӨХК	11	36.32%	13	36.86%

Өвөрхангай АЗЗА ТӨХК	12	36.11%	11	37.77%
Шивээ Овоо ТӨХК	13	35.94%	15	36.30%
Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	14	35.31%	10	38.23%
Архангай АЗЗА ТӨХК	15	35.15%	18	34.72%
ДЦС-4 ТӨХК	16	34.19%	14	36.43%
Орхон АЗЗА ТӨХК	17	33.76%	19	33.97%
Талын зам АЗЗА ТӨХК	18	33.76%	16	35.04%
Цемент Шохой ТӨХК	19	33.13%	17	35.00%
Монгол Шуудан ХК	20	31.67%	20	33.91%
Эрдэнэсант АЗЗА ТӨХК	21	30.98%	21	32.43%
Дархан Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК	22	29.90%	23	31.15%
Говь-Алтай АЗЗА ТӨХК	23	29.81%	22	31.94%
Таван Толгой ХК	24	25.41%	24	26.22%
Харгуй АЗЗА ТӨХК	25	24.25%	25	24.73%
Булган АЗЗА ТӨХК	26	22.76%	27	23.02%
Хархорин АЗЗА ТӨХК	27	22.44%	29	22.22%
Ховд АЗЗА ТӨХК	28	21.90%	30	21.26%
Багануур ТӨХК	29	21.25%	28	23.02%
Сэлэнгэ АЗЗА ТӨХК	30	20.73%	26	23.77%
Баянчандмань АЗЗА ТӨХК	31	19.66%	31	19.71%
Эрдэнэс монгол ХХК	32	19.48%	32	19.69%
Монголын цахилгаан холбоо ХК	33	15.94%	33	17.08%
Багануур АЗЗА ТӨХК	34	13.25%	35	13.03%
Налайх АЗЗА ТӨХК	35	13.14%	34	13.68%
Увс АЗЗА ТӨХК	36	11.22%	36	10.36%
Хөвсгөл АЗЗА ТӨХК	37	8.23%	37	8.23%
Завхан АЗЗА ТӨХК	38	8.12%	38	7.26%
Дулааны 3-р Цахилгаан Станц ТӨХК	Үнэлгээ хийсэн өдрүүдэд цахим хуудас нь ажиллахгүй байсан тул үнэлгээ хийгдээгүй.			

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Хүснэгт 18, 19-д хамгийн өндөр оноо авсан ТОП 5 компанийн үнэлгээг мэдээллийн бүлгээр нь харуулав. Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ “Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал” бүлгийн үзүүлэлтээр 100% хамгийн өндөр оноо авсан бол Монголын төмөр зам ХК “Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт” бүлгийн үзүүлэлтээр 96.25% оноо, Монголын хөрөнгийн бирж ХК “Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл” бүлгийн үзүүлэлтээр 91.67% оноог авсан байна.

Хүснэгт 18. Хамгийн өндөр ерөнхий оноотой компаниуд (Судалгааны багийн онооны систем)

№	Компанийн нэр	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	Хүний нөөцийн талаарх мэдээлэл	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй	Үнэлгээний ерөнхий оноо, хувь
1.	Монголын төмөр зам ТӨХК	96.25%	75.00%	71.15%	45.83%	64.77%	75.51%
2.	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	64.58%	100.00%	46.15%		41.67%	57.03%
3.	Монголросцветмет ТӨҮГ	65.74%	56.94%	67.95%		38.19%	56.88%
4.	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	54.17%	73.61%	63.69%	91.67%	27.27%	54.84%
5.	Үндэсний давхар даатгал ХК	63.33%	61.81%	61.61%	50.00%	20.83%	51.09%
Эхний 5 компанийн дундаж оноо		68.81%	73.47%	62.11%	62.50%	38.55%	59.07%
38 компанийн дундаж оноо		31.42%	38.14%	39.45%	72.02%	21.83%	32.60%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Хүснэгт 19. Хамгийн өндөр ерөнхий оноотой компаниуд (Журмын онооны систем)

№	Компанийн нэр	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион	Хүний нөөцийн талаарх мэдээлэл	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй	Үнэлгээний ерөнхий оноо, хувь
1.	Монголын төмөр зам ТӨХК	92.92%	73.61%	65.38%	41.67%	62.12%	71.85%
2.	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	63.89%	100.00%	43.59%		41.67%	56.04%
3.	Монголросцветмет ТӨҮГ	58.33%	56.94%	62.18%		36.81%	52.92%
4.	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	46.67%	72.22%	58.93%	70.83%	27.27%	50.39%
5.	Үндэсний давхар даатгал ХК	62.92%	61.81%	58.04%	41.67%	21.97%	49.90%
Эхний 5 компанийн дундаж оноо		64.94%	72.92%	57.62%	51.39%	37.97%	56.22%
38 компанийн дундаж оноо		29.31%	37.79%	37.19%	52.60%	22.50%	31.37%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Үнэлгээнд хамрагдсан компаниудын 6 нь нээлттэй хувьцаат компани бөгөөд бусад нь (32) хаалттай компаниуд байна. Хоёр үнэлгээний системийн хувьд харьцуулж үзэхэд нээлттэй хувьцаат компаниудын дундаж нь хаалттай компаниудын дунджаас бага байгаа нь нээлттэй компаниудын ил тод байдал хангалтгүй байгааг илтгэж байна (Хүснэгт 20-иос үзнэ үү).

Хүснэгт 20. Нээлттэй ХК болон хаалттай компаниуд

№	Шалгуур үзүүлэлт	Нээлттэй ХК		Хаалттай компаниуд	
		СБ онооны систем	Журмын онооны систем	СБ онооны систем	Журмын онооны систем
А.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	35.15%	51.39%	30.72%	28.72%
В.	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	43.98%	43.63%	37.04%	36.70%
С.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	30.75%	32.49%	41.08%	38.72%
Д.	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	80.56%	29.00%	65.63%	53.33%
Е.	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	21.38%	20.89%	21.91%	22.80%
<b>Нэгдсэн дүн</b>		<b>31.90%</b>	<b>30.10%</b>	<b>32.95%</b>	<b>31.37%</b>

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

ТОП 100-д орсон нийт 13 компанийн дундаж үнэлгээг (37.89%) бусад буюу 2022-2023 онд нээлттэй болох 24 компанийн дундаж үнэлгээтэй (27.57%) харьцуулахад 10.32% -иар илүү байна (Хүснэгт 21-ээс үзнэ үү).

Хүснэгт 21. ТОП 100-д орсон болон нээлттэй болох компаниудын үнэлгээний харьцуулалт

№	Шалгуур үзүүлэлт	ТОП-100 аж ахуй нэгжийн жагсаалтад орсон 13 компанийн дундаж		2022-2023 онд нээлттэй болох 25 компанийн дундаж	
		СБ онооны систем	Журмын онооны систем	СБ онооны систем	Журмын онооны систем
А.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	43.44%	40.21%	24.41%	22.96%

В.	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	57.99%	57.54%	26.56%	26.27%
С.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа	38.85%	36.61%	39.80%	37.53%
Д.	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	70.83%	56.25%	72.92%	48.96%
Е.	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	27.34%	26.93%	18.61%	19.92%
<b>Нэгдсэн дүн</b>		<b>39.72%</b>	<b>37.89%</b>	<b>28.45%</b>	<b>27.57%</b>

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Дундаж үзүүлэлт хамгийн өндөр, 85.96% гүйцэтгэлтэй мэдээлэл нь шилэн дансанд байршуулдаг “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэх мэдээлэл орж байгаа бол “Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт”, “Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт” гэх мэдээллүүд нь дундаж үзүүлэлт хамгийн бага буюу 3% хүрэхгүй үнэлэгдсэн байна (Хүснэгт 22-оос үзнэ үү).

Хүснэгт 22. Хамгийн өндөр оноотой болон хамгийн бага оноотой нийтийн мэдээлэл

№	Нийтийн мэдээлэл	Үзүүлэлтийн дундаж оноо	
		СБ онооны систем	Журмын онооны систем
1.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	86.18%	85.96%
2.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	75.66%	75.55%
3.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	73.68%	70.39%




4.	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар	69.74%	69.74%
5.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	67.11%	67.11%
35.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	7.57%	7.57%
36.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	5.26%	5.26%
37.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	3.73%	3.73%
38.	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт	2.63%	2.63%
39.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	3.29%	2.19%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Журмын үнэлгээний системээр эхний тавд орсон компаниуд “Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм”, “Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт” болон “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” нийтийн мэдээллүүдийг 100% мэдээлсэн бол харин “Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл” болон “Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ” мэдээллүүдийг огт мэдээлээгүй байна (Зураг 15-ыг үзнэ үү).


Зураг 15. Эхний таван компанийн үнэлгээний хувь болон мэдээллийн тоо



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Үнэлгээ хийгдсэн зургаан нээлттэй хувьцаат компаниуд нийт 11 нийтийн мэдээллийг огт мэдээлээгүй бөгөөд тэдгээрийн 3 мэдээлэл нь шилэн дансанд нийтлэгдэх мэдээлэл бол үлдсэн 8 мэдээлэл нь цахим хуудсанд нийтлэгдэх мэдээлэл байна. Зураг 16-д үнэлгээнд хамрагдсан 6 нээлттэй ХК-ийн үнэлгээний хувь болон мэдээллийн тоог, харин Хүснэгт 23-т тэдгээрийн нийтлээгүй мэдээллийн жагсаалтыг харуулав.

Зураг 16. Зургаан нээлттэй ХК-ийн үнэлгээний хувь болон мэдээллийн тоо



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Хүснэгт 23. Зургаан нээлттэй ХК-ийн мэдээлээгүй нийтийн мэдээллүүд

№	Нийтийн мэдээлэл
1.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан
2.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан
3.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл
4.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн
5.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан
6.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт
7.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл

8.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл
9.	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ
10.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт
11.	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт


Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

#### 4.2 Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн үнэлгээний үр дүн

Судалгааг 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөс 4 дүгээр сарын 12-ны өдрийн хугацаанд гүйцэтгэж, нийт 39 компанийн цахим хуудсыг хамруулснаас, 38 компанийн цахим хуудаст Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн үнэлгээг хийсэн. Үнэлгээнд хамрагдсан компаниудын дундаж үнэлгээ 18,14% гарсан байна.

Нийт 38 компанийн дунджийг үнэлгээний бүлэг тус бүрээр авч үзвэл, “ашиглагдахуйц байдал” үзүүлэлт хамгийн өндөр оноотой буюу нийт 20 оноо авахаас 9,62 оноо/48,11% оноо авсан бол харин “аюулгүй байдал/нууцлал” гэсэн үзүүлэлт хамгийн бага оноотой буюу нийт 20 оноо авахаас 0.59 оноо/ 2,95% авсан байна. (Зураг 17-г үзнэ үү)

Зураг 17. Олон улсын үнэлгээний ерөнхий үр дүн, үзүүлэлтийн бүлгээр



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Орон нутгийн Авто зам засвар арчилгааны (АЗЗА) үйлчилгээ үзүүлж буй 20 компанийг үнэлгээнд хамрагдсан бусад компанитай харьцуулахад 13.91 хувиар бага оноогоор үнэлэгдсэн байна (Хүснэгт 24-ийг үзнэ үү).

Хүснэгт 24. Олон улсын үнэлгээний ерөнхий үр дүн %, мэдээллийн бүлэг болон компанийн төрлөөр

№	Шалгуур үзүүлэлт	Бусад дундаж хувь (нийт 18 компани*)	АЗЗА дундаж хувь (нийт 20 компани)	Нийт (нийт 38 компани)
1.	Аюулгүй байдал/нууцлал	6.23%	0.00%	2.95%
2.	Ашиглахуйц байдал	55.90%	41.09%	48.11%
3.	Агуулга	37.74%	15.00%	25.77%
4.	Үйлчилгээ	17.87%	1.58%	9.30%
5.	Иргэн болон нийгмийн оролцоо	9.57%	0.11%	4.59%
<b>Нэгдсэн дүн</b>		<b>25.46%</b>	<b>11.56%</b>	<b>18.14%</b>
* Үнэлгээ хийсэн өдрүүдэд Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц ТӨҮГ-ын цахим хуудас ажиллахгүй байсан тул үнэлгээ хийгдээгүй бөгөөд нэгдсэн хүснэгтэд ороогүй болно.				

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Олон улсын Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн үнэлгээгээр **МИАТ ТӨХК** хамгийн өндөр оноог авч, нэгдүгээрт эрэмбэлэгдэж байгаа бол хамгийн бага оноог Завхан АЗЗА ХК авсан байна. Нийт компанийн үнэлгээний дүнг Хүснэгт 25-д харуулсан.

Хүснэгт 25. Үнэлгээний дүн, компаниар

№	Компанийн нэр	Нийт хувь	№	Компани	Нийт хувь
1.	МИАТ ТӨХК	49.80%	21.	Говь-Алтай АЗЗ ТӨХК	13.91%
2.	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	35.95%	22.	Өвөрхангай АЗЗА ТӨХК	13.82%
3.	Монголын цахилгаан холбоо ХК	34.79%	23.	Талын зам ТӨХК	13.82%
4.	Монгол шуудан ХК	31.41%	24.	Архангай АЗЗА ТӨХК	13.65%
5.	Монголын Хөрөнгийн бирж ТӨХК	28.14%	25.	Орхон АЗЗА ТӨХК	13.52%
6.	Монголросцветмет ТӨҮГ	27.04%	26.	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	13.17%
7.	Эрдэнэс Таван Толгой ХК	25.28%	27.	Увс АЗЗА ТӨХК	12.87%
8.	Таван Толгой ХК	23.62%	28.	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	12.59%
9.	Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨҮГ	23.07%	29.	Дорноговь АЗЗА ТӨХК	11.01%
10.	Эрдэнэс монгол ХХК	22.54%	30.	Хөвсгөл АЗЗА ТӨХК	9.09%

11.	Монголын төмөр зам ТӨХК	22.18%	31.	Булган АЗЗА ТӨХК	8.82%
12.	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	20.92%	32.	Баянчандмань АЗЗА ТӨХК	8.78%
13.	Дархан Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК	20.88%	33.	Налайх АЗЗА ТӨХК	8.78%
14.	Үндэсний давхар даатгал ХК	19.48%	34.	Хархорин АЗЗА ТӨХК	8.78%
15.	4-р цахилгаан станц ТӨХК	19.40%	35.	Багануур АЗЗА ТӨХК	8.46%
16.	Багануур ТӨХК	18.94%	36.	Харгуй ТӨХК	8.46%
17.	Төв АЗЗА ТӨХК	18.93%	37.	Ховд АЗЗА ТӨХК	8.46%
18.	Цемент Шохой ТӨХК	18.17%	38.	Завхан АЗЗА ТӨХК	8.14%
19.	Шивээ Овоо ТӨХК	16.76%	39.	3-р цахилгаан станц ТӨХК	n.d
20.	Дархан АЗЗА ТӨХК	16.08%			

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Хүснэгт 26-д хамгийн өндөр оноо авсан ТОП 5 компанийн үнэлгээг мэдээллийн бүлгээр нь харуулав. МИАТ ТӨХК “аюулгүй байдал/нууцлал”, “Агуулга”, “Үйлчилгээ” болон “Иргэний болон нийгмийн оролцоо” бүлгүүдийн хамгийн өндөр оноо авсан бол Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ “Ашиглагдахуйц байдал” бүлгийн үзүүлэлтээр хамгийн өндөр оноог авсан байна.

Хүснэгт 26. Хамгийн өндөр ерөнхий оноотой компаниуд (Судалгааны багийн онооны систем)

№	Компанийн нэр	Аюулгүй байдал/нууцлал	Ашиглахуйц байдал	Агуулга	Үйлчилгээ	Иргэн болон нийгмийн оролцоо	Нийт оноо, %
1.	МИАТ ТӨХК	33.33%	71.88%	57.14%	48.33%	38.30%	49.80%
2.	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	9.09%	75.00%	46.03%	28.33%	21.28%	35.95%
3.	Монголын цахилгаан холбоо ХК	18.18%	62.50%	38.10%	46.67%	8.51%	34.79%
4.	Монгол шуудан ХК	33.33%	68.75%	28.57%	20.00%	6.38%	31.41%
5.	Монголын Хөрөнгийн бирж ТӨХК	0.00%	62.50%	49.21%	18.33%	10.64%	28.14%
Нийт 38 компанийн дундаж оноо		2.95%	48.11%	25.77%	9.30%	4.59%	18.14%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Үнэлгээнд хамрагдсан компаниудын 6 нь нээлттэй хувьцаат компани, бусад нь (31) хаалттай компаниуд бөгөөд харьцуулж үзэхэд нээлттэй хувьцаат компаниудын дундаж нь, хаалттай компаниудын дундажаас 8.86%-иар илүү байгаа нь нээлттэй компаниудын цахим хуудас хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй байгааг харуулж байна.

Хүснэгт 27. Нээлттэй ХК болон хаалттай компаниудын үнэлгээний харьцуулалт

Компаниуд	Аюулгүй байдал/ нууцлал	Ашиглахуйц байдал	Агуулга	Үйлчилгээ	Иргэн болон нийгмийн оролцоо	Нийт оноо, %
Нээлттэй ХК	10.10%	57.81%	35.19%	17.50%	7.45%	25.61%
Хаалттай компани	1.61%	46.29%	24.01%	7.76%	4.06%	16.74%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

ТОП 100-д орсон нийт 14 компанийн дундаж үнэлгээг бусад буюу 2022-2023 онд нээлттэй болох 25 компанийн дундаж үнэлгээтэй харьцуулахад 11.18% -иар илүү байна.

Хүснэгт 28. ТОП 100-д орсон болон нээлттэй болох компаниудын үнэлгээний харьцуулалт

Компаниуд	Аюулгүй байдал/ нууцлал	Ашиглахуйц байдал	Агуулга	Үйлчилгээ	Иргэн болон нийгмийн оролцоо	Нийт оноо, %
ТОП-100 аж ахуй нэгжийн жагсаалтад орсон 14 компанийн дундаж	6.71%	55.58%	37.41%	15.83%	10.49%	25.20%
2023 онд нээлттэй болох 25 компанийн дундаж	0.76%	43.75%	18.98%	5.49%	1.15%	14.03%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

### 4.3 Хэрэглэгчийн туршлагыг үнэлэх нейро судалгааны үр дүн

Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмын үнэлгээний үр дүнгээр хамгийн өндөр оноо авсан **Монголын төмөр зам ТӨХК**, Rutger-ийн цахим засгийн гүйцэтгэлийн индексийн үзүүлэлтээр хамгийн өндөр оноо авсан **МИАТ ТӨХК**-ийн цахим хуудасны хэрэглэхэд тохиромжтой байдал, хэрэглэгчийн туршлагыг нейро болон чанарын судалгааны аргачлалаар шинжлэхээр сонгов. Судалгаанд сонгосон компаниудын цахим хуудасны харагдах байдлыг зураг 18-д харуулав.


Судалгааны даалгаврыг зохиохдоо сонгогдсон 2 компанийн цахим хуудсанд хоёуланд нь байгаа мэдээллийг хамруулсан.

Хүснэгт 29. Нейро судалгаанд оролцогчийн гүйцэтгэх даалгавар

<b>Даалгавар 1</b>	Компанийн үйл ажиллагааны стратеги, эрхэм зорилго, зорилтыг олох
<b>Даалгавар 2</b>	Төрийн эзэмшиж буй хувь эзэмшлийн мэдээллийг олох
<b>Даалгавар 3</b>	Компанийн бүтцийн мэдээллийг олох
<b>Даалгавар 4</b>	2023 оны 3-р сарын цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын гүйлгээний тоог олох

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Зураг 18. Нейро судалгаанд хамруулахаар сонгосон 2 компанийн цахим хуудас



Эх сурвалж: [www.miat.com](http://www.miat.com), [www.mtz.mn](http://www.mtz.mn)

Хүснэгт 30. Өгөгдсөн даалгавар тус бүрийн мэдээллийн байршил, компани тус бүрээр

Даалгавар	МИАТ ТӨХК	МТЗ ТӨХК
Үйл ажиллагааны стратеги, эрхэм зорилго, зорилтыг олох	Бидний тухай → Алсын хараа, Эрхэм зорилго <i>Эсхүл</i> Ил тод байдал → Компанийн бодлого, зорилт → Алсын хараа, эрхэм зорилго	Бидний тухай → Танилцуулга, эрхэм зорилго, алсын хараа
Төрийн эзэмшиж буй хувь эзэмшлийн мэдээллийг олох	Ил тод байдал → Дүрэм, журам	Хүний нөөц → Компанийн дүрэм, журам
Компанийн бүтцийн мэдээллийг олох	Ил тод байдал → Компанийн бүтэц	Бидний тухай → Бүтэц
2023 оны 3-р сарын Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын гүйлгээний тоог олох	Ил тод байдал → Шилэн данс	Шилэн данс <i>Эсхүл</i> Ил тод байдал → Худалдан авалт → Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш гүйлгээ → Шилэн данс

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Нейро судалгааг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр СЭЗИС-ийн дэргэдэх нейро судалгааны лабораторт гүйцэтгэв. Судалгаанд нийт 20 оролцогчийг хамруулснаас 19 оролцогчийн мэдээллийн үр дүнг боловсруулсан. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг хүснэгт 32 -д харуулав.

Хүснэгт 31. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


<b>Нас:</b>	<b>Боловсрол:</b>	Дээд 18
<b>Хүйс:</b> Эрэгтэй 9, Эмэгтэй 11		Оюутан 2

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

### Даалгавар гүйцэтгэсэн хугацааны шинжилгээ

Оролцогчдын нийт даалгаврыг гүйцэтгэсэн хугацааны дунджийг авч үзвэл, МИАТ ТӨХК-ийн цахим хуудсанд даалгавар гүйцэтгэсэн дундаж хугацаа **95.6 сек**, харин МТЗ ТӨХК-ийн хувьд **73.8 сек** байна. Даалгавар тус бүрийг гүйцэтгэсэн дундаж хугацааг компани тус бүрээр Зураг 19 болон хүснэгт 33-д харуулав.

Зураг 19. Даалгавар гүйцэтгэсэн дундаж хугацаа, секунд



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Хүснэгт 32. Даалгавар гүйцэтгэсэн дундаж хугацаа, секунд

Даалгавар	МИАТ	МТЗ
<b>Даалгавар 1:</b> Компанийн үйл ажиллагааны стратеги, эрхэм зорилго, зорилтыг олоход	59.55	30.03
<b>Даалгавар 2:</b> Төрийн эзэмшиж буй хувь эзэмшлийн мэдээллийг олоход	150.55	149.18
<b>Даалгавар 3:</b> Компанийн бүтцийн мэдээллийг олоход	45.21	20.07
<b>Даалгавар 4:</b> 2023 оны 3-р сарын цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын гүйлгээний тоог олоход	127.01	95.83
<b>Ерөнхий дундаж хугацаа, секунд</b>	<b>95.58</b>	<b>73.78</b>

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар


Даалгавар тус бүрээр авч үзвэл 1 болон 3-р даалгаврыг гүйцэтгэхэд оролцогчид харьцангуй бага хугацаа зарцуулсан ба хамгийн багадаа 5-6 секундэд, бүх оролцогчид 3 минутын дотор мэдээллийг олсон.



Хоёр компанийн хувьд “Алсын хараа, эрхэм зорилго” нь “Бидний тухай” цэсэнд байсан тул оролцогчид хялбар олсон боловч, зарим оролцогч “Үйл ажиллагааны стратеги”-ийг үргэлжлүүлэн хайж байсан.

Даалгавар 3 дээр МИАТ ТӨХК-ийн бүтцийн зураглал нь хэдийгээр хялбар олддог ч хажуу тийш харсан (Зураг 21-ийг үзнэ үү), зурган файлаар татагдаж гарч ирдэг тул оролцогч зургийг эргүүлж тэгшлэн харах, хүлээх зэрэгт хугацаа зарцуулж байсан.

Зураг 20. МИАТ ТӨХК-ийн цахим хуудаст компанийн бүтцийн зураглалын харагдах байдал







Эх сурвалж: [www.miat.com](http://www.miat.com)

Даалгавар 2-ыг гүйцэтгэхэд оролцогчдын тал нь, даалгавар 4 дээр 5-6 оролцогч 3 минут хүртэл мэдээллийг хайсан.

Оролцогчдын даалгавар тус бүрийг гүйцэтгэсэн хугацааг Зураг 21-д харуулав.

Зураг 21. Оролцогчдын даалгавар тус бүрийг гүйцэтгэсэн хугацаа, секундээр





Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар


**Дүгнэлт:** Хугацааны шинжилгээнээс даалгавар 1 ба 3 хайж олоход **хялбар**, харин даалгавар 2 болон 4-ийг хайж олоход **хүндрэлтэй** байсныг харуулж байна. Даалгаврыг гүйцэтгэсэн дараалал нь эхлээд МИАТ, дараа нь МТЗ байсан нь МИАТ-ын цахим хуудас дээр ажиллаж туршлага хуримтлуулаад МТЗ дээр хялбар ажиллаж бага хугацаа зарцуулахад нөлөөлсөн байх магадлалтай. Мөн МИАТ ТӨХК-ийн цахим хуудас зарим үед удаж байсан нь хугацаанд нөлөөлсөн.

### Даалгаврын биелэлтийн шинжилгээ

Даалгавар тус бүрээр авч үзвэл, даалгаврын биелэлт хоёр компанийн хувьд ойролцоо хувьтай байна. (Зураг 22-ыг үзнэ үү) 1 ба 3-р даалгаврын асуулт цахим хуудасны хамаарах дэд цэсэнд өгөгдсөн даалгаврын нэршлийн дагуу шууд олдохоор байсан тул нэгээс бусад бүх оролцогч даалгаврыг амжилттай гүйцэтгэж чадсан.

1 ба 3-р даалгаврыг нэгээс бусад бүх оролцогч амжилттай гүйцэтгэж чадсан нь тэдгээр даалгаврын асуулт, цахим хуудасны хамаарах дэд цэсийн нэршлийн дагуу шууд олдохоор байсантай холбоотой.

Зураг 22. Оролцогчдын даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн хувь




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Даалгавар 2 буюу төрийн эзэмшиж буй хувь эзэмшлийн мэдээллийг зөвхөн компанийн дүрмээс үзэх боломжтой байсан нь мэдээллийг олоход оролцогчдоос тодорхой хэмжээний мэдлэг шаардаж байсан. МТЗ ТӨХК-ийн компанийн дүрэм нь

“Хууль эрх зүй” цэсэнд биш “Хүний нөөц” цэсэнд байснаас (Зураг 23-ийг үзнэ үү) нэг ч оролцогч олж чадаагүй ба 3 оролцогчийн хувьд компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, УИХ-ын тогтоолыг үзсэнээр даалгавар 2-ыг гүйцэтгэсэнд тооцсон бол 6 нь мэдээллийг байхгүй гэж үзээд хуудсыг хааж, 10 нь 3 минутын турш мэдээллийг хайж хугацааг дуусгасан.


Харин МИАТ ТӨХК-ийн дүрэм нь “Ил тод байдал” цэсний “Дүрэм, журам” хэсэгт байсан ба дүрмийг 5 оролцогч олж, даалгаврыг биелүүлж чадсан. (Зураг 24-ийг үзнэ үү)

Зураг 23. МТЗ ТӨХК-ийн цахим хуудасны Хүний нөөц цэс



Эх сурвалж: [www.mtz.mn](http://www.mtz.mn)


Зураг 24. МИАТ ТӨХК-ийн цахим хуудасны Дүрэм, журам цэс



Эх сурвалж: [www.miat.com](http://www.miat.com)

Даалгавар 4 буюу “2023 оны 3-р сарын цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын гүйлгээний тоо”-г оролцогчдын 50 орчим хувь нь Шилэн дансны цахим хуудаснаас олсон бол тал нь шилэн дансны цахим хуудас руу орсон ч хайж олж чадахгүй буцаж гарч, эсхүл мэдээллийг ололгүй 3 минутын хугацааг дуусгасан. Шилэн дансны цахим хуудаснаас оролцогч мэдээлэл хайж буй байдлыг Зураг 25-д үзүүлэв. Компани тус бүрийн цахим хуудсанд даалгавар гүйцэтгэсэн байдлыг Хүснэгт 38, 39-д харуулсан.

Зураг 25. Оролцогч шилэн дансны цахим хуудаснаас мэдээлэл хайж буй байдал



Эх сурвалж: Судалгааны багийн гүйцэтгэсэн Eye tracking судалгааны бичлэг

Хүснэгт 33. МИАТ ТӨХК-ийн цахим хуудсанд даалгавар гүйцэтгэсэн мэдээлэл

Даалгавар	Мэдээлэл олсон		Нэмэлт мэдээлэл хайсан		Мэдээлэл ололгүй хаасан		Буруу мэдээлэл олсон		Мэдээлэл ололгүй хугацаа дууссан	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Даалгавар 1	19	100%	5	26%	0	0%	0	0%	0	0%
Даалгавар 2	5	26%	0	0%	4	21%	1	5%	9	47%
Даалгавар 3	18	95%	0	0%	1	5%	0	0%	0	0%
Даалгавар 4	9	47%	0	0%	4	21%	0	0%	6	31%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Хүснэгт 34. Монголын Төмөр Зам ТӨХК-ийн цахим хуудсанд даалгавар гүйцэтгэсэн мэдээлэл

Даалгавар	Мэдээлэл олсон		Нэмэлт мэдээлэл хайсан		Мэдээлэл ололгүй хаасан		Буруу мэдээлэл олсон		Мэдээлэл ололгүй хугацаа дууссан	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Даалгавар 1	19	100%	3	16%	0	0%	0	0%	0	0%
Даалгавар 2	0	0%	0	0%	6	32%	3	16%	10	53%
Даалгавар 3	18	95%	0	0%	1	5%	0	0%	0	0%
Даалгавар 4	10	53%	1	5%	4	21%	0	0%	5	26%


Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

**Дүгнэлт:** Дээр дурдсанчлан даалгавар 1 ба 3 олоход хялбар, 2 ба 4 олоход хүндрэлтэй байсныг даалгаврын биелэлтийн шинжилгээ нотолж байна. Даалгаврыг амжилттай гүйцэтгэхэд цахим хуудасны цэсийн нэршил, мэдээллийг цэсэнд зөв ангилж байрлуулах нь чухал нөлөөтэй байсан бөгөөд зарим тохиолдолд оролцогчийн мэдлэг, туршлага шаардаж байна.

**Сэтгэл хөдлөлийн байдалд хийсэн шинжилгээ**

Оролцогчдын сэтгэл хөдлөл (emotion) -ийн байдлыг 12 үзүүлэлтээр хэмжсэн үр дүнг нийт хугацааны туршид дундажлан авч үзэхэд (Зураг 26-г үзнэ үү) оролцогчид ихэнхдээ нейтрал буюу сэтгэл хөдлөл бага байсан байна.

Зураг 26. Сэтгэл хөдлөлийн хэмжилтийн дундаж хувь




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Valence буюу нийт хугацааны туршид оролцогчдын сэтгэл хөдлөлийн эерэг, сөрөг байдлын дундаж үзүүлэлтийг үнэлгээ хийсэн 2 компанийн цахим хуудас болон даалгавар тус бүрээр авч үзвэл, МИАТ ТӨХК-ийн хувьд эерэг 0.04, МТЗ ТӨХК-ийн хувьд эерэг 0.21 байна.


Даалгавар 3 буюу МТЗ ТӨХК-ийн бүтцийн мэдээллийг олоход нийт оролцогчдын сэтгэл хөдлөлийн дундаж үзүүлэлт хамгийн их эерэг байсан байна. МТЗ ТӨХК-ийн бүтцийн мэдээлэл нь олоход хялбар байснаас гадна өнгө үзэмж сайтай байсан нь нөлөөлсөн байх магадлалтай. (Зураг 28-г үзнэ үү ) Харин оролцогчид даалгавар 4-ийг гүйцэтгэхэд буюу шилэн данснаас мэдээлэл хайх үед сөрөг сэтгэл хөдлөл илүү байсныг харуулж байна.

Зураг 27. Оролцогчдын сэтгэл хөдлөлийн эерэг сөрөг байдлын дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

Зураг 28. МТЗ ТӨХК-ийн цахим хуудас дахь даалгавар 2-ын харагдах байдал



Эх сурвалж: [www.mtz.mn](http://www.mtz.mn)

**Дүгнэлт:** Оролцогчдын гүйцэтгэсэн даалгаврууд нь бүгд текстээр бөгөөд албан ёсны, мэргэжлийн үг хэллэг түлхүү ашигласан байсан нь сэтгэл хөдлөл бага байхад нөлөөлсөн гэж үзэж байна. Мэдээлэл нь ойлгомжтой, хялбар, өнгөлөг байх нь хэрэглэгчид таатай, эерэг сэтгэгдэл төрүүлж байх магадлалтай.

### Ганцаарчилсан ярилцлагын үр дүн

Оролцогчидтой хийсэн ганцаарчилсан ярилцлагын үр дүнг компани тус бүрээр Хүснэгт 36-д нэгтгэн харуулав. Оролцогчдын 45% (9) нь МИАТ ТӨХК-ийн цахим хуудсанд эерэг сэтгэгдэлтэй, ойлгомжтой, хялбар гэж үзсэн бол 50% (10) нь ашиглахад төвөгтэй, ойлгомжгүй гэж үнэлсэн. Харин оролцогчдын 65% (13) нь МТЗ ТӨХК-ийн цахим хуудсанд эерэг сэтгэгдэлтэй, өнгө үзэмж сайн, ойлгомжтой, бүтэц зөв, цэгцтэй, хялбар гэж дүгнэсэн бол 35% (7) нь төвөгтэй, хуучирсан, ойлгомжгүй гэж үнэлсэн.

Хүснэгт 35. Ганцаарчилсан ярилцлагын ерөнхий тойм

	Сэтгэгдэл	Тоо
МИАТ ТӨХК эерэг сэтгэгдэл	Цахим хуудас ойлгомжтой байсан	4
	Мэдээлэл олоход төвөгтэй биш, амар, хялбар	5
МИАТ ТӨХК сөрөг сэтгэгдэл	Цэсний ангилал, бүтэц ойлгомжгүй, мэдээллүүд нь зөв байрлалтай бус	7
	Компанийг мэдээллийн цэснээс мэдээлэл олж авахад төвөгтэй.	3
МТЗ ТӨХК эерэг сэтгэгдэл	Ойлгомжтой, зөв бүтэцтэй, хялбар	12
	Өнгө үзэмж таалагдсан	2
МТЗ ТӨХК сөрөг сэтгэгдэл	Ойлгомжгүй, төвөгтэй	5

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар

5 оролцогч 2 сайтыг хоёуланг ойлгомжтой, хялбар гэж үзсэн бол 3 оролцогч 2 сайтыг хоёуланг ойлгомжгүй, сайжруулах шаардлагатай гэж үзжээ. Бусад оролцогч аль 2 сайтыг харьцуулж, аль нэгийг нь илүү үнэлсэн байна.

**Дүгнэлт:** МТЗ ТӨХК-ийн цахим хуудас харьцангуй хялбар, ойлгомжтой бөгөөд цахим хуудсанд ажилласны дараах оролцогчдын сэтгэгдэл ерөнхийдөө хуваагдсан байгаа нь 2 компанийн цахим хуудсанд сайжруулах, цэсийг илүү, ойлгомжтой, хялбар болгох хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

### Нейро судалгааны нэгдсэн үр дүн

Нейро судалгааны ерөнхий үр дүнг (дундаж үзүүлэлт) Хүснэгт 37-д нэгтгэн харуулав.

Нийт хугацааны дунджаар МИАТ ТӨХК-ийн цахим хуудсанд даалгавар гүйцэтгэхэд арай удаан байсан нь даалгаврын эхэнд байсан, бүтцийн зураг нь удаан нээгдсэн, цахим хуудас нь зарим үед удаан ачаалж байсан нь нөлөө үзүүлсэн бол МТЗ ТӨХК-ийн даалгаврын биелэлт арай бага хувьтай гарсан нь компанийн дүрмийг хүний нөөц цэсэнд байршуулсан нь нөлөө үзүүлсэн. МТЗ ТӨХК-ийн цахим хуудсанд ажиллахад сэтгэл хөдлөл арай илүү эерэг гарсан нь бүтцийн зураг хялбар, ойлгомжтой байсан нь нөлөөлсөн байх магадлалтай.

Хүснэгт 36. *Нейро судалгааны үр дүнгийн нэгтгэл*

Үзүүлэлт	МИАТ	МТЗ
Даалгаврын хугацаа	95.6 сек	73.8 сек
Даалгаврын биелэлт	67.1%	61.8%
Сэтгэл хөдлөл	0.04 эерэг	0.21 эерэг
Ганцаарчилсан ярилцлага	45% эерэг	65% эерэг

*Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулснаар*

### Нейро судалгааны ерөнхий дүгнэлт

Судалгааны даалгаврыг сонгоходоо Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нээлттэй болгохоор заасан мэдээллүүдээс үнэлгээний үр дүнгээр хамгийн сайн үнэлэгдсэн цахим хуудас хоёуланд нь байгаа мэдээллийг сонгосон хэдий ч компанийн хувь эзэмшлийн болон шилэн данс дахь мэдээллийг хайж олоход хүндрэлтэй байна.

Цахим хуудсан дахь мэдээллийг үндсэн болон дэд цэсэнд агуулгаар нь зөв ангилж байрлуулах нь мэдээллийг хайж олоход чухал нөлөөтэй байна.

Шилэн дансны цахим хуудас нь удаан бөгөөд судалгаанд оролцогчид хаанаас нь ямар мэдээллийг, хэрхэн нээж үзэх ёстойг шууд хараад ойлгохгүй, олон дахин оролдож үзсэн ч хайсан мэдээллээ олж нээж үзэх чадахгүй, мөн сэтгэл хөдлөлийн шинжилгээгээр сөрөг үзүүлэлттэй байгаа нь шилэн дансны цахим хуудас хэрэглэхэд тохиромжгүй байгааг харуулж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нээлттэй болгохоор заасан мэдээллийг аливаа файл дотроос олохоор бус, цэсээр дамжин цахим хуудсанд шууд үзэх боломжтой байдлаар байршуулах нь тохиромжтой байна.

#### 4.4 Үнэлгээний үр дүнд хийсэн анализ

1. ТОП-100 аж ахуйн нэгжид багтсан компаниудын хувьд мэдээллийн ил тод байдал нь бусад компаниудаас илүү сайн байх ёстой хэмээн судлаачдын хувьд таамаглаж байсан боловч журмын хэрэгжилтийн үнэлгээгээр эхний 10-т эрэмблэгдсэн компаниудын 5 нь буюу хагас нь ТОП 100-д багтдаггүй компаниуд орсон байна. Өөрөөр хэлбэл ТОП 100 аж ахуйн нэгжид багтсан ТӨК нь хэдийгээр эдийн засаг, татвар төлөлт зэргээрээ шилдэг үзүүлэлтийг илэрхийлж байгаа ч энэ хэрээрээ үйл ажиллагаагаа ил тод байлгах, мэдээллээ нийтлэх хуулийн шаардлагыг хангалттай түвшинд хангаж чадахгүй байна.
2. Судалгааны бас нэгэн объект болох АЗЗА-ын хувьд ТОП-100 ААН-д багтсан компаниудтай харьцуулахад үйл ажиллагааны хүрээ бага, орон тоо цөөн, эдийн засгийн ач холбогдол багатай зэрэг хүчин зүйлүүдийг тооцон үзвэл мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийн шаардлагыг хангах байдал нь хангалтгүй байж болзошгүй хэмээн таамаглаж байсан ч хууль журмын хэрэгжилтийн хувьд жижиг, том, эдийн засгийн үр нөлөө зэргээс үл хамааран бүгд хэрэгжүүлэх боломжтой буюу магадгүй нээлттэй мэдээлэх мэдээллийн төрлийг үйл ажиллагааны онцлогтой нийцүүлэн ялгаатай байдлаар зохицуулсан бол биелэлтийн хувь ТОП 100 аж ахуйн нэгжээс ч өндөр хувьтай гарч болзошгүй байна.
3. Журмын үнэлгээний эрэмбээр Эрдэнэс Монгол (32), Багануур (29), Тавантолгой (24) зэрэг эдийн засгийн гол салбар болох уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд нь доогуур үнэлэгдсэн байдал ажиглагдаж буй бөгөөд улс орны эдийн засаг, татвар бүрдүүлэлтэд гол үүрэг гүйцэтгэж буй болон сүүлийн үед гарч буй дуулиант хэргүүдтэй нэр нь холбогдож байдаг энэ салбарын компаниудын хувьд мэдээллийнхээ ил тод байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэхийг онцгойлон анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна.
4. Мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийн байдалд орон нутгийн компаниудын хувьд буюу АЗЗА нарын хувьд орон зайн байршил, төвөөс алслагдсан байдал зэрэг хүчин зүйл нөлөөлж магадгүй гэсэн таамаглалыг дэвшүүлсэн боловч судалгааны үр дүнгээс харвал орон зай, алслагдсан байдлаас үл хамааран хуулийн хэрэгжилтийг адил тэгш хангуулах боломжтой, байрлал нөлөөгүй болох нь Төв АЗЗА-8, Дорноговь АЗЗА-10, Багануур АЗЗА-34, Налайх АЗЗА-35 зэргээр эрэмблэгдсэн байдлаас харагдаж байна.
5. Судалгааны объектэд 6 нээлттэй компани багтсан бөгөөд нээлттэй компанид тавигддаг хууль журам, зохицуулах байгууллагын нарийвчилсан шаардлагын хүрээнд мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт нь харьцангуй сайн байх ёстой хэмээн таамаглал дэвшүүлсэн боловч журмын үнэлгээгээр Монголын Хөрөнгийн Бирж-4, Үндэсний Давхар даатгал-5, Шивээ овоо-13, Монгол Шуудан-20, Таван Толгой-24, Багануур-29, Монголын Цахилгаан Холбоо-33 дугаар эрэмбэд тус тус үнэлэгдсэнээс харвал нээлттэй компаниудын ил тод байдал нь хаалттай компаниас өндөр байж чадахгүй байгааг илтгэж байна. 4 болон 5-д эрэмблэгдсэн компаниудын хувьд 2022 оны 11, 12 саруудад нээлттэй ХК болсон бөгөөд нээлттэй болохын тулд шаардагдах мэдээллийн шаардлагыг урьдчилан хангасантай холбоотой байж болзошгүй байна.



6. Хууль журмын хэрэгжилтийн үнэлгээний хувьд компанийн том, жижиг, төв болон алслагдсан, нээлттэй, хаалттай байдал зэрэг нь нөлөөлөл багатай болох нь судалгааны үр дүнгээс гарч байгаа ч эсрэгээрээ цахим хуудасны хэрэглэгчдэд ашиглагдахуйц байдал, хэрэглээнд нийцсэн байдлын хувьд дээрх нөхцөл байдлууд нь нөлөөтэй буюу олон улсын Rutger судалгааны аргаар эхний 15 дотор эрэмблэгдсэн компаниудын дотор орон нутгийн АЗЗА компаниуд багтаагүй байгаагаас харж болохоор байна.
7. Олон улсын Rutger судалгааны аргачлалын үнэлгээгээр хамгийн сайн үнэлгээ авсан МИАТ ТӨХК-ийн цахим хуудас нейро судалгааны дүнгээр зөвхөн даалгаврын биелэлтийн хувьд л МТЗ ТӨХК-иас бага зэрэг илүү байснаас өөрөөр илүү сайн үнэлгээтэй байж чадаагүй. Энэ нь олон улсын аргачлалын үнэлгээнд илүү оноо авахад нөлөөлсөн хувийн нууцлалын дүрэм журамтай, хэрэглэгчтэй харилцах боломж бүрдүүлсэн зэрэг хүчин зүйл нь нейро судалгаанд нөлөө үзүүлээгүйтэй холбоотой. Мөн оролцогчтой хийсэн ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээр МИАТ ТӨХК-ийн цахим хуудасны бүтэц ойлгомжгүй, компанийн тухай болон ил тод байдал цэснүүд нь тасалбар захиалах зэрэг үйлчилгээний цэсүүдтэй холилдсон байсан гэж үзсэн нь тус цахим хуудас хэрэглэхэд тийм ч тохиромжтой бус болохыг харуулж байна.

## ДУГНЭЛТ

- Монгол Улсын хувьд IRIM судалгааны хүрээлэн болон дотоодын судлаачдын бүтээл нь Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй ХК болон зарим салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалын түвшин, төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдалд хийгдсэн судалгаанууд байна. Судалгааны ажлуудын үр дүн Монгол Улс дахь тэдгээрийн засаглалын үнэлгээ 60 хувиас хэтрэхгүй гарсан нь хангалтгүй, төрийн байгууллын цахим ил тод байдлын индекс 54.9 хувь гарсан нь сул үзүүлэлт байна.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, журмыг баталж, хэрэгжүүлж эхэлсэн нь иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хэрэгжүүлэх нөгөө талаас төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар, төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох хууль эрх зүйн суурь тавигдсан байна.
- Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, журмын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын цахим хуудаснаас иргэдийн мэдээлэл авах боломж хэр бүрдсэн байгааг судалсан судалгаа хараахан хийгдэж нийтэд мэдээлээгүй тул шинэлэг судалгаа болсон бөгөөд үнэлгээнд хамрагдсан компаниуд бүгд цахим хуудастай, “ил тод байдал” гэсэн цэс үүсгэсэн нь хууль, журмын хэрэгжилт эхэлсэн байна гэж дүгнэж байна.
- Салбарын өнөөгийн байдлын хувьд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг хэрэгжүүлэгчийн мэдээлэл, төрийн эзэмшлийн хувь эзэмшлийн мэдээлэл, эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд гүйцэтгэх захирал, иргэнээр бүртгэгдсэн эсхүл мэдээлэл тодорхойгүй байгаа нь тэдгээр компанийн эрх барих дээд байгууллагын мэдээллийн ил тод байдал хангалтгүй байгааг харуулж байна.
- Мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон журам нь мэдээлэл хариуцагчид нийтэд ил тод хүргэх хамгийн наад захын шалгуурыг тавьж байгаа гэж үзвэл үнэлгээнд хамрагдаж буй компаниуд дундаж үнэлгээ 31.37%, 2023 онд нээлттэй ХК болох жагсаалтад орсон компаниудын дундаж үнэлгээ 25.75% гарсан нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын цахим хуудас дахь мэдээллийн ил тод байдал хангалтгүй, иргэдийн мэдэх эрх хангагдахгүй, олон нийтийн хяналт хийх боломж хараахан бүрдээгүй байгаа нь нейро судалгааны үр дүнгээр ч батлагдаж байна.
- Олон улсын үнэлгээний аргачлал нь цахим хуудас дахь хувийн мэдээллийн аюулгүй байдал, мэдэгдэл, иргэд мэдээлэл авах боломжоор хангагдсан байдал, цахим хуудас дахь мэдээллийн агуулга, хүртээмжийн байдлыг үнэлдэг бөгөөд үнэлгээнд хамрагдсан компаниудын дундаж үнэлгээ 18.1% гарсан нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын цахим хуудас дахь

мэдээллийн ил тод байдал хангалтгүй, иргэд мэдээлэл авах боломж, нөхцөлөөр хангагдахгүй байгааг илэрхийлж байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

- Нээлттэй хувьцаат компани нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол болон хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, өөрчлөлт болон компанийн засаглалтай холбоотой мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид тухай бүр хүргүүлж ажиллахын зэрэгцээ төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар, төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээд нь Нийтийн мэдээллийн тухай хуульд заасан нээлттэй, ил тод мэдээлэх мэдээллийг цахим хуудастаа байршуулж ажиллах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, нийгэд сурталчлах ажлыг зохион байгуулах хэрэгтэй гэж үзэж байна.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд нь нээлттэй мэдээллийн агуулгын чанар, мэдээлэл авагчийн хэрэгцээг хангах байдалд анхаарч, цахим хуудаст мэдээллийг ил тод, ойлгомжтой байдлаар цаг тухай бүрт байршуулах, хайлтын цонх бий болгох, мэдээллийг ойлгомжтой, түргэн шуурхай олж авах нөхцөлийг бүрдүүлж, хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах зүйтэй байна.
- Мэдээлэл хариуцагч нь өөрийн цахим хуудсанд шилэн дансны цахим хуудсыг холбоогүй байдал ихэнх компаниуд дээр ажиглагдсан тул мэдээлэл хариуцагчийн цахим хуудсыг шилэн дансны цахим хуудастай холбох, шилэн дансны цахим хуудасны өмнөх онуудын мэдээллийг оруулах, үүнтэй холбоотойгоор төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулж ажиллах хэрэгтэй байна.
- Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн журмын үнэлгээг гүйцэтгэхэд нээлттэй мэдээлэл тус бүрд 4 төрлийн шалгуур үзүүлэлт тавьсан нь хууль тогтоомжид заасан хугацаатай мэдээллээс бусад мэдээллийн хувьд хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг үнэлэхэд хүндрэлтэй байсан тул хууль, журмын шалгуурыг нарийвчилж оруулах нь чухал байна.
- Мэдээлэл хариуцагчийн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээс хамаараад тухайлбал АЗЗА-ын хувьд нийгэд хүргэх мэдээллийг ялгаатай байдлаар журамлаж оруулах нь мэдээлэл хариуцагчийн зүгээс бүрэн бүтэн, чанартай мэдээлэл оруулах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзлээ.
- Үнэлгээнд хамрагдсан компаниуд нь үйл ажиллагааны чиглэл, цар хүрээнээс хамаарч харилцан ялгаатай, зарим нь үндэсний хэмжээний том компани, зарим нь орон нутгийн жижиг компани байгаа бөгөөд тэдгээрийг ялангуяа стратеги, хүний нөөцийн ижил шалгуураар үнэлж, харьцуулах нь тохиромжгүй байна.
- Журамд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжүүлсэн үр дүн, арга хэмжээний хөтөлбөр, шалтгааны тайлбар, нэгдсэн үзүүлэлт, явц, үр дүн, хэрэгжилт, нээлттэй

байхаар заасан бусад мэдээлэл гэх мэт олон төрлийн нэр томъёо ашигласан нь тодорхойгүй байдал үүсгэж байгаа тул нэр томъёог нэг ижил болгох нь зүйтэй гэж үзэж байна.

- Төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар, төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, журмыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад даалгах, хууль, журмыг олон нийтэд таниулж хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангаж ажиллахыг зөвлөж байна.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийн агуулга, чанарт анхаарах, ойлгомжтой байдлаар цахим хуудсанд ил тод, нээлттэй, цаг хугацаа тухай бүрт байршуулах нөхцөлийг бүрдүүлж төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж ажиллах нь зүйтэй байна.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэлбэрийг нээлттэй болгох замаар өөрчлөн байгуулагдах АЗЗА хуулийн этгээд хамгийн эхэнд нээлттэй мэдээллийг цахим хуудастаа байршуулж хууль, журмын хэрэгжилтийг хангаж, компанийн засаглалыг сайжруулж ажиллахыг зөвлөж байна.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээлэл болон Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлэл давхардаж байгаа тул цаашид давхардсан мэдээллийг хэрхэн оруулах талаар тодорхой чиглэл гаргаж, мэдээллээр хангаж ажиллах нь зүйтэй байна.

## НОМЗҮЙ

### Монгол хэл дээрх:

- Авлигатай Тэмцэх Газар. (2021). *Төрийн байгууллагын албан ёсны цахим хуудсанд 2021 онд үнэлгээ хийсэн танилцуулга*. Retrieved from <https://iaac.mn/post/104453>
- Байлхүү, Д. (2015). *Төрийн өмчит эрчим хүчний компаниудын засаглалын үнэлгээ*. ЭХЯ. Нээлттэй Нийгэм Форум. Улаанбаатар. Монгол
- Баясгалан, Н. (2018). Төрийн өмчийн компаниудын мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг үнэлэх нь. *СЭЗИС-Бүтээлийн сан, Мастерын зэрэг горилсон дипломын ажил*. Retrieved from <http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/handle/8524/959>
- Бүжин, А. (2011). Монгол Улсад компанийн засаглалыг нэвтрүүлэх нь. *Бизнесийн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл*. МУИС.
- Монгол Улсын Засгийн Газар. (2011). *Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/5481/2/202857>
- Монгол Улсын Засгийн Газар. (2022). *Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531445101831>
- Монгол Улсын Их Хурал. (2011). *Компанийн тухай хууль*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/310>
- Монгол Улсын Их Хурал. (2020). *Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/15406>
- Монгол Улсын Их Хурал. (2021). *Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/310>
- Нарантулга, Б. Оюун-Эрдэнэ, П. нар (2020). *Төрийн өмчит аж ахуйн нэгжийн эдийн засагт гүйцэтгэх үүргийн шинжилгээ. Удирдлагын академийн судалгааны тайлан, 026*. Улаанбаатар. Монгол: Мөнхийн үсэг ХХК.
- Насанжаргал, С. нар (2019). Хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдлыг үнэлэх нь. *СЭЗИС-Бүтээлийн сан, Мастерын зэрэг горилсон дипломын ажил*. Retrieved from <http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/handle/8524/1992>
- Санхүүгийн зохицуулах хороо, & Компанийн засаглалын Үндэсний зөвлөл. (2015). *Монгол Улсын компанийн засаглалын үндэсний тайлан 2015*. Улаанбаатар.
- Санхүүгийн Зохицуулах Хороо. (2022). *Компанийн засаглалын кодекс*. Retrieved from <http://www.frc.mn/d/gc/8426>
- Стандарт, Хэмжил зүйн Газар. (2017). *Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага*. MNS 6285:2017. Available at <https://estandard.gov.mn/standard/reader/4411>

- Цахим Хөгжил Харилцаа Холбооны Яам. (2022). “Цахим Үндэстэн” Баримтлах чиглэл (2022-2027). Retrieved from [A24-20220518-Цахим-үндэстэн-баримтлах-чиглэл-батлах-тухай\\_1658190818-1-1.pdf](https://mddc.gov.mn/A24-20220518-Цахим-үндэстэн-баримтлах-чиглэл-батлах-тухай_1658190818-1-1.pdf) (mddc.gov.mn)
- Цэнд-Аюуш, Т. (2011). *Монголын компанийн засаглалын нээлттэй байллын индексийн шинжилгээ*. Улаанбаатар. Монгол
- Цэнд-Аюуш, Т. (2012). Монголын Компанийн засаглалыг сайжруулах арга замууд. *Бизнесийн удирдлагын ухааны докторын зэрэг горилсон бүтээл, МУИС*.
- Цэцэгдарь, М., Гангаажав, Ж. (2019) Аялал жуулчлалын компанийн вэбсайтад хэрэглэхэд тохиромжтой байдлын үнэлгээ хийх нь (нүдний хөдөлгөөн дагах төхөөрөмж/ нейромакетинг, СЭЗИС-Бүтээлийн сан, Мастерын зэрэг горилсон дипломын ажил. Retrieved from <http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/handle/8524/1605>
- Шуурав, Я. (2017). *Төрийн өмчит хувьцаат компанийн засаглал төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлөх нь*. Удирдлагын академи. Судалгааны ажил. Улаанбаатар
- Энхбаяр, Н. (2018). Монголын арилжааны банкнуудын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг үнэлэх нь. *СЭЗИС-Бүтээлийн сан, Мастерын зэрэг горилсон дипломын ажил*. Retrieved from <http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/handle/8524/925>

#### Англи хэл дээрх:

- Adina, P., Victoria, B. (2009). Transparency and disclosure between theory and practice. A case study of Romania. Cit.3/2/2023. Available at. [https://www.researchgate.net/publication/245040984\\_A\\_review\\_of\\_the\\_empirical\\_disclosure\\_literature](https://www.researchgate.net/publication/245040984_A_review_of_the_empirical_disclosure_literature)
- Development Bank of Latin America. (2021). Guidelines for Good Corporate Governance of State-Owned Enterprises. *Public Policy and Productive Transformation series №37*
- Holzer, M., Manoharan, A. (2019). *Digital Governance in Municipalities Worldwide (2015-16)*. Retrieved from [https://www.researchgate.net/publication/334558153\\_Digital\\_Governance\\_in\\_Municipalities\\_Worldwide\\_2015-16](https://www.researchgate.net/publication/334558153_Digital_Governance_in_Municipalities_Worldwide_2015-16)
- Holzer, M., Melitski, J. & Manoharan, A. (2021). Digital Governance: An Assessment of Performance and Best Practices, *Public Organization Review*. Retrieved from <https://doi.org/10.1007/s11115-021-00584-8>
- IRIM судалгааны хүрээлэн. (2021). *Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс 2021: Мониторингийн тайлан*. Retrieved from <https://www.irim.mn/web-monitoring>
- Mark, F. (2015). Transparency in Search of a Theory. *European Journal of Social Theory* 2015, Vol. 18(2) p.150-167
- Michael, P. Andrés, O. & Guillermo, G. (2015) Transparency in the Corporate Governance of State-Owned Enterprises in Latin America, *Public Policy and Productive*

- Transformation Series N°20/2015.* Retrieved from <https://scioteca.caf.com/handle/123456789/845?show=full>
- Paul, M., Krishna, G. (2000). A review of the Empirical Disclosure Literature prepared for the 2000 JAE Conference Cit.2/26/2023. Available at. [https://www.researchgate.net/publication/245040984\\_A\\_review\\_of\\_the\\_empirical\\_disclosure\\_literature](https://www.researchgate.net/publication/245040984_A_review_of_the_empirical_disclosure_literature)
- PwC. (2015). *State-Owned Enterprises: Catalysts for public value creation?*. Cit.03/28/2023. Retrieved from <https://www.pwc.com/gr/en/publications/assets/state-owned-enterprises-catalysts-for-public-value-creation.pdf>
- Sauro, J. (2016). Measuring the Quality of the Website User Experience. *Electronic Theses and Dissertations. 1166*. Retrieved from <https://digitalcommons.du.edu/etd/1166>
- Sorin, N., Monica-Violeta, A. (2013). Theories of Corporate Governance. *Economic Series Vol 23 Issue 1/2013*, p.117-128
- Talat, A., Mian, S. (2014). Theoretical Perspective of Corporate Governance: A Review. *European Journal of Scientific Research. Vol.119* p.255-264
- The World Bank. *State-Owned Enterprises: Understanding their market effects and the need for competitive neutrality.* Cit.02/04/2023. Available at <https://thedocs.worldbank.org/en/doc/739371594131714315-0130022020/original/15444WBSOEWEB.pdf>
- Tolossa, F. (2021). The Impact of corporate governance measures on firm performance: the influences of managerial overconfidence. *Guluma Futur Business Journal 2021*, 7(1):50
- UNESCAP. (2008). *What is Good Governance?* Cit.03/24/2023. Available at <https://www.unescap.org/sites/default/files/good-governance.pdf>
- United Nations. Department of Economic and Social Affairs. (2022). *E-Government Survey 2022 The Future of Digital Government.* Retrieved from <https://publicadministration.un.org/egovkb/en-us/Reports/UN-E-Government-Survey-2022>
- William, A., & Thomas S. (2023). *Measuring the user experience. 3rd edition.* USA: Elsevier, Inc.
- World Bank Group. (2014). *Corporate Governance of State-Owned Enterprises:A Toolkit.* Retrieved from <http://hdl.handle.net/10986/20390>

## ХАВСРАЛТ

### Хавсралт 1. Хуучин болон шинэ хуулийн мэдээллийн харьцуулалт

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр		НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр	
7-р зүйл	Үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах	8.2.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл
7.1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтэц	8.2.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;
7.1.2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь	8.2.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;
7.1.3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт	8.5.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;
7.1.4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар	8.2.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;
7.1.5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төсөл	8.6.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;
7.1.7.	Төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл		
7.1.8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	8.5.2.	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.
7.1.9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээлэл	8.4.26.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;
8-р зүйл	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	8.3.	Хүний нөөцийн талаарх мэдээлэл



8.1.1.	Сул орон тооны зар	8.3.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;
8.1.2.	Албан хаагчийн ёс зүйн дүрэм	8.3.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;
8.1.3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам	8.3.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;
8.1.4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	8.3.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;
8.1.5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	8.3.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.
		8.3.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;
9-р зүйл	Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдалтай холбогдсон харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна.	8.4.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл
10-р зүйл	Байгууллагын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдалтай холбогдсон харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна.		
<b>НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ-ийн хүрээнд нэмэгдсэн мэдээллүүд</b>			
8.2.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;		
8.2.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;		
8.2.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;		
8.2.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;		
8.2.8.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;		
8.2.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;		
8.2.10.	8.2.10.мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.		
8.4.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;		
8.4.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;		
8.4.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;		
8.4.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;		
8.4.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;		
8.4.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;		
8.4.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;		
8.4.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;		
8.4.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;		
8.4.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;		

8.4.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;
8.4.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;
8.4.13.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт;
8.4.14.	8.4.14.Засгийн газрын гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээрийн талаарх мэдээлэл;
8.4.15.	Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт;
8.4.16.	Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл;
8.4.17.	Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл;
8.4.18.	Улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;
8.4.19.	Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ;
8.4.20.	Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан;
8.4.21.	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл;
8.4.22.	Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
8.4.23.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулсан тухай бүрд хувийн хэвшлийн түншлэгч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, түншлэлийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл;
8.4.24.	Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл;
8.4.25.	Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо;
8.4.27.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;
8.5.	Үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдээлэл (энэ бүлэгт байсан 2 мэдээллийг өмнөх хуулийн харгалзах хэсэгт оруулав)
8.6.	Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:
8.6.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;
8.6.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;
8.6.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;
8.6.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;
8.6.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;
8.6.7.	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон Үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ;
8.6.8.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;
8.6.9.	Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;

8.6.10.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;
8.6.11.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;
8.6.12.	Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал;
8.6.13.	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;
8.6.14.	Шүүн таслах ажиллагааны дүн мэдээ;
8.6.15.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ;
8.6.16.	Улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл;
8.6.17.	Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, хүргүүлсэн тайлан, Монгол Улсад өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах байгууллагын талаарх мэдээлэл;
8.6.18.	Зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгайл байдлаар аж ахуй эрхлэгчийн жагсаалт;
8.6.19.	Хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;
8.6.20.	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;
8.6.21.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;

## Хавсралт 2. Нээлттэй компанид тавигдаж буй мэдээллийн харьцуулалт

№	Нийтийн мэдээллийн ил тод байдлын журмын шалгуур	Нээлттэй ХК болоход тавигдах хууль болон зохицуулагч байгууллагын мэдээллийн шалгуур	Нээлттэй ХК-ийн мэдээлэл
1	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	<p>ҮЦЗЗТХ 10.5.4. МХБ - ҮЦБЖ 4.3.4. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, гэдгээрийн өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;</p> <p>ҮЦЗЗТХ 10.5.1. МХБ - ҮЦБЖ 4.3.1 Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа, хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх тухай мэдээлэл</p> <p>ҮЦЗЗТХ 10.5.1, МХБ - ҮЦБЖ 4.3.2. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр</p>	<p>ҮЦГОНХМЖ 8.1. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад Компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлтүүд, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой өөрчлөлт орсон мэдээллийг тухайн өдрөөс хойш 1 хоногт багтаан биржид ирүүлж, нийтэд мэдээлнэ.</p>
2	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	-	<p>ҮЦЗЗДМЖтМЖ 2.1.4. Үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд Хорооноос болон эрх бүхий байгууллагаас хийсэн шалгалтын тайлан, бусад материалд орсон нийтэд тараагдаагүй мэдээ баримт</p> <p>ҮЦГОНХМЖ 7.1, 7.4 Үнэт цаас гаргагч нь санхүү, үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг жил, хагас жилийн үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг ирүүлнэ.</p> <p>ҮЦЗЗтХ 20.1.7. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг СЗХ-оос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлнэ.</p>
3	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	-	-
4	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	-	-
5	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	-	-
6	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар,	ҮЦЗЗТХ 10.5.4. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, гэдгээрийн өмчлөл дэх хувьцааны	-

	албаны цахим шуудангийн хаяг	тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл	
7	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	-	-
8	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	МХБ - ҮЦБЖ 4.3.9. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл	ҮЦГОНХМЖ 8.3.6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурийн талаарх мэдээлэл, түүнд орсон өөрчлөлт
9	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	-	-
10	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	-	ҮЦГОНХМЖ 8.3.12. Дараа жилийн үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөө, төсвийн талаарх мэдээлэл
11	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	-	ҮЦГОНХМЖ 7.2. Үнэт цаас гаргагч Санхүүгийн тайлангналын олон улсын стандарт /IFRS/-д нийцүүлэн үнэн зөв гаргаж жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг дараа сарын 20-ны дотор Биржид ирүүлнэ. ҮЦЗЗТХ 20.1.7. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг СЗХ-оос тогтоосон журмын дагуу нийгэд мэдээлнэ.
12	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	ҮЦЗЗТХ 10.5.6. МХБ - ҮЦБЖ 4.3.6. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт	ҮЦЗЗТХ 20.1.6. ҮАЗХТЖ 2.2. хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх
13	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	-	ҮЦЗЗДМЖтМЖ 2.1.14.санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд нь өмнөх жилүүдийн болон ирээдүйд төлөвлөсөн тооцооноос 25 хувиас илүү хэмжээгээр өөрчлөгдөх
14	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	СЗХ - ҮЦБЖ 11.14.6, МХБ - ҮЦБЖ 2.6.6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах	ҮЦЗЗТХ 56.1.5. Үнэт цаас гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон нөхцөл байдлын талаарх мэдээлэл; ҮЦЗЗДМЖтМЖ 2.1.17. Шинэ

		үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх	нээлт хийх, патент авах, ач холбогдол бүхий тусгай зөвшөөрөл эзэмших
15	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	СЗХ - ҮЦБЖ 11.14.7, МХБ - ҮЦБЖ 2.6.7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх	-
16	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	ҮЦЗЗТХ 10.5.3. Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, тэдгээрийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ	ҮЦЗЗТХ 56.1.1. Үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон өөрчлөлт; 56.1.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтэц, түүний бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд орсон өөрчлөлт; ҮЦГОНХМЖ 8.3.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд, тэдгээрийн хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлт; ҮЦЗЗДМЖтМЖ 2.1.1. ХЭ-ийн бүртгэл (ХЭ-ийн овог нэр, түүний өмчлөлд буй хувьцааны тоо, оршин суугаа хаяг)
17	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	ҮЦЗЗТХ 10.5.5. МХБ - ҮЦБЖ 4.3.5. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, биет болон биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл	2.1.9.үнэт цаас гаргагчийн ашиг, алдагдал 25 болон түүнээс дээш хувиар өөрчлөгдөх; 2.1.21.үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны өмчлөлд байгаа хувьцааны багцад 5-аас дээш хувиар өөрчлөлт орсон мэдээлэл.
18	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	СЗХ - ҮЦБЖ 1.14.2, МХБ - ҮЦБЖ 2.6.2. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал болон эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж байгаа эсэх	ҮЦЗЗДМЖтМЖ 2.1.19.үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч этгээдийн бүтцэд орсон өөрчлөлтүүд

19	-	СЗХ - ҮЦБЖ 11.14.5, МХБ - ҮЦБЖ 2.6.5. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх	ҮАЗХТЖ 4.2. ХК-ийн их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэлд үндэслэн уг хэлцлийг хуульд нийцүүлэн эрх бүхий удирдах байгууллагын хурлаар шийдвэрлэсэн эсэх, энэ хэлцлийг хийсэнтэй холбогдон компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварт мэдэгдэхүйц өөрчлөлт орсон бол энэ талаар зээлдүүлэгчдэд мэдэгдсэн эсэх; ҮЦГОНХМЖ 8.3.10. Үнэт цаас гаргагч нь их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн тохиолдолд тухайн мэдээлэл.
20	-	СЗХ - ҮЦБЖ 11.14.4, МХБ - ҮЦБЖ 2.6.4. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх	ҮЦГОНХМЖ 8.3.8. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл (лиценз), бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ, хэлцлийг цуцлах, дуусгавар болгосон талаарх мэдээлэл.
21	-	СЗХ - ҮЦБЖ 11.14.10, МХБ - ҮЦБЖ 2.6.9. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх	ҮЦЗЗДМЖтМЖ 2.1.22. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг нь зогсоохоор нэхэмжлэл гаргасан, түүний эрх бүхий албан тушаалтан, хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн мэдээлэл
22	-	СЗХ - ҮЦБЖ 11.14.11, МХБ - ҮЦБЖ 2.6.9. Үнэт цаас гаргагч татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх	
